

Фалунь Гон

(Монгол орчуулга)

Ли Хонжи

ДАФА

(Лун Юй) 1

Дафа² бол Бүтээгчийн билгүүн ухаан билээ. Энэ бол тэнгэр газар бүтсэн, орчлон ертөнц бий болсон суурь. Энэ нь хамгийн бичлийн туйлаас аугаа уудмын туйл хүртэлх бүхнийг багтаасан ба сансрын биетийн орших түвшин бүрт өөр өөрөөр илэрдэг. Сансрын биетийн гүнээс хамгийн бичил бие бодиуд анх үүсч тоо томшгүй бие бодиуд давхаргаас давхаргад, жижгээс том руу үелэн өссөөр хүн төрөлхтөний мэдэх гадаргуйн давхаргын атом, молекул, од гаригс, галактик болон түүнээс ч том хэмжээнд хүрдэг. Янз бүрийн хэмжээт бие бодиос янз бүрийн хэмжээт амь бодь болон уудам сансрын биет даяар тархан орших янз бүрийн хэмжээт хорвоо ертөнц бүтдэг. Өөр өөр давхаргын бие бодь дээр орших амь бодийн хувьд дараахь арай том давхаргын бие бодь нь тэдний тэнгэрт орших од гаригс нь болдог, давхарга болгоны хувьд ийм байдаг. Орчлон ертөнцийн аль ч давхарга дахь амь бодийн хувьд энэ бол хязгааргүй. Цаг хугацаа, орон зай, амь бодийн үй түмэн хэлбэр, төрөл зүйлийг мөн Дафа бүтээсэн, оршин байгаа аливаа зүйл бүгд түүнд багтана, үүнээс гадуур үлдэх зүйл гэж үгүй. Энэ бол Дафа-гийн Жэнь, Шань, Рэн³ мөн чанарын өөр өөр давхарга дахь бодит илрэл юм.

Хүн төрөлхтөний орчлон ертөнц ба амь бодийг судлах арга хэдий хөгжсөн ч зөвхөн доод давхаргын орчлон ертөнц болох хүмүүний орших энэ орон зайн хэсгийг л судалдаг. Өнө эртний хүн төрөлхтөний бий болгосон олон соёл иргэншлийн үед өөр од гаригсыг судалж байсан. Гэвч хэдий

¹ Лун Юй- Оршил.

² Дафа-Аугаа Ном

³ Жэнь, Шань, Рэн - Үнэн, Нинжин, Тэвчээр

өндөрт нисч, хэр хол явсан ч хүмүүний орших энэхүү орон зайнаас гарч чадаагүй. Хүн төрөлхтөн хэзээ ч орчлон ертөнцийн үнэн илрэлийг жинхэнэ танин мэдэх боломжгүй. Хэрэв хүн төрөлхтөн орчлон ертөнц, цаг хугацааны орон зай болон хүний биеийн нууцыг тайлъя гэвэл Ариун номоор бясалгаж гэгээрэх, амь бодийн түвшнээ дээшлүүлэх нь цорын ганц л зам юм. Бясалгалын явцад бас ёс суртахуун дээшилдэг, жинхэнэ нинжин ба харгис, сайн ба мууг ялгаж чаддаг болоход, хүн төрөлхтөний энэ давхаргаас гарахад орчлон ертөнцийн үнэн бодит байдал болон өөр өөр түвшний, өөр өөр орон зайн амь бодийг харж, бас харилцаж чаддаг болно.

Хүн төрөлхтөний судалгаа шинжилгээ нь амьдралын нөхцөлийг сайжруулах нэрийн доор явагдах технологийн өрсөлдөөн бөгөөд энэ нь ихэнх тохиолдолд бурханыг үгүйсгэж, хүн төрөлхтөн өөрийгөө зөв барьж байх ёс суртахуунаа алдах нөхцөл нь болдог. Ийнхүү өнө эртний хүмүүний соёл иргэншил олон удаа устгагдаж байсан. Хүн төрөлхтөний судалгаа шинжилгээ нь зөвхөн энэ материаллаг ертөнцөд хязгаарлагддаг, арга нь зөвхөн тухайн зүйлийг таньж мэдсэний дараа судалдаг замаар явагддаг. Хүмүүс Бурханыг үгүйсгэдгээс болж энэ орон зайд харагдахгүй, мэдрэхүйд өртөхгүй боловч бодитоор оршдог, хүн төрөлхтөний бодит амьдралд илэрч байдаг сүнслэг үзэл, сүсэг бишрэл, бурханлаг үг, ид шид гэх мэт зүйлийг хөндөж зүрхэлдэггүй.

Хэрэв хүн төрөлхтөн ёс суртхуундаа суурилан өөрийн зан үйлдэл, үзэл бодлоо сайжруулж чадвал хүний нийгмийн энэ соёл иргэншил урт удаан хугацаанд оршин тогтнож болох бөгөөд бурханы ид шид хүмүүний нийгэмд дахин илэрнэ. Урьд өмнө хагас бурханлаг, хагас хүмүүнлэг соёл иргэншил хүн төрөлхтөний нийгэмд удаа дараа оршиж

байсан нь хүн төрөлхтөний амь бодь, орчлон ертөнцийн талаархи танин мэдэхүйг дээшлүүлж байсан. Энэ дэлхийд дэлгэрч буй Дафа-д хүн төрөлхтөн зохих дээдлэл хүндлэлтэй хандвал тэр хүмүүс, тэр үндэстэн эсвэл улс орон аз жаргал, алдар хүндийг хүртэх болно. Сансрын биет, орчлон ертөнц, амь бодь бүхий л зүйлсийг орчлон ертөнцийн Дафа бүтээсэн. Дафа-гаас эсрэг болсон амь бол жинхэнэ муудсан амь. Дафа-д нийцсэн аливаа хүн жинхэнэ сайн хүн, түүнд сайн хариу, урт нас, удаан жаргал ирнэ. Дафа-д уусч чадсан бясалгагч бол гэгээрэгч - Бурхан.

Ли Хонжи
2015 оны 5 сарын 24

ГАРЧИГ

Нэгдүгээр бүлэг. Өмнөх үг	1
1. Чигоны эх сурвалж	2
2. Чий ба Гон	4
3. Гон хүч ба Ер бусын чадвар	5
4. Тэнгэрийн мэлмий	10
5. Чигон эмчилгээ ба эмнэлгийн эмчилгээ	17
6. Буддын системийн Чигон ба Буддын шашин	20
7. Ариун номын бясалгал ба буг чөтгөрийн зам	24
Хоёрдугаар бүлэг. Фалунь Гон	30
1. Фалуний үйл ажиллагаа	30
2. Фалуний бүтэц	32
3. Фалунь Гон бясалгалын онцлог	33
4. Амь бие, сэтгэлийн хос бясалгал	38
5. Бодлын үйл	42
6. Фалунь Гон бясалгалын түвшин	44
Гуравдугаар бүлэг. Зан чанарын бясалгал	48
1. Зан чанарын агуулга	48
2. Алдах ба Олох	50
3. Жэнь, Шань, Рэн (Үнэн, Нинжин, Тэвчээр)-ийг зэрэг бясалгах	54
4. Атаархах сэтгэлийг арилгах	55
5. Зууралдсан сэтгэлийг арилгах	58
6. Нүгэл	60
7. Буг чөтгөрийн үймүүлэл	66
8. Төрөлхийн суурь ба Гэгээлэг чанар	68
9. Цэвэр, ариун сэтгэл	71

Дөрөвдүгээр бүлэг. Фалунь Гон бясалгалын систем	74
1. Буддын мянган гарын сунналт	75
2. Фалунь багана зогсолт	84
3. Сансрын хоёр туйлыг нэвтрэх	89
4. Фалунь тэнгэрийн эргүүлэг	94
5. Ер бусын чадварыг эрчимжүүлэх	99
Фалунь Гон бясалгалд тавигдах үндсэн шаардлага ба анхаарах зүйлс	107
Тавдугаар бүлэг. Асуулт ба Хариулт.....	110
1. Фалунь ба Фалунь Гон	110
2. Дасгалын зарчим ба Арга	115
3. Зан чанараа бясалгах	138
4. Тэнгэрийн мэлмий	144
5. Хүнд бэрхшээл	152
6. Орон зай ба Хүн төрөлхтөн	154

Нэгдүгээр бүлэг

Өмнөх үг.

*Чигон*⁴ бол манай оронд өнө эртний үеэс уламжилж ирсэн урт удаан түүхтэй. Манай ард түмэн *чигон*-оор бусдаас амархан бясалгадаг давуу талтай. Чигон бясалгалын ариун систем болох Буддын болон Дао-гийн системийн урьд нууцаар уламжлагддаг байсан бясалгалын олон аугаа аргууд нь аль хэдийн нийтэд дэлгэрсэн. Дао системийн бясалгалын арга бол их онцгой, Буддын систем бас өөрийн гэсэн бясалгалын аргатай. Фалунь Гон⁵ бол Буддын системийн өндөр түвшинд бясалгах аугаа ном юм. Лекцийн танхимд би эхлээд та бүгдийн биеийг өндөр түвшинд бясалгахад нийцэх байдалд хүргэж засч өгнө, бас дараа нь та бүгдийн биенд Фалунь⁶ ба *чий* механизмыг суулгаж өгнө, мөн дасгалыг зааж өгнө. Үүнээс гадна миний Номын бие та нарыг хамгаална. Гэхдээ эдгээр нь бас хангалттай биш, бас гон⁷ өсгөх зорилгонд хүрч чадахгүй, мөн та бүгдэд заавал өндөр түвшинд бясалгах ёс зарчмыг мэдүүлэх ёстой. Энэ номонд өгүүлэх зүйл бол энэ л юм.

Би дээд түвшинд бясалгалыг зааж байгаа, иймээс би ямар нэг судал, ямар нэг биологийн идэвхтэй цэг, ямар нэг энергийн сувгийг⁸ ярихгүй. Би аугаа номоор бясалгахыг заана, энэ бол жинхэнэ дээд түвшин лүү бясалгадаг аугаа ном юм. Анх сонсоход магадгүй төсөөлөхөд бэрх, гэхдээ *чигон*-оор бясалгахад өөрийгөө зориулсан хүн хянуур танин мэдвээс гүн гайхамшигт далдын зүйлс үүнд агуулагддаг болохыг ойлгоно.

⁴ Чигон-хүний биеийг бясалгах тодорхой аргуудын ерөнхий нэр

⁵ Фалунь Гон- бас Фалунь Дафа гэж нэрлэгддэг

⁶ Фалунь- Номын хүрд

⁷ Гон- “бясалгалын энерги”.

⁸ энергийн суваг- *чий* дамжуулах энергийн сүлжээ судлууд. Хятадын уламжлалт ухаан ба эмчилгээнд энэ судалд *чий* чөлөөтэй гүйхгүй болоход өвчин үүсдэг гэж үздэг

1. Чигон-ы эх сурвалж

Бидний одоо ярьж байгаа *чигон*-ыг үнэндээ *чигон* гэдэггүй. Энэ нь ганцаар бясалгадаг байсан эртний Хятад хүмүүсээс болон шашинаас гаралтай. Үрлийн ном, Бумбын жаяг, Гурван судар номнуудаас хайхад *чигон* гэсэн үг байхгүй. Энэ нь өнөөгийн хүн төрөлхтний соёл иргэншил ийм хэмжээнд хүртэл хөгжих явцдаа шашны анх үүсч байсан үеийг дамжиж өнгөрсөн. Шашин үүсэхээс өмнө *чигон* байсан. Шашин үүссэний дараа энэ нь шашины өнгө аястай болсон, урьд Буддын бясалгалын аугаа ном, Бумбын бясалгалын аугаа ном, мөн Есөн удаа эргэх алтан үрлийн увьдас, Архадын⁹ ном, Очир номлол гэх мэтээр нэрлэгддэг байсан. Бид одоо үүнийг өнөөдрийн орчин үеийн хүмүүсийн үзэл бодолд нийцүүлэхийн тулд, нийгэмд амархан дэлгэрүүлэхийн тулд *чигон* гэж нэрлэсэн. Үнэндээ Хятадад байгаа энэ зүйлийн үндсэн зорилго бол хүний биеийг бясалгахад оршино.

Чигон нь бидний энэ удаагийн хүн төрөлхтний бий болгосон зүйл биш, энэ бол маш эртний түүхтэй, тэгвэл *чигон* хэзээ үүссэн бэ? Зарим хүн *чигон*-ыг гурван мянган жилийн түүхтэй гэж ярьдаг, Тан¹⁰ гүрний үед их дэлгэрсэн. Зарим хүн үүнийг таван мянган жилийн түүхтэй гэж ярьдаг, Хятад үндэстний соёлын түүхтэй адил. Зарим хүн археологийн олдвороос үндэслэн үүнийг долоон мянган жилийн түүхтэй гэдэг. Миний харснаар *чигон*-ыг орчин үеийн хүн төрөлхтөн бий болгосон юм биш, энэ бол түүхийн өмнөх үеийн соёл. Ер бусын чавдартай хүний харснаар бидний одоогийн амьдарч байгаа энэ орчлон

⁹ Архад-Буддын системд гэгээрлийн хутагт хүрсэн, Гурамсан ертөнцөөс давсан гэхдээ Бодьсадвагаас доод түвшинд гэгээрэгч

¹⁰ Тан гүрэн-Хятадын түүхэнд хамгийн хөгжингүй байсан үе (618-907 он)

ертөнц нь есөн удаагийн дэлбэрэлтний дараа дахин бүрэлдсэн юм. Бидний амьдарч байгаа энэ гариг олон удаа устаж байсан. Удаа болгон дэлхий шинээр бүрдсэний дараа шинэ хүн төрөлхтөн өсдөг. Одоо бидний дэлхийд орчин үеийн соёлоос давсан олон зүйлсийг олж илрүүлсэн. Дарвины хувьслын онолоор бол хүн сармагчнаас хувирч ирсэн гэвэл арван мянган жилээс хэтрээгүй. Гэхдээ археологийн олдвороос олж мэдсэнээр Европын Альпийн уулсын агуйд 250 мянган жилийн өмнөх үеийн хадан дээрхи зураг байсан, тэр нь урлагийн маш өндөр түвшинд хүрсэн үнэ цэнт зүйл, орчин үеийн хүний чадвараас хавьгүй хол давсан юм. Перу улсын их сургуулийн музейд дуран авай бариад од гаригсыг ажиглаж байгаа хүний дүрс сийлэгдсэн том чулуу байдаг. Энэ дүрс нь гучин мянга гаруй жилийн түүхтэй. Та нар Галилеог 1609 онд 30 дахин өсгөлттэй одон орны дуранг зохион бүтээснийг мэднэ, өнөөг хүртэл 300 гаруй жил л болж байна. Тэгвэл 30,000 жилийн өмнө яаж дуран авай байх юм бэ? Энэтхэгт нэг төмөр багана байдаг, үүний төмрийн найрлага нь 99% гаруй. Одоогийн төмөр хайлуулдаг технологи нь ийм өндөр зэрэглэлийн цэвэр төмрийг боловсруулж гаргаж чадахгүй, энэ нь аль хэдийн орчин үеийн технологийн түвшнөөс хол давсан. Хэн эдгээр соёл иргэншлийг бий болгосон бэ? Хүн төрөлхтөн тэр үед магадгүй микро организм байсан, яаж эдгээр зүйлсийг бүтээсэн байх уу? Эдгээр илэрсэн зүйлс нь дэлхий даяар шинжлэх ухааны эрдэмтдийн анхаарлыг татсан. Тайлбарлаж чадахгүй болохоор эдгээрийг түүхийн өмнөх үеийн соёл гэдэг.

Үе үеийн шинжлэх ухааны түвшин бүгд адилгүй байсан, зарим үед маш өндөрт хүрсэн, бидний орчин үеийн хүн төрөлхтний түвшнөөс давсан. Гэхдээ тэдгээр соёл иргэншил нь устсан. Иймээс *чигон*-ыг бидний орчин үеийн хүн бий болгосон биш, бүтээсэн биш, харин орчин үеийн хүмүүс олж илрүүлээд сайжруулсан гэж би хэлмээр байна. Энэ нь түүхийн өмнөх үеийн соёл юм.

Чигон зөвхөн манай оронд байгаа зүйл биш, гадаадад ч бас байдаг. Гэхдээ тэд *чигон* гэж нэрлэдэггүй, Европчууд үүнийг илбэ гэдэг, Америк, Англи гэх мэт орнуудад ингэж л нэрлэдэг. Америкийн илбэчин, Дэвид Копперфилд нь ер бусын чадварын их багш, энэ хүн Хятадын цагаан хэрэмний ханыг нэвт алхаж гарах тоглолт үзүүлсэн. Тэр нэвтэрч гарахдаа цагаан даавуугаар өөрийгөө болон ханыг бүтээгээд дараа нь нэвтэрсэн. Тэр яагаад ингэж хийсэн бэ? Ингэвэл хүмүүст илбэ үзүүлэлт гэж харагдана, яагаад гэвэл тэр ингэж хийхгүй бол болохгүй. Ингэж хийсэн нь Хятадад байдаг олон гайхалтай ер бусын чадвартай хүмүүс түүнийг үймүүлэхээс айсан, иймээс тэр орохоосоо өмнө өөрийгөө бүтээсэн, гарахдаа эхлээд нэг гараар бүтээлгээ сөхөөд цухуйсан, тэгээд гарч ирсэн. Мэргэжлийн хүн бол аргыг нь хардаг, энгийн хүн бол мэл гайхшран хардаг гэсэн үг байдаг. Ингэж хийвэл үзэгчид үүнийг илбэ үзүүлж байна гэж бодно. Тэд эдгээр ер бусын чадварыг илбэ гэдэг, яагаад гэвэл энэ нь биеэ бясалгахад зориулагдаагүй, харин тайзан дээр ер бусын зүйлс үзүүлж үзэгчдийг зугаацуулдаг. Иймээс доод түвшинд яривал *чигон*-ыг биеийнхээ байдлыг өөрчлөх, өвчнөө эдгээх, биеэ сайжруулах зорилгоор хэрэглэдэг. Дээд түвшинд яривал *чигон*-оор өөрийнхөө үндсэн эх биеийг бясалгадаг.

2. Чий ба Гон

Бидний одоо ярьж байгаа *чий*-г¹¹ дээр үеийн хүмүүс чээ гэдэг байсан. Тэдгээрийн утга нь үндсэндээ адилхан, хоёулаа орчлон ертөнцийн *чий*-г хэлж байгаа, энэ нь орчлон ертөнц даяар орших хэлбэр дүрсгүй, үл үзэгдэх бие бодь юм. Энэ агаарыг хэлж байгаа юм биш, тэр бие бодийн

¹¹ *чий*- Хятад тайлбарт: бодис, энерги, биед болон орон зайд орших янз бүрийн хэлбэртэй, гол төлөв амин энерги гэдэг, хүний эрүүл мэндийг тодорхойлдог.

энерги нь бясалгалаар хүний биед идэвхжиж биеийн байдлыг өөрчилдөг, өвчнийг арилгах бие сайжруулах нөлөө гаргадаг. Гэхдээ *чий* бол ердөө л *чий*, чамд ч *чий* байгаа, түүнд ч *чий* байгаа, нэг хүний *чий* нөгөө хүнийхийг хязгаарлах нөлөө байхгүй. Зарим хүн *чий* өвчнийг эдгээж чадна, эсвэл чамайг *чий-гээ* явуулж хэн нэгний өвчнийг эдгээж өгч болно гэнэ. Энэ яриа нь шинжлэх ухааны үндэслэлгүй, яагаад гэвэл *чий* үндсэндээ өвчнийг эдгээж чадахгүй. Бясалгадаг хүний биед *чий* байвал түүний бие сүүн цагаан биед хувирч чадаагүй, түүнд бас өвчин байна гэсэн үг.

Бясалгаад өндөр увьдас чадвартай болсон хүнээс *чий* гардаггүй, харин дээд энергийн бөөгнөрөл гардаг. Энэ нь туяа хэлбэрээр илэрдэг дээд энергийн бие бодь, их нарийн ширхэгтэй, маш өндөр нягтралтай. Энэ бол *гон*. Энэ үед энгийн хүнийг хязгаарлах нөлөө гардаг, зөвхөн үүгээр хүний өвчнийг эдгээж болно. Ийм нэг үг байдаг, “Буддын туяа даяар гийхэд зүй бус бүхэн засагдана”. Утга нь бол ариун номоор бясалгадаг хүний биед агуулагдах энерги нь маш их, түүний байгаа газар, түүний энергийн бүрхүүл дотор байгаа аливаа гажуу байдал засагдаж болно, хэвийн байдалдаа орно. Жишээ нь, хүний бие өвчтэй бол биед хэвийн бус байдал гарсан гэсэн үг, энэ байдал засагдвал өвчин эдгэрнэ. Энгийнээр хэлбэл *гон* бол энерги. Гон материаллаг шинж чанартай, бясалгадаг хүн үүний бодитоор оршиж байгааг бясалгалаар мэдэрдэг.

3.Гон хүч ба Ер бусын чадвар

1) Гон хүч зан чанарын бясалгалаар гардаг.

Хүний *гон* хүчний түвшнийг жинхэнэ тодорхойлдог *гон* нь *чигон* дасгалаар гардаггүй, харин “буян” гэдэг бие бодийн хувирлаас гардаг, зан чанараа бясалгаснаар гардаг. Энэ хувирах явц нь энгийн хүний төсөөлдөгөөр зуухан дээр

тогоо тавиад эмийн бодисуудыг найруулж үрэл гаргадагтай адилгүй. Бидний ярьж байгаа *гон* бол хүний биений гадна үүсдэг, биений доод хэсгээс эхэлдэг. Зан чанараа дээшлүүлэхэд энэ нь мушгирсан хэлбэрээр дээш өснө, хүний биеийн гадна үүсдэг. Толгойн оройд хүрээд нэг гон багана болдог, гон багана хэр өндөр байгаагаас тэр хүний гоны түвшин харагддаг. Гон багана маш гүн, нуугдмал орон зайд байрладаг, энгийн хүнд амархан харагдахгүй.

Ер бусын чадвар нь гон хүчээр адислагддаг, гон хүчний түвшин өндөр байгаа хүний ер бусын чадвар ч хүчтэй, хэрэглэхэд амархан. Гон хүч нь сул хүний ер бусын чадвар нь ч хүчгүй, хэрэглэхэд бас амар биш, тэр ч байтугай хэрэглэж чадахгүй. Ер бусын чадвар нь хүний гон хүчний их багыг, түвшний өндөр намыг төлөөлөхгүй. Хүний түвшний өндөр намыг тодорхойлдог нь гон хүч юм, харин ер бусын чадвар биш. Зарим хүн түгжээтэй бясалгадаг, түүний гон хүч нь маш өндөр ч гэсэн тийм их ер бусын чадвар байхгүй. Гон хүч бол хамгийн гол тодорхойлогч хүчин зүйл, зан чанарын бясалгалаар гардаг, хамгийн чухал зүйл юм.

2) Ер бусын чадвар нь бясалгадаг хүний хөөцөлддөг зүйл биш.

Бүх бясалгадаг хүн ер бусын чадварыг их анхаардаг. Ер бусын чадвар нь нийгэмд их сонирхол татдаг, олон хүн ер бусын чадвартай байхыг хүсдэг, гэхдээ хүний зан чанар сайн биш бол ер бусын чадвар гарахгүй.

Зарим ер бусын чадвар энгийн хүнд байж магад, жишээ нь тэнгэрийн мэлмий нээгдэх, тэнгэрийн сонсгол нээгдэх, алсаас мэдрэх онцгой чадвар, урьдчилан хэлэх онцгой чадвар гэх мэт. Гэхдээ эдгээр онцгой чадвар нь хүнээсээ хамаарч өөр өөр байдаг, аажмаар гэгээрэх явцад энэ бүх чадвар гардаггүй. Зарим ер бусын чадвар энгийн хүнд байхгүй, жишээ нь энэ бодит орон зайн нэг юмыг өөр нэг

зүйлд хувиргах тийм чадвар энгийн хүнд байхгүй. Аугаа ер бусын чадвар зөвхөн бясалгалаар гардаг. Фалунь Гон бол орчлон ертөнцийн мөн чанар дээр үндэслэн гарч ирсэн, тиймээс орчлон ертөнцөд оршдог бүх ер бусын чадвар Фалунь Гонд байдаг, энэ нь бясалгагчийн хэр бясалгахаас шалтгаална. Зарим ер бусын чадвартай болохыг хүсэх нь буруу биш, гэхдээ хэтэрхий ихээр хүсвэл хэмжээнээс хэтэрнэ, мөн муу үр дагавар авчирна. Доод түвшинд жоохон ер бусын чадвартай болсон хүн энгийн хүмүүсийн өмнө өөрийнхөө чадварыг гайхуулж тэднээс арай хүчирхэг гэж харагдахыг хүсвэл үүний хэрэг гэж байхгүй. Хэрэв ийм байвал энэ хүний зан чанар өндөр биш гэсэн үг, ер бусын чадварыг түүнд өгөхгүй байх нь зөв. Зарим ер бусын чадварыг зан чанар муутай хүнд өгвөл тэр муу зүйл хийхэд ашиглана. Яагаад гэвэл хүний зан чанар туйлбартай сайн биш бол тэр хүн муу зүйл хийхгүй гэсэн баталгаа байхгүй.

Гэхдээ аливаа үзүүлж хэрэглэж болдог ер бусын чадвараар хүн төрөлхтний нийгмийг эсвэл энгийн нийгмийн амьдралыг өөрчилж чадахгүй. Жинхэнэ аугаа ер бусын чадварыг ил гаргаж үзүүлэхийг зөвшөөрөхгүй, яагаад гэвэл үүний нөлөө, аюул маш их. Жишээ нь нэг том барилгыг нураах үзүүлбэр. Аугаа ер бусын чадварыг маш онцгой зорилгоор хэрэглэхээс бусад тохиолдолд хэрэглэхийг зөвшөөрөхгүй. Үүнийг ил гаргаж болохгүй, яагаад гэвэл дээд түвшний их багш нар хязгаарлаж байдаг.

Гэхдээ зарим хүмүүс *чигон* багшийг ер бусын чадвараа үзүүлэхийг шахдаг. Тийм хүн ер бусын чадвараа ил гаргаж үзүүлэх дургүй байдаг, яагаад гэвэл үүнийг үзүүлэх нь хориотой, ил гаргаж үзүүлчихвэл бүхэл нийгмийн байдлыг үймүүлнэ, жинхэнэ аугаа буянтай хүнд ер бусын чадвараа ил гаргаж үзүүлэхийг зөвшөөрөхгүй. Зарим *чигон* багш нар тоглолт үзүүлснийхээ дараа сэтгэл санаагаар их унадаг, харамсан уйлмаар болдог. Тэднийг үзүүлэхийг битгий шах! Ийм зүйлийг ил гаргаж харуулахдаа тэд их гутардаг. Нэг

сурагчийн надад авчирсан сэтгүүлийг уншаад миний сэтгэл эвгүйрхсэн. Түүн дээр Олон улсын *чигон*-ы чуулган болох тухай бичсэн байсан, хэн ер бусын чадвартай нь ирж тэмцээнд оролцож болно, аугаа ер бусын чадвартай хүмүүст чуулган нээлттэй. Би үүнийг уншсаны дараа хэдэн өдөр таагүй байсан. Үүгээр уралдаан тэмцээнд орж болдоггүй юм, дараа нь харамсана. Энгийн хүн бол зөвхөн дэлхийн бодит зүйлд л анхаардаг, гэхдээ Чигон багш нар өөрийгөө эрхэмлэх ёстой.

Ер бусын чадвартай болохын цаад зорилго нь юу вэ? Бясалгадаг хүний бодол, мөн юу хөөцөлдөх нь харагддаг, бодол хүсэл нь ариун биш, тогтворгүй байвал дээд ер бусын чадварыг олж чадахгүй. Үүнд ийм нэг учир байдаг, чи төгс гэгээрэхээс өмнө, харсан юмны сайн мууг зөвхөн Гурамсан ертөнцийн номын шалгуураар цэгнэнэ, чамд энэ зүйлийн үнэн байдал, хувь тавилангийн холбоо харагдахгүй. Хүн хүний хоорондын зодоон, хэрүүл, дээрэлхэлт бүгд заавал учир шалгаантай байдаг, чи тэр шалтгааныг харж чадахгүй бол, тусалсан биш гай болно. Энгийн хүний хоорондын талархал, хорсол, зөв буруу бүгд энгийн хүний зүйд хамаардаг, бясалгадаг хүн үүнд оролцох хэрэггүй. Төгс гэгээрэхээс өмнө чиний харсан зүйл магадгүй үнэн биш. Нэг нь нөгөөгөө цохих нь тэд магадгүй нүглийн өрөө төлж байгаа хэрэг, чи дунд нь оролцвол магадгүй тэдний нүглийн өрөө хариулахад саад болно. Нүгэл бол хүний биеийн эргэн тойронд байдаг нэг төрлийн хар бие бодь, энэ нь өөр нэг орон зайд бодитоор оршдог, энэ зүйл өвчин ба гай зовлон болж хувирдаг.

Ер бусын чадвар хүн болгонд байдаг, энэ нь тууштай бясалгалын дүнд нээгдэж бэхэждэг. Бясалгадаг хүний хувьд зөвхөн ер бусын чадвар олохыг хөөцөлдвөл тэр хүн холын бодолгүйнх юм, бодол нь ариун биш юм. Юуны тулд ер бусын чадвартай болохыг хүсч байгаа нь хамаагүй, түүнд

үргэлж амиа хичээсэн сэтгэл оршдог. Энэ нь бясалгалд саад болно, эцэст нь ямар ч ер бусын чадвар олж авч чадахгүй.

3) Гон хүчийг залуурдах

Зарим хүн бясалгаж эхлээд удалгүй хүний өвчнийг эдгээхийг хүсдэг, нөлөө гарах үгүйг нь үзмээр санагддаг. Өндөр *гон* хүчгүй хүн гараа сунгаад хийж үзэхэд өвчтэй хүний биед байгаа их хэмжээний өвчтэй, бохир хар *чий*-г өөрийнхөө биед татдаг. Яагаад гэвэл чамд өвчтэй *чий*-нээс хамгаалах чадвар байхгүй, биед чинь хамгаалах бүрхүүл байхгүй. Чи өвчтэй хүнтэй нэг оронгоор холбогддог, *гон* хүч тийм хүчтэй биш бол өөрийгөө хамгаалж чаддаггүй, биендээ их таагүй байдлыг мэдэрнэ. Хэрэв чамд хамгаалах хүн байхгүй бол яваандаа чиний бие бүхэлдээ өвчний үүр болно. Тийм болохоор өндөр *гон* хүчгүй хүн бусдын өвчинг эдгээж өгч болохгүй. Зөвхөн ер бусын чадвартай болсон хүн, тодорхой *гон* хүчтэй болсны дараа *чигон*-оор хүний өвчнийг эдгээж болно. Хэдийгээр зарим хүний ер бусын чадвар гарч, мөн өвчнийг эдгээж чаддаг болсон ч түвшин нь их доогуур бол үнэндээ хадгалагдсан *гон* хүчээ өгч байж өвчнийг эдгээдэг, өөрийн энергээр өвчнийг эдгээдэг. Гон бол энерги мөн увидастай зүйл, энэ нь амар хуримтлагддаггүй тиймээс чи *гон* гаргахдаа өөрийнхөө *гон*-ыг шавхаж байгаа юм. Чамайг *гон* гаргахад толгой дээрх *гон* багана чинь доошилж барагдана, энэ бол ёстой хайран юм. Ийм болохоор би, чиний *гон* хүч их биш байхад хүний өвчнийг эдгээж өгөхийг дэмжихгүй. Чи ямар ч сайн арга хэрэглэсэн ч өөрийнхөө энергийг зарцуулна гэсэн үг.

Гон хүч нь тодорхой хэмжээнд хүрсний дараа янз бүрийн ер бусын чадвар гардаг, тэдгээр ер бусын чадваруудыг хэрэглэхдээ их болгоомжтой байх ёстой. Жишээ нь, тэнгэрийн мэлмий нээгдэхэд хэрэглэхгүй байж бас болохгүй, ердөө хэрэглэхгүй бол хаагдчихдаг. Харсан ч бас үргэлж хараад байж болохгүй, их хараад байвал бас энергээ их алдана. Тэгвэл чамайг үүнийг хэзээ ч битгий хэрэглэ

гэсэн үг үү? Мэдээж тийм биш. Хэрэв хэрэглүүлэхгүй юм бол бясалгаж яах юм? Хэзээ хэрэглэх нь гол асуудал юм. Зөвхөн нэг тодорхой хэмжээнд бясалгаж хүрсний дараа өөрөө энергийг нөхөх чадвартай болоход хэрэглэж болно. Фалунь Гон бясалгагч тодорхой түвшинд хүрэхэд, хэр их *гон* гаргасан ч Фалунь үүнийг автоматаар хувиргаж нөхөж өгдөг, бясалгадаг хүний *гон* хүчний түвшинг нэг хэмжээнд автоматаар барьж байдаг, жоохон ч багасгахгүй. Энэ бол Фалунь Гоны онцлог юм. Зөвхөн энэ үед ер бусын чадварыг хэрэглэж болно.

4.Тэнгэрийн мэлмий

1) Тэнгэрийн мэлмий нээгдэх

Тэнгэрийн мэлмийн гол гарц нь духны голд буюу Шангень¹² цэг дээр байрладаг. Энгийн хүн нүдээрээ харах нь зургийн аппаратны ажиллагаатай адил, линз болон хүүхэн харааны том жижиг болох нь юмны хол ойроос болон гэрлийн хэмжээнээс болж тохируулагддаг. Харсан зүйл нь харааны судлаар дамжин тархины хойд хэсэгт байрлах буурцагт булчирхайд дүрс болон буудаг. Нэвт харах ер бусын чадвар бол буурцагт булчирхай тэнгэрийн мэлмийгээр дамжиж шууд гадагшаа харах чадвар юм. Энгийн хүний тэнгэрийн мэлмий хаалттай байдаг. Гол гарц суваг нь нарийн бөгөөд харанхуй, дотор нь охь *чий* байхгүй, гэрэлгүй, зарим хүний суваг нь бөглөрсөн байдаг, иймээс харж чадахгүй.

Бид тэнгэрийн мэлмийг нээхдээ нэгд: Эхлээд гадны хүчээр эсвэл өөрөө бясалгаад энэ сувгийг онгойлгодог. Хүн болгоны энэ сувгийн хэлбэр нь өөр өөр байдаг, зуйвангаас дугуй хэлбэртэй, ромбоос гурвалжин хэлбэртэй байж болно, сайн бясалгах тусам улам дугуй хэлбэртэй болдог. Хоёрт:

¹² Шангень-хоёр хөмсөгний дундаас арай доохон орших цэг

Багш нь чамд нэг нүд өгдөг, эсвэл өөрөө бясалгаад гаргаж болдог. Гуравт: Тэнгэрийн мэлмийн байршилд охь *чий* байх ёстой.

Жирийн үед бид юм харахдаа энэ хоёр нүдээр хардаг. Харин энэ хоёр нүд бидний өөр орон зайг харах сувгийг хаачихдаг, энэ хаалтны нөлөөнд бид зөвхөн бидний энэ материаллаг орон зайн зүйлийг л хардаг. Тэнгэрийн мэлмий нээгдвэл энэ хоёр нүдийг хэрэглэхгүйгээр юм харна. Маш дээд түвшинд хүрсний дараа Үнэн нүдийг бясалгаад гаргаж болно, тэгээд Гурав дахь нүд буюу Үнэн нүдээр эсвэл Шаньгенг цэг дэх Үнэн нүдээр харж болно. Буддын системд арьсны нүх болгоныг нэг нүд гэдэг, бүх биеэр дүүрэн нүд байдаг. Дао-гийн системд биологийн идэвхтэй цэг болгоныг нэг нүд гэдэг. Тэгэхдээ гол суваг нь тэнгэрийн мэлмийд байдаг, энэ нь заавал эхлээд нээгдэх ёстой. Энэ лекцэн дээр би хүн болгонд тэнгэрийн мэлмийг нээх зүйл суулгаж өгсөн. Хүн болгоны биений байдал өөр өөр болохоор үр дүн ч өөр гарна. Зарим хүнд гүн худаг шиг хар нүх харагддаг, энэ бол тэнгэрийн мэлмийн суваг нь харанхуй байна гэсэн үг. Зарим хүнд энэ суваг нь цагаан өнгөтэй харагддаг, хэрэв нүдний өмнө юм харагдвал тэнгэрийн мэлмий нь нээгдэх гэж байгаа гэсэн үг. Зарим хүнд нэг зүйл эргэж байгаа харагддаг, энэ бол багшийн чамд суулгаж өгсөн тэнгэрийн мэлмийг нээх зүйл юм, тэнгэрийн мэлмийг өрөмдөж онгойлгомогц чи юм хардаг болно. Зарим хүний тэнгэрийн мэлмийд нэг том нүд харагддаг, үүнийг Будда нүд гэж үздэг, үнэндээ энэ бол өөрийн чинь нүд, ийм хүний төрөлхийн суурь нь нэлээд сайн байдаг.

Бидний судалснаар бол миний лекц болгон дээр тэнгэрийн мэлмий нь нээгдсэн хүний тоо суусан хүмүүсийн талаас илүү нь байдаг. Тэнгэрийн мэлмий нээгдсэний дараа нэг асуудал гарч болзошгүй, зан чанар нь өндөр биш хүн үүнийг ашиглан муу зүйл хийх нь амархан. Энэ асуудлаас зайлахын тулд, би чиний тэнгэрийн мэлмийг шууд билгийн

нүд нээгдэх түвшинд нээж өгнө. Өөрөөр хэлбэл дээд түвшинд нээж өгнө, чамд шууд өөр орон зайн байдлыг харуулна, чамайг дасгалаа хийж байхад гарсан зүйлийг харуулна, чамайг итгэлтэй болгоно, энэ нь чиний бясалгал хийх итгэл үнэмшлийг батжуулна. Дөнгөж бясалгал хийж эхэлж байгаа хүний зан чанар энгийн хүний түвшнөөс гараагүй үед ер бусын чадвартай болбол муу зүйл хийх талтай. Нэг хошин жишээ хэлье, чи гудамжинд явж байгаад хонжворт сугалаа харвал магадгүй дээд хонжворыг нь авчихна, зүгээр л энэ асуудлыг тайлбарлаж байна. Ийм байдал гарахыг зөвшөөрөхгүй. Бас өөр нэг учир гэвэл, бид их олон хүмүүст тэнгэрийн мэлмийг нээж өгч байгаа. Хэрэв тэнгэрийн мэлмийг доод түвшинд нээж өгвөл, та бүгд боддоо, хүн болгон хүний биеийг нэвт харж чадна эсвэл хананы цаадхыг нэвт харна, тэгвэл энэ нь хүн төрөлхтний нийгэм мөн үү? Тийм байвал энгийн хүний нийгмийн байдлыг ноцтойгоор үймүүлнэ, үүнийг бол зөвшөөрөхгүй, тийм байж болохгүй. Түүнчлэн бясалгадаг хүнд энэ нь ямар ч ашиггүй, харин хүний зууралдсан сэтгэлийг хүчтэй болгоно. Иймээс чамд тэнгэрийн мэлмийг доод түвшинд нээж өгөхгүй харин шууд дээд түвшинд нээж өгнө.

2)Тэнгэрийн мэлмийн түвшин

Тэнгэрийн мэлмийд олон түвшин байдаг. Түвшин өөр байвал харагдах орон зай ч өөр байдаг. Буддын шашинаар яривал таван түвшин байдаг: Махан нүдний, Тэнгэрийн нүдний, Билгийн нүдний, Номын нүдний, Будда нүдний. Түвшин болгон бас дээд, дунд, доод гэж хуваагддаг. Тэнгэрийн нүд нээгдэх түвшинд болон түүнээс дооших түвшинд зөвхөн бидний энэ материаллаг орон зайн зүйл л харагддаг. Билгийн нүд нээгдэх түвшинд мөн түүнээс дээш түвшинд өөр орон зайнууд харагддаг. Тэдгээр нэвт харах ер бусын чадвартай хүмүүс “СТ” оношлогооны төхөөрөмжөөс илүү нарийвчлалтай тод харж чаддаг. Гэхдээ тэдний хардаг нь мөн л бидний энэ бодит орон зайн зүйлс л юм, бидний

оршиж байгаа энэ орон зайнаас гараагүй, энэ нь тэнгэрийн мэлмийн дээд түвшинд тооцогдохгүй.

Хүний тэнгэрийн мэлмийн түвшин хэр өндөр байгаа нь энэ хүний охь *чий* их багаас, гол сувгийн өргөн нарийнаас, гэгээтэй эсэхээс мөн гол суваг хэр бөглөрснөөс шалтгаалдаг. Тэнгэрийн мэлмий хэр сайн нээгдэх нь дотоод охь *чий*-нээс хамаарна. Зургаагаас доош насний хүүхдийн тэнгэрийн мэлмийг нээхэд их амар, надад гараа хэрэглэх ч хэрэг байхгүй зүгээр үг хэлэхэд л нээгдэнэ. Яагаад гэвэл хүүхдийн төрөлхийн чанарт материаллаг орчны муу нөлөө бага туссан, муу зүйл хийгээгүй, бас төрөлхийн охь *чий* нь сайн хадгалагдсан байдаг. Зургаагаас дээш насны хүүхдийн тэнгэрийн мэлмийг нээхэд хэцүү болно, яагаад гэвэл хүүхэд өсөх тусмаа гадны нөлөөнд улам их автдаг. Тухайлбал муу хүмүүжүүлснээс, дураар нь тавьснаас ёс суртхуун нь муудахад охь *чий* нь алдагддаг, тодорхой нэг хэмжээнд хүрэхэд бүгд дуусна. Охь *чий*-гээ гээж дууссан хүн бясалгалын замаар үүнийг аажимдаа дахин сэргээж болно, гэхдээ их урт удаан хугацаа шаардагдана мөн их зовж зүдрэх болно. Иймд охь *чий* бол маш нандин юм.

Би тэнгэрийн мэлмийг Тэнгэрийн нүдний түвшинд нээхгүй байхыг зөвлөдөг, учир нь бясалгагчийн гон хүч сул бол бясалгалаар хураах энергээс илүү хэмжээний энергийг юм харахдаа зарцуулна. Охь *чий*-гээ их хэмжээгээр алдвал тэнгэрийн мэлмий дахин хаагдаж магад, тэгвэл дахиад нээхэд их хэцүү болно. Тиймээс би Тэнгэрийн мэлмийг хүнд нээж өгөхдөө Билгийн нүдний түвшинд нээдэг. Бясалгагч тодорхой харж чадах үгүй нь хамаагүй өөр орон зайны зүйлсийг харж чадна. Төрөлхийн суурь чанараас шалтгаалан зарим хүн тод харна, зарим нь үе үе хардаг, бас зарим хүнд бол бүдэг харагддаг. Дор хаяж чи гэрэл харах болно. Энэ нь бясалгагчийг дээд түвшин лүү ахихад тустай. Тод харж чадахгүй хүн бясалгаад байвал нөхөгдөж болно.

Бага охь *чий*-тэй хүний тэнгэрийн мэлмийгээрээ харсан зүйл хар цагаан өнгөтэй байдаг. Охь *чий* нь харьцангуй их байгаа хүний харсан зүйл өнгөтэй, тод байдаг. Охь *чий* их байх тусам улам тод харна. Гэхдээ хүн болгон адилгүй, зарим хүний Тэнгэрийн мэлмий төрөлхийн нээлттэй байдаг, зарим хүнийх бүр бөглөрчихсөн байдаг. Тэнгэрийн мэлмий нээгдэх нь цэцэг дэлбээлэхтэй адил давхарга давхаргаар нээгддэг. Завилан суугаад бясалгаж байхад тэнгэрийн мэлмий туяарч эхэлнэ, эхэндээ тийм гэгээтэй биш, аажимдаа улаан болж хувирна. Зарим хүний Тэнгэрийн мэлмий их бөглөрчихсөн байдаг, нээхэд их хүчтэй мэдэрдэг. Гол суваг мөн Шангэнь цэг хавийн булчин чангарна, яг дотогш дарагдаж шахагдаж байгаа мэт болдог. Чамархай духаар хөөсөн мэт болж хөндүүрлэнэ, энэ бол Тэнгэрийн мэлмий нээгдэж байгаагийн шинж тэмдэг юм. Тэнгэрийн мэлмий амархан нээгддэг хүнд магадгүй гэнэт ямар нэг зүйл харагддаг. Лекц уншиж байхад зарим хүн санаандгүй миний Номын биесийг хардаг. Тэр улам сайн харах гэж чармайхад тэд алга болдог, энэ нь өөрийнхөө бодит нүдийг хэрэглэснээс юм. Нүдээ аниад юу харсан ч тэр байдлаа хадгалахыг хичээ, аажимдаа улам тод хардаг болно. Хэрэв чи улам тод харах гэвэл үнэндээ өөрийнхээ энэ бодит нүдрүү шилжиж харааны мэдэрлийн судлаа хэрэглэдэг, тэгээд юм харагдахгүй болно.

Тэнгэрийн мэлмийн түвшнөөс хамаарч харагдах орон зай ч өөр байдаг. Зарим судалгаа шинжилгээний газрууд энэ байдлыг мэдэхгүй, *чигон* дээр зарим туршилт хийгээд үр дүнд хүрдэггүй, тэр ч байтугай буруу дүгнэлтэнд хүрдэг. Жишээ нь, нэг байгууллага тийм ер бусын чадварыг шалгах арга туршсан, *чигон* багш нараас нэг битүү хайрцаган дотор юу байгааг асуусан. Тэдгээр *чигон* багш нарын Тэнгэрийн мэлмийн түвшин өөр өөр болохоор, хариулт нь ч өөр өөр гарсан, үүнээс болж туршилт хийсэн газар тэнгэрийн мэлмийг хуурамч, хүнийг хуурдаг гэж үзсэн. Ийм шалгалтанд Тэнгэрийн мэлмийн түвшин нь доогуур байгаа

хүний далдыг харах чадвар нь сайн үр дүнтэй гардаг, яагаад гэвэл түүний тэнгэрийн мэлмий нь зөвхөн Тэнгэрийн нүдний түвшинд нээгдсэн, энэ нь зөвхөн материаллаг орон зайн зүйлсийг харахад зохистой түвшин. Тиймээс тэнгэрийн мэлмийг ойлгодоггүй хүмүүс ийм хүний ер бусын чадварыг хамгийн өндөр түвшинд гэж үздэг. Бүх зүйлс, органик, органик биш бүгд өөр өөр орон зайнд өөр өөр хэлбэр, дүрстэйгээр илэрдэг. Жишээ нь, нэг шилэн аяга үйлдвэрлэгдэнгүүт өөр орон зайд түүний нэг амь үүсдэг. Харин тэр амь бий болохоосоо өмнө магадгүй өөр зүйл байсан. Тэнгэрийн мэлмийн доод түвшинд энэ нь зөвхөн аяга гэж харагдана, нэг түвшин өндөр байхад өөр орон зайны тэр амь бодь харагддаг, дахиад өндөр түвшинд харахад энэ амь бодийн оршиж байсан өмнөх хэлбэр нь харагддаг.

3) Далдыг харах

Тэнгэрийн мэлмий нээгдсэний дараа зарим хүнд далдыг харах ер бусын чадвар гардаг, тэр хэдэн мянган километрийн цаана байгаа зүйлийг харж чаддаг. Хүн болгон өөрийн гэсэн орон зайг эзэлж байдаг, тэр орон зайд өөрөө орчлон ертөнц шиг том хэмжээтэй байдаг. Нэг тодорхой орон зайд түүний духны өмнө нэг толь байдаг, бидний энэ орон зайд харагдахгүй. Энэ толь хүн болгонд байдаг, харин бясалгадаггүй хүний энэ толь нь дотогшоо харсан байдаг, бясалгадаг хүний толь нь аажмаар гадагш эргэдэг. Эргэсний дараа бясалгагчийн харах гэсэн зүйлийг тусгадаг. Энэ онцгой орон зайд тэр маш том, энэ толь ч гэсэн маш том, харахыг хүссэн зүйл нь толинд тусгагддаг. Дүрс тусгагдсан ч гэсэн тэр харж чадахгүй, дүрс нь энэ толинд нэг агшин зуур үлдэх ёстой. Толь дотогш эргэж тусгасан зүйлээ чамд харуулаад буцаад гадагш харна, маш хурдан дахиад эргэдэг, тасралтгүйгээр нааш цааш эргэдэг. Дүрсийг тасралтгүйгээр гаргахын тулд киноны хальс нэг секундэд 24 кадрын хурдтайгаар эргэдэг. Тольны эргэх хурд түүнээс ч хурдан, иймээс гарсан дүрс тасралтгүй бөгөөд тодорхой харагддаг,

үүнийг далдыг харах гэдэг. Далдыг харах зарчим нь ийм хялбар. Энэ бол нууцын нууцад байсан, би үүнийг хэдхэн үгээр илчиллээ.

4) Орон зай

Бидний харж байгаагаар орон зай бол маш нарийн, ярвигтай. Хүн төрөлхтөн зөвхөн өөрийнхээ оршиж байгаа орон зайг л мэддэг, өөр орон зайг судалж, илрүүлж чадаагүй. Өөр орон зайн хувьд, бид *чигон* багш нар хэдэн арван өөр орон зайг харж чаддаг, онолоор тайлбарлаж болно, гэхдээ шинжлэх ухаан үүнийг баталж чадаагүй. Зарим зүйлийн оршиж байгааг чи хүлээн зөвшөөрөхгүй байсан ч, энэ нь бидний энэ орон зайд илэрсэн. Жишээ нь: дэлхийд Бермудын гурвалжин гэдэг газар байдаг, хүмүүс үүнийг чөтгөрийн гурвалжин гэдэг. Зарим усан онгоц, нисдэг онгоц энэ хэсэг газарт ороод алга болчихдог, хэдэн жилийн дараа эргээд гараад ирдэг. Хэн ч үүний учрыг тайлбарлаж чаддаггүй, хэн ч одоогийн хүн төрөлхтний үзэл бодол, онолын хүрэнээс гараагүй. Үнэндээ энэ гурвалжин бол өөр орон зайд орох үүд юм. Бидний энгийн хаалга шиг тодорхой байрлалтай биш, урьдчилан тааварлах боломжгүй байдаг. Усан онгоц энэ үүд яг нээгдэх үед тэнд яваад хүрчихвэл амархан өөр орон зайд орчихдог, хүн орон зайн хоорондын зөрөөг мэдрэхгүй, тэр агшин зуурт л орчихдог. Тэр орон зай болон бидний энэ орон зайн цаг хугацааны зөрөөг километрээр хэмжишгүй, хэдэн мянган километр зай нь эндхийн магадгүй нэг хэсэг газраас хэтрэхгүй, өөрөөр яривал тэдгээр нь нэг газар нэг цагт зэрэг оршдог. Усан онгоц орчихоод жоохон байж байгаад санаандгүй буцаад гараад ирэхэд дэлхий дээр хэдэн арван жил өнгөрчихсөн байдаг, яагаад гэвэл хоёр орон зайн цаг хугацаа өөр байдаг, орон зай болгонд орчлон ертөнц оршдог. Бөмбөлгүүд нэг нэгэнтэйгээ холбогдсон атомын бүтцийн хэлбэртэй адил, маш олон бөмбөлөг холбоостой маш нарийн, ярвигтай.

Дэлхийн 2-р дайн эхлэхээс дөрвөн жилийн өмнө Английн нэг нисгэгч даалгавар авч нисч явахдаа ширүүн аадар бороотой тааралдаж урьдныхаа туршлагаар нэг ашиглагдахгүй болсон онгоцны буудал олж газардсан. Харин энэ онгоцны буудал нь түүний нүдэнд огт өөр болж хувирсан, гэнэт тэнгэр цэлмэг нартай болж өөр орчлонгоос ирсэн мэт санагдсан. Нисэх буудал дээр шар өнгийн будагтай онгоцнууд байсан, хүмүүс тэнд завгүй ажиллаад л, тэр маш их гайхсан. Газардсаны дараа хэн ч түүнийг анзаараагүй, нислэг удирдах цамхгаас ч түүнтэй холбоо бариагүй. Тэнгэр цэлэмсэн болохоор тэр буцаад ниссэн. Нисээд хэсэгхэн хугацааны өмнө тэр онгоцны буудал харагдсан зайнд хүрэхэд тэр дахиад ширүүн аадар бороон дунд орсон, тэгээд эцэст нь буцаад харьж чадсан. Тэр энэ тохиолдсон явдлаа илтгэсэн, нислэгийн тэмдэглэлдээ хүртэл бичсэн. Гэвч дарга нь түүнд итгээгүй. Дөрвөн жилийн дараа дэлхийн хоёрдугаар дайн эхэлсэн, түүнийг орхигдсон тэр онгоцны буудал руу томилсон. Тэр эргэн санахад тэнд яг дөрвөн жилийн өмнө харсан байдалтай нь адилхан байсан. Бид *чигон* багш нар үүний учрыг тайлбарлаж чадна, энэ үйл явдал болохоос дөрвөн жилийн өмнө тэр урьдчилаад тэнд очсон, дараа нь бүх зүйл зөв эрэмбэ дараалалдаа орсон.

5. Чигон эмчилгээ ба эмнэлгийн эмчилгээ

Онолын үүднээс яривал *чигон* эмчилгээ нь эмнэлэгийн эмчилгээнээс үндсээрээ өөр юм. Барууны эмчилгээнд энгийн хүний нийгмийн өвчин эдгээх арга хэрэглэдэг, лабораторын шинжилгээ, рентген туяа-ны оношлогоо гэх мэт байсан ч зөвхөн энэ орон зайны өвчтэй газрыг л шинжилдэг, өөр орон зайд орших өвчний эх үүсвэрийг харж чадахгүй. Тиймээс өвчин үүссэн шалтгааныг мэдэхгүй. Өвчин хөнгөн байвал эмчилгээгээр өвчнийг эдгээж эсвэл өвчний үүсвэрийг (үүнийг барууны эмчилгээнд өвчин үүсгэгч нян гэдэг, *чигон*-д нүгэл гэдэг) арилгаж чадна. Хүнд өвчнийг анагаах ухаанаар эмчилж чадахгүй, эмийн тунг

нэмбэл өвчтөн даахгүй. Зарим өвчин энэ орчлон дэлхийд хязгаарлагдахгүй, энэ хүрээнээс давсан хүнд өвчинг эмнэлэгт эмчилж чадахгүй.

Хятад эмчилгээ бол манай орны уламжлалт анагаах ухаан, энэ нь хүний биеийн бясалгалаар гардаг ер бусын чадвартай салшгүй холбоотой. Эртний хүмүүс хүний биеийн бясалгалыг их чухалчилдаг байсан. Күнзийн сургууль, Дао-гийн сургууль, Буддын сургууль, тэр ч байтугай Күнзийн шашины сурагчид бүгд бясалгалыг эрхэмлэдэг. Завилж суун бясалгахыг нэг төрлийн чадварт тооцдог байсан, дасгал хийхгүй байсан ч тэд яваандаа гон болон ер бусын чадвар гаргах боломжтой. Хятадын зүү заслын эмчилгээ яаж хүний биеийн судлыг тийм тодорхой илрүүлж чадсан бэ? Яагаад зүүний цэгүүд хоорондоо хөндлөн холбогддоггүй вэ? Яагаад хөндлөн сүлжилддэггүй вэ? Яагаад босоо шугамаар холбогддог вэ? Яаж тийм нарийвчлалтай зураглал гаргаж чадсан бэ? Орчин үеийн ер бусын чадвартай хүмүүсийн харсан нь Хятадын тэдгээр эмч нарын зурсантай яг таардаг, учир нь эртний Хятадын нэртэй эмч нар голдуу ер бусын чадвартай байсан. Хятадын түүхэн дэхь, Ли Шижэнь, Сун Симиао, Биан Чуэ, Хуа Туо нар бүгд ер бусын чадвартай *чигон* их багш нар байсан. Хятад эмчилгээ нь одоог хүртэл уламжлагдсаар ирсэн, гэхдээ ер бусын чадвар нь орхигдоод, зөвхөн эмчилгээний арга нь үлдсэн. Эртний Хятад эмч нар нүдээрээ (ер бусын чадвараар) өвчнийг оношилдог байсан, дараа нь бас судас барих аргыг хөгжүүлсэн. Хэрэв Хятад эмчилгээний арга дээр ер бусын чадварыг нэмбэл Барууны эмчилгээ нь хичнээн жил болсон ч Хятад эмчилгээг гүйцэхгүй гэж хэлж болно.

Чигон эмчилгээ өвчний үндэс, эх үүсвэрийг арилгадаг. Би өвчнийг нэг төрлийн нүгэл гэж үздэг, өвчин эдгээнэ гэвэл нүглийг арилгана. Зарим *чигон* багш нар өвчнийг эдгээхдээ хар *чий*-г арилгахын тулд *чий* гадагшлуулах, *чий*

сэлгэх аргыг хэрэглэдэг. Доод түвшинд бол тэд хар *чий*-г гадагшлуулдаг гэхдээ хар *чий* үүсдэг үндсэн шалтгааныг мэддэггүй. Энэ хар *чий* дахиад бий болно, тэгээд өвчин дахина. Үнэндээ хар *чий* өвчнийг үүсгэдэг биш, хар *чий* байгаа нь зөвхөн өвчтөнийг таагүй болгодог. Харин өвчин үүсгэдэг үндсэн шалтгаан нь бол өөр орон зайд орших оюун ухаант амь бодь юм. Олон *чигон* багш үүнийг мэддэггүй. Энэ оюун ухаант амь бодь их айхтар, ердийн хүн хүрч чадахгүй, хүрж ч зүрхлэхгүй. Фалуны Гоны өвчнийг эдгээх арга нь шууд тэр амь бодь руу чиглэдэг, өвчин үүсгэсэн үндсэн зүйлийг авч хаядаг, мөн өвчтэй газар нэг хаалт суулгадаг, өвчин дахиад халдаж чадахгүй болно.

Чигон өвчнийг эдгээж чадна, гэхдээ энгийн хүний нийгмийн байдлыг үймүүлж болохгүй. Хэрэв өргөн хэмжээнд хэрэглэвэл энгийн хүний нийгмийн байдлыг үймүүлнэ, үүнийг бол зөвшөөрөхгүй, үйлчлэх нөлөө нь ч гэсэн сайнгүй болно. Та нар мэднэ, зарим хүн *чигон* оношлогооны клиник, *чигон* эмнэлэг, *чигон*-ы нөхөн сэргээх төв нээсэн. Тэд энэ бизнесийг нээхээс өмнө эмчилгээний үр дүн магад нэлээд сайн байсан, нээсний дараа эмчилгээний үр дүн огцом унадаг. Учир нь ер бусын арга хэрэглэж энгийн хүний нийгмийн үйл ажиллагааг гүйцэтгэж болохгүй. Тэгвэл мэдээж үр дүн нь энгийн хүний эмчилгээний аргатай адил болж доогуур түвшинд унана.

Ер бусын чадвараар хүний биеийн дотрыг давхарга давхаргаар нь харж болно, эмнэлэгт хөндлөн зүсэлт хийдэгтэй адил, биений зөөлөн эдүүд болон биений аль ч хэсгийг харж болно. Одоогийн СТ скайн тодорхой харж чаддаг ч тоног төхөөрөмж ашиглана, их цаг орно, их хэмжээний зургийн хальс хэрэглэнэ, их удаан бөгөөд өндөр өртөгтэй. Хүний ер бусын чадвар шиг ийм тохиромжтой, ийм нарийвчлалтай байж чадахгүй. Чигон багш нүдээ аниад л гүйлгээд хурдан харчихдаг, өвчтэй хүний аль ч хэсгийг тов тодорхой шууд хардаг. Энэ нь өндөр технологи биш гэж

үү? Өнөөдрийн энэ өндөр гэгдэх технологиос ч илүү дээгүүр юм. Гэхдээ ийм чадвар эртний Хятадад аль эрт байсан, энэ нь эртний өндөр түвшний технологи юм. Хуа туо Цао цао¹³ -гийн тархинд хавдар байгааг нь хараад түүнд хагалгаа хийх гэсэн. Цао цао үүнд итгээгүй, өөрийг нь алах гэж байна гэж бодоод Хуа туог баривчлуулсан. Яваандаа Цао цао тархины хавдраас болж нас барсан. Түүхэнд Хятадын их олон эмч ер бусын чадвартай байсан, зөвхөн орчин үеийн нийгэмд хүмүүс бодит зүйлээр хэт хөөцөлдөж эртний уламжлагдсан зүйлсийг мартсан.

Бидний дээд түвшний *чигон* бясалгал, уламжлагдсан зүйлсийг дахин судлах хэрэгтэй, үүнийг өвөлж авч хөгжүүлэх, хүний нийгмийн ашиг тусын тулд дахин хэрэглэх хэрэгтэй.

6.Буддын системийн Чигон ба Буддын шашин

Бид Буддын системийн *чигон*-ыг ярихад олон хүн ийм нэг бодолтой байдаг: Буддын систем Будда-д бясалгадаг болохоор тэд Буддын шашины зүйлийг хамааруулж боддог. Би үүнийг нухацтайгаар тодруулж хэлье, Фалунь Гон бол Буддын системийн *чигон*, энэ нь ариун, аугаа бясалгалын Ном, Буддын шашинтай уялдаа байхгүй. Буддын системийн *чигон* бол Буддын системийн *чигон*, Буддын шашин бол Буддын шашин. Бясалгалын зорилго нь адилхан ч, явах зам нь адилгүй, нэг номын үүднийх биш, шаардлага нь бас адилгүй. Би энд Будда гэдэг үгийг дурьдлаа, би дээд түвшинд бясалгал заахдаа дараа бас дурьдана, энэ үгэнд ямар ч мухар сүсэгийн шинж байхгүй. Зарим хүн Будда гэдэг үгийг сонсоод тэвчдэггүй, мухар сүсэг сурталчилж байна гэдэг, тийм биш юм. “Будда” нь Энэтхэгийн Санскрит хэлнээс үүсэлтэй. Энэтхэгээс Хятадад орж ирэхдээ Фо (Будда) Туо гэдэг хоёр үгээр дуудагддаг байсан, хүмүүс Туо

¹³ Цао цао- Гурван вант гүрний үеийн эзэн хаан (220-265 он)

гэдэг үгийг хасаад Фо гэдэг болсон, хятадаар орчуулвал “Тэгээрэгч” гэсэн үг, гэгээрсэн хүн.

1) Буддын системийн Чигон

Одоо нийтэд Буддын системийн *чигон*-ы хоёр төрөл байдаг. Нэг нь Буддын шашинаас үүсэлтэй, энэ нь хөгжлийнхөө хэдэн мянган жилийн явцад нэртэй, их олон лам хуврагуудыг төрүүлсэн. Бясалгагчид их өндөр түвшинд хүрэхэд, их багш тэд нарт зарим зүйлсийг заадаг, ингэснээр тэд улам дээд түвшний зүйлийг жинхэнэ уламжилж авдаг. Эдгээр зүйлсийг урьд нь Буддын шашинд үргэлж нэг л хүнд дангаар нь уламжилдаг байсан, дээд лам хувраг нас барахаасаа өмнө нэг л сонгосон шавьдаа уламжилдаг. Тэр Буддын шашины зарчим дагуу бясалгаад бүхэлдээ дээширнэ. Энэ төрлийн *чигон* Буддын шашинтай ойр холбоотой харагддаг. Сүүлд нь ялангуяа Соёлын их хувьсгалын үед лам хуврагууд хийдээс хөөгдсөн. Улмаар тэдгээр дасгалууд нь нийтийн дунд тархаж хөгжсөн.

Өөр нэг төрлийн *чигон* бас Буддын системийнх, энэ нь үеэс үед Буддын шашинд байгаагүй, үүнийг үргэлж ард түмний дунд юмуу эсвэл алс бөглүү ууланд чимээгүйхэн бясалгадаг байсан, эдгээр төрлийн бясалгал нь өөрийн онцлогтой. Тэд бүгд нэг маш сайн шавийг сонгох шаардлагатай, жинхэнэ дээд түвшинд бясалгаж чадах аугаа буянтай хүн байх ёстой. Ийм хүн дэлхийд их олон жилийн туршид нэг л удаа төрдөг, тэдгээр бясалгал нь зан чанар их өндөр байхыг шаарддаг, гон ч их хурдан дээширдэг болохоор нийтэд дэлгэрүүлж болохгүй. Ийм хэлбэрийн бясалгал цөөнгүй байдаг. Дао-гийн системд ч гэсэн адилхан, Доа-гийн *чигон* бүгд Дао-гийн системд харьяалагдана, энэ нь цааш Куньлун, Эмэй, Вудан гэх мэтээр хуваагддаг. Бүлэг болгон дотроо салбаруудтай, салбар бүрийн бясалгал хоорондоо их ялгаатай. Тэр бүгдийг хольж хамт бясалгаж болохгүй.

2) Буддын шашин

Буддын шашин бол 2000 гаруй жилийн өмнө Шагжамуни¹⁴ Энэтхэгт бясалгаж гэгээрээд өөрийн бясалгалын үндсэн дээр суурилан үүсгэсэн бясалгалын цогц систем. Үүнийг гурван үгэнд хураангуйлж болно: цээрлэх, самади¹⁵-д орох, гэгээрэх. Цээрлэх бол самади-д орохын тулд юм. Буддын шашинд дасгал хийдэггүй ч үнэндээ бол самади-д суухад дасгал хийж байгаатай адил юм, тэгээд хүн гүн амгаланд ордог. Яагаад гэвэл хүн амгаланд орж сэтгэлээ тайван болгоход орчлон ертөнцийн энерги түүний биеийн эргэн тойронд цуглардаг, *чигон* дасгал хийсэнтэй адил нөлөө гардаг. Буддын шашны цээрлэх нь хүний бүх дур хүслийг хориглох, энгийн хүний зууралддаг бүх зүйлийг орхих, ингэснээр лам хувраг амар амгалан, үйлгүй байдалд хүрнэ, тэгээд самадид орж чаддаг. Самадид байж тасралтгүйгээр түвшнөө дээшрүүлнэ, тэгээд яваандаа билиг оюун нь дэлгэрч гэгээрлийн хутагт хүрнэ, орчлон ертөнцийг танин мэдэж үнэн байдлыг харна.

Шагжамуни анх эхэлж номоо заан тараахдаа өдөр бүр зөвхөн гурван зүйлийг хийдэг байсан: шавь нартаа Ном ярина (гол нь Архатад хүрэх ном), аягаа бариад хоол гуйна, мөн самадид сууж бясалгана. Шагжамуни Будда энэ орчлонг орхисны дараа Брахман шашин Буддын шашинтай тэмцэлдэж эхэлсэн. Хожим энэ хоёр шашин нэгдээд Хинду шашин үүссэн. Иймээс Энэтхэгт одоо Буддын шашин байхгүй. Сүүлд хөгжил, өөрчлөлтийн явцад Буддын Их хөлгөн шашин гарч ирсэн, энэ нь Хятадад орж ирээд одоогийн Буддын шашин болсон юм. Их хөлгөн Буддын шашин Шагжамунийг зөвхөн ганц үндэслэгч гэж шүтдэггүй, харин олон Буддад шүтлэгтэй болсон, олон

¹⁴ Шагжамуни- Будда, Сидхарта Гаутама, Буддын шашныг үндэслэгч.

⁵ дугаар зууны үед (м.э.ө) эртний Энэтхэгт амьдарч байсан

¹⁵ Самади- Буддын системийн амгаланд суух бясалгал

Рулай¹⁶ бурханд итгэдэг, Будда Амитаба, Манал Бурхан гэх мэт, мөн цээрлэх зүйлс нь бас нэмэгдсэн, бясалгалын зорилго нь өндөр болсон. Шагжамуни тэр үед цөөхөн шавьдаа Бодьсадва¹⁷ номыг заасан, хожим эдгээр зүйлсийг цэгцлээд өнөөдрийн Их хөлгөн Буддын шашин болж хөгжсөн, Бодьсадва түвшин рүү бясалгадаг. Өнөөг хүртэл Өмнөд Ази хавиар Буддын Теревада шашин уламжлагдан үлдсэн, ер бусын чадвар хэрэглэн Номын зан үйлийг хийдэг. Буддын шашины хувьслын явцад бясалгалын нэг хэлбэр манай Түвдийн нутагт орж ирсэн, Түвдийн Тантрын шашин гэдэг. Өөр нэг бясалгалын хэлбэр нь Шинжианаар дамжаад Хан нутагт¹⁸ орж ирсэн, Тан Тантрын шашин гэдэг (энэ нь Хуйчань жилүүдэд Буддын шашин хавчигдах үед байхгүй болсон). Бас өөр нэг хэлбэр Энэтхэгт үүссэн, энэ нь Йог юм.

Буддын шашинд дасгал заадаггүй, бас *чигон* бясалгахгүй. Энэ нь Буддын шашины бясалгалын уламжлалт аргыг сахихын тулд юм, мөн Буддын шашин 2000 гаруй жил буураагүй уламжлагдан ирсэн гол шалтгаан нь юм. Энэ уламжлал нь жамаараа нарийн хадгалагдаж ирсэн, яагаад гэвэл гадны юуг ч хүлээж авдаггүй. Буддын шашинд бясалгалын олон арга байдаг, бүгд адилгүй. Бага хөлгөн (Теревада) Буддын шашин өөрийгөө аврах, өөрийгөө бясалгахад анхаардаг. Их хөлгөн Буддын шашин өөрийгөө ч аврах, бусдыг ч аврах, бүх амийг аврахад байдаг.

¹⁶ Рулай- (Татагата) Буддын системийн гэгээрлийн хутагт хүрсэн гэгээрэгч, Бодьсадва, Архад түвшнөөс дээгүүр

¹⁷ Бодьсадва- Буддын системийн гэгээрлийн хутагт хүрсэн гэгээрэгч, Архад-аас дээгүүр Рулай-гаас доод түвшинд гэгээрэгч

¹⁸ Хан нутаг- Хан үндэстэн Хятадын хамгийн том үндэстэн, Хятадын төв мужийн ихэнх хэсгийг эзэлсэн (Түвд гэх мэт)

7. Ариун номын бясалгал ба буг чөтгөрийн зам

1) Хажуу үүдний болхи зам (Панмен Зуодао)

Хажуу үүдний болхи зам бас уламжлалт бус Чиймэнь бясалгал гэж нэрлэгддэг. Шашин үүсэхээс өмнө янз бүрийн *чигон*-ы урсгал оршиж байсан, шашинаас гадна олон төрлийн бясалгалууд ард түмний дунд тархсан байдаг. Ихэнх нь системтэй номлол байхгүй учраас бүрэн төгс бясалгалын систем болж чадаагүй, харин Чиймэнь бясалгал бол системтэй бүрэн цогц бясалгалын аргатай, бас ард түмний дунд уламжлагдсан. Энэ системийн бясалгал нь хажуу үүдний болхи замын гэж хэлэгддэг, яагаад хажуу үүдний болхи зам гэдэг вэ? Үгний утганаас үзвэл "Панмен" гэдэг нь хажуу үүдний гэсэн утгатай, "Зуодао" гэдэг нь болхи гэсэн утгатай юм. Хүмүүс Будда, Дао хоёр системийн бясалгалыг гол замын гэж үздэг, бусад бүх бясалгалын аргуудыг хажуу үүдний болхи замын, эсвэл буг чөтгөрийн замын гэж үздэг, үнэндээ тийм биш юм. Хажуу үүдний болхи замаар үеэс үед үргэлж нууцаар бясалгадаг байсан, нэг л шавьд заадаг, нийтэд ил гаргаж болохгүй, ил болгосон ч хүмүүст ойлгоход хэцүү. Тэдний бясалгагчид энэ бясалгалаа Буддынх ч биш, Дао-гийх ч биш гэдэг, түүний бясалгалын арга нь зан чанарын хатуу шаардлагатай, тэд орчлон ертөнцийн мөн чанарын дагуугаар бясалгадаг, сайн үйл хийхийг ярьдаг, зан чанарыг эрхэмлэдэг. Бясалгаад өндөрт хүрсэн багш бүр онцгой чадвартай байдаг, зарим онцгой арга барил нь их хүчтэй. Би Чиймэнь бясалгалын их өндөрт хүрсэн гурван багштай уулзаж байсан, тэд надад Будда, Бумба хоёр системд байдаггүй зарим зүйлийг уламжилсан. Эдгээр зүйлсийг бясалгалын явцад гаргахад нэлээд хэцүү, бясалгаж гаргасан *гон* нь бас онцгой. Харин одоогийн тархсан зарим Буддын, Дао-гийн гэж нэрлэгдсэн бясалгалын аргуудад зан чанарын хатуу шаардлага дутмаг байдгаас дээд түвшинд бясалгаж чаддаггүй, иймээс бид бясалгалын арга бүрийг бодитоор харах ёстой.

2) Ушу Чигон

Ушу *чигон* бол өнө эртний түүхээс өмнө бий болсон, нэг бүрэн цогц онолын системтэй бөгөөд бясалгалын аргатай, өөрийн бие даасан системтэй, гэхдээ шууд хэлэхэд зөвхөн хамгийн доод түвшний дотоод бясалгалын аргад гардаг ер бусын чадвар илэрдэг. Ушу бясалгалаар гардаг ер бусын чадвар нь дотоод бясалгалын аргаар бясалгахад бас бүгд гардаг. Ушу *чигон*-ы бясалгалд бас *чий* хийн дасгалаас эхэлж хийдэг. Жишээ нь, чулууг цохиж бутлахдаа эхлээд гараа эргүүлж чийг гүйлгэнэ, яваандаа *чий*-н чанар өөрчлөгдөж энергийн бөөгнөрөл үүсдэг. Энэ нь туяа хэлбэрээр оршдог, ийм хэмжээнд хүрэхэд *гон*-ы нөлөө гарч эхэлдэг. Яагаад гэвэл *гон* бол сэтгэхүйтэй дээд зэргийн бие бодь, тэр тархины бодлоор удирдагддаг, өөр орон зайд оршдог. Тулалдаанд Ушу-гаар бясалгагч *чий* гүйлгэх хэрэггүй, нэг бодоход л гон нь ирчихдэг. Бясалгалын явцад гон тасралтгүй улам хүчтэй болно, улам нарийн ширхэгтэй болж нягтарна, энерги нь улам ихэсдэг. Төмөр элсэн алга болон Улаан алга гэдэг чадвар гардаг. Сүүлийн хорин жилд гарсан Алтан хонхон хуяг ба Төмөр цамц гэдэг чадварыг бид кино, сэтгүүлээс мөн телевизийн тоглолтноос харж болно, эдгээр нь Ушу болон дотоод бясалгалаар зэрэг хичээллэснээс үүссэн. Энэ нь дотоод гадаад хос бясалгалаас гарсан. Дотогшоо бясалгавал буяныг чухалчилна, зан чанарыг бясалгана, онолоор яривал хүний чадвар тодорхой хэмжээнд хүрэхэд гон биений дотроос гадагш цацарч гардаг. Энэ нь өндөр нягтшилтай болохоор хамгаалах бүрхүүл болдог. Зарчмын хувьд Ушу болон дотоод бясалгалын хамгийн том ялгааг хэлбэл, Ушу-г бол ширүүн хөдөлгөөнөөр хийдэг, амгалан байдалд ордоггүй. Амгалан байдалд ордоггүй учраас *чий* даньтиан¹⁹ руу орохын оронд арьсан доогуур булчин дундуур гүйдэг. Тиймээс амийг бясалгадаггүй, бясалгах ч боломжгүй.

¹⁹ даньтиан- хэвлийн доод хэсэгт оршдог үрлийн талбай

3) Урвуу бясалгал ба Гон зээлдэх

Зарим хүн *чигон*-оор хэзээ ч хичээллэж байгаагүй. Гэтэл *гон* гэнэт ирдэг, бас нэлээд хүчтэй энергитэй, хүний өвчнийг ч эдгээж чадна. Хүмүүс түүнийг *чигон* багш гэж дуудна, тэр бас хүмүүст зааж өгнө. Зарим нь ямар ч *чигон*-оор хичээллэж байгаагүй ч хэдхэн сурсан хөдөлгөөнөө жоохон өөрчлөөд хүмүүст заадаг. Ийм хүнийг *чигон* багш гэж болохгүй, тэр хүнд уламжилж өгөх юу ч байхгүй. Түүний заасан зүйл нь дээд түвшин рүү үнэндээ бясалгуулж чадахгүй, сайндаа өвчин эдгээх, бие сайжруулахад л тустай. Тийм *гон* хаанаас ирсэн бэ? Эхлээд урвуу бясалгалын талаар ярья. Урвуу бясалгал бол өндөр зан чанартай, маш сайн хүмүүст хамаатай, голдуу настай хүмүүс, тавиас дээш насныхан байдаг. Тэдний хувьд эхнээс нь бясалгахад нас нь хүрэхгүй болсон, амь бие сэтгэлийн хос бясалгал заадаг их багшийг олоход бас амаргүй. Тийм хүнд бясалгах хүсэл төрөхөд өндөр түвшний их багш түүний зан чанарт үндэслэн их хэмжээний гон энерги өгч дээрээс доош урвуу бясалгах боломж олгоно, ийм замаар бясалгахад хурдан. Өндөр түвшний багш өөр орон зайнд түүний биений гаднаас *гон* энерги хувиргаж өгч тасралтгүйгээр нэмж байдаг, тухайлбал хүний өвчнийг үзэж өгөхөд энергийн хүрээ үүсэх байдал юм. Их багшийн өгөх энерги хоолойгоор дамжуулж байгаа мэт урсдаг, зарим хүн энэ энерги хаанаас ирснийг ч мэдэхгүй, энэ бол урвуу бясалгал.

Бас өөр нэг төрөл бол гон зээлэх юм. Гон зээлэхэд насны хязгаар байхгүй, хүнд Эзэн сүнснээс гадна Дэд сүнс байдаг, ер нь Дэд сүнсний түвшин Эзэн сүнснийхээс дээгүүр байдаг. Зарим хүний Дэд сүнсний түвшин маш өндөр, гэгээрэгчтэй харьцаж чаддаг, иймэрхүү хүн бясалгахыг хүсвэл түүний Дэд сүнс бас түвшинөө дээшлүүлэх хүсэлтэй, тэр даруй *гон* зээлэхээр аугаа гэгээрэгчтэй холбогддог. Гон зээлсэний дараа нэг шөнийн дотор тэр *гон*-той болно, *гон* ирсэний дараа хүн үзэж өвчнийг нь намдааж чаддаг болно. Тэр хүн голдуу энергийн хүрээ үүсгэх арга хэрэглэдэг, бас

дангаараа хүнд энерги өгч чадна, зарим арга барилыг зааж чаддаг.

Гол төлөв ийм хүн эхэндээ их дажгүй сайн байдаг, *гон*-той болсны дараа нэр хүндтэй болно, нэр хүнд ашиг хоёуланг нь олж авна. Бодолд нь бясалгалаас илүү нэр хүнд ашиг л орж ирнэ. Тэгээд үүнээс хойш *гон* нь доош унана, унасаар байгаад эцэст нь юу ч байхгүй болно.

4) Сансрын хэл

Зарим хүмүүс гэнэт нэг янзын хэлээр ярьдаг, уг хэлээр чөлөөтэй ярьдаг, гэхдээ энэ нь хүн төрөлхтний нийгмийн хэл биш. Үүнийг юу гэдэг вэ? Сансрын хэл гэдэг. Сансрын хэл нь өндөр түвшний биш амь бодийн хэл юм. Одоо орон даяар ийм байдал *чигон*-оор бясалгадаг зарим хүнд гарсан, тэр ч байтугай зарим хүн нэлээд хэдэн төрлийн хэлээр ярьж чадна, мэдээж бидний хүн төрөлхтний хэл бас нарийн төвөгтэй, мянга гаруй төрөл байдаг. Санасарын хэл нь ер бусын чадвар мөн үү? Би хэлбэл биш юм, чиний өөрийн ер бусын чадвар биш, гаднаас чамд ирсэн ер бусын чадвар ч биш, харин гадны амь бодиор удирдуулсан юм. Энэ амь бодь арай дээд түвшнөөс ирсэн, дор хаяж бидний хүн төрөлхтний түвшнөөс дээгүүр, түүний ярьж байгаа үг юм. Сансрын хэлээр ярьж байгаа хүн зөвхөн дамжуулах үүрэг гүйцэтгэж байгаа юм. Ихэнх хүмүүс өөрсдөө ямар утгатай үг хэлж байгаагаа мэдэхгүй, зөвхөн хүний бодлыг уншдаг ер бусын чадвартай хүн ерөнхий утгыг нь гадарлана. Энэ бол ер бусын чадвар биш, тэд энэ хэлээр ярьсныхаа дараа өөрийгөө гоц гойд гэж боддог, ер бусын чадвартай гэж боддог. Үнэндээ дээд түвшний тэнгэрийн мэлмийтэй хүн харахад нэгэн амь бодь түүний дээрээс амаар нь дамжуулан ярьж байдаг.

Тэр амь бодь хүнд зарим энергээ дамжуулан сансрын хэлийг зааж өгдөг, гэхдээ энэ хүн үүнээс хойш түүний удирдлаганд орно, энэ бол ариун ном биш. Тэр амь бодь

арай дээд орон зайн түвшинд байгаа ч ариун номоор бясалгадаггүй, тиймээс бясалгагчдад яаж өвчнөө арилгах биеэ сайжруулахыг зааж мэдэхгүй, тэгээд яриагаар энерги гаргах ийм аргыг хэрэглэдэг. Яагаад гэвэл энэ нь цацардаг, бага хэмжээний энергитэй, хөнгөн өвчнийг эдгээж чадна, харин хүнд өвчнийг бол чадахгүй. Буддын шашинд тэнгэрийнхэнд зовлон байхгүй, зөрчил байхгүй учраас бясалгах аргагүй, өөрийгээ хатуужуулж чадахгүй, түвшнөө дээшлүүлэх боломжгүй гэж ярьдаг. Иймээс хүний өвчнийг эдгээж, биеийг нь сайжруулж өгч түвшнөө дээшлүүлэх арга зам хайдаг. Сансрын хэл гэж ярьдаг нь энэ юм, энэ нь ер бусын чадварч биш, бас *чигон* ч биш.

5) Сүнс шүглэх

Доод түвшний амь бодийн сүнс шүглэх нь хамгийн их хор хөнөөлтэй. Энэ бол буруу замаар бясалгаснаас болдог. Энэ нь хүнд үнэхээр их хор уршигтай, сүнс шүглэсэн хүнд ирэх үр дагавар нь тун аймшигтай. Зарим хүн *чигон*-оор хичээллэж эхлээд л хүний өвчнийг үзэж өгөх, баян болох гэсэн сэтгэлд автдаг, дандаа ийм зүйл боддог. Анхандаа энэ хүн магадгүй нэлээд сайн байсан, эсвэл хариуцах багштай байсан. Гэхдээ түүнд өвчин эдгээх, баян болох бодол гарахад болохоо байна, сүнсийг өөртөө татдаг, бидний энэ материаллаг орон зайд байхгүй ч гэсэн үнэхээр оршдог.

Тийм бясалгагчид тэнгэрийн мэлмий нь гэнэт нээгдэж бас *гон*-той болсон мэт санагддаг, үнэндээ бол шүглэсэн сүнс түүний тархийг удирддаг, тэр сүнс харсан зүйлээ хүний тархинд тусгахад тэр хүний тэнгэрийн мэлмий нь нээгдсэн мэт болдог, үнэндээ бол тийм биш, ердөөсөө нээгдээгүй юм. Яагаад тэр шүглэсэн сүнс, амьтан тэр хүнд *гон* өгч байгаа вэ? Яагаад түүнд тусалж байгаа вэ? Яагаад гэвэл бидний энэ орчлон ертөнцөд амьтан бясалгаад үр дүнд хүрэхийг зөвшөөрдөггүй, амьтан зан чанарын талаар юу ч мэдэхгүй, дээширч чадахгүй учраас ариун ном олохыг зөвшөөрөхгүй. Тиймээс тэд хүний биед шүглэж хүний биеийн охь авахыг

хүсдэг. Орчлон ертөнцөд бас нэг зарчим байдаг, алдахгүй бол олдохгүй. Тэр чиний нэр ашгийн хүслийг хангадаг, чамайг баян болгоно, чамайг нэрд гаргана, тэгэхдээ тэр зүгээр чамд туслахгүй, тэр бас олно, чиний охийг авна. Тэр чамаас явахад чамд юу ч үлдэхгүй, маш сул биетэй хоцорно, хэвтрийн хүн болгоно! Энэ нь чиний доройтсон зан чанараас болсон. Нэг ариун бодол зуун хорон санааг дардаг, чиний сэтгэл ариун байвал муу зүйл ирэхгүй, өөрөөр хэлбэл ариун журмын бясалгагч бол ямар ч замбараагүй зүйлийг хүлээж авахгүй, зөвхөн ариун номоор л бясалгана.

б) Ариун номоор бясалгахад бас буруу замын бясалгал руу орж болно.

Зарим хүн ариун номоор бясалгаж байсан ч өөрийгөө хатуу шаардахгүй, зан чанарыг эрхэмлэхгүй, дасгал хийхдээ үргэлж муу юм боддогоос болж санамсаргүйгээр буруу замын бясалгалд орчихдог. Жишээ нь, дасгалын үед багана зогсолт хийж байхдаа, бясалган сууж байхдаа мөнгө, нэр ашиг бодож байдаг. Эсвэл, тэр намайг буруутгасан, ер бусын чадвар гарвал түүнийг чадна, ийм ч тийм ч ер бусын чадвартай болохыг хүсэх гэх мэт муу зүйлийг бясалгалдаа оруулбал үнэндээ буруу замаар бясалгасан болно. Энэ бол тун аюултай, магадгүй зарим муу зүйлийг татаж ирүүлнэ, доод түвшний амь бодь сүнс гэх мэт. Тэр өөрөө үүнийг татаж ирүүлснээ ч мэдэхгүй. Тэр их хүчтэй зууралдсан сэтгэлтэй, хөөцөлдөх сэтгэлээр бясалгал сурвал болохгүй. Түүний сэтгэл ариун бус, багш нь ч түүнийг хамгаалах аргагүй. Иймээс бясалгадаг хүн зан чанараа хатуу сахих ёстой, юугаар ч хөөцөлдөхгүй сэтгэл ариун байх ёстой, эс бөгөөс асуудал гарна.

Хоёрдугаар бүлэг

Фалунь Гон

Фалунь Гон нь Буддын системийн Фалунь Шиюлиан Дафагаас үүсэлтэй. Энэ бол Буддын системийн *чигон* бясалгалын онцгой аргуудын нэг, гэхдээ Буддын системийн бясалгалын энгийн аргатай адилгүй онцгой шинж чанартай. Энэ бясалгалын систем бол их онцлог, эрчимт бясалгалын арга нь бясалгагчаас маш өндөр зан чанар, аугаа төрөлхийн суурьтай байхыг шаарддаг байсан. Олон бясалгагчдыг дээшрүүлэх, мөн их хэмжээний бясалгах хүсэлтэй хүний хүслийг хангахын тулд энэ цогц бясалгалын аргыг дахин өөрчилж өргөн хэмжээнд дэлгэрүүлэхэд тохиромжтой болгосон. Өөрчлөлт оруулсан ч гэсэн энэ бясалгал нь бусад бясалгалын заадаг зүйлийн түвшнөөс маш хол давсан хэвээр.

1. Фалуний үйл ажиллагаа

Фалунь Гоны Фалунь нь орчлон ертөнцтэй ижил мөн чанартай, энэ нь орчлон ертөнцийн хураангуй дүрс. Фалунь Гон-ы бясалгагчид ер бусын чадвар, гон хүчээ хурдан өсгөөд зогсохгүй бас маш богино хугацаанд зүйрлэшгүй хүчирхэг Фалунийг бясалган гаргаж чадна. Фалунь үүсч дараа нь нэг төрлийн оюун ухаант амь бодь болон оршдог. Энэ нь бясалгагчийн хэвлийн доод хэсэгт автоматаар зогсолтгүйгээр эргэнэ, тасралтгүйгээр орчлон ертөнцөөс энергийг татан авч хувиргана, улмаар энергийг бясалгагчийн үндсэн биед гон болгон хувиргана. Ингэснээр Ном хүнийг бясалгах нөлөө гардаг, өөрөөр яривал хүн үргэлж бясалгал хийгээгүй байсан ч Фалунь тасралтгүйгээр хүнийг бясалгаж байдаг. Фалунь дотогш өөрийгөө аварна, тэр хүнийг хүчтэй, эрүүл, ухаан санааг саруул болгоно, бясалгагчийг буруу хазайхаас хамгаална, мөн муу зан чанартай хүний үймүүлээс хамгаалдаг. Фалунь гадагшаа бусдыг аварна, хүний өвчнийг эдгээж, буг чөтгөрөөс

зайлуулж чадна, бүх буруу байдлыг засна. Фалунь хэвлийн доод хэсэгт зогсолтгүйгээр эргэдэг, цагийн зүүний дагуу есөн удаа эргэсний дараа цагийн зүүний эсрэгээр есөн удаа эргэнэ. Цагийн зүүний дагуу эргэхдээ орчлон ертөнцөөс энергийг их эрчимтэй шингээн авдаг, тэр энерги нь маш хүчтэй. Хүний гон хүч өсөхийн дагуу эргэх хүч нь улам хүчтэй болдог, хүн *чий*-г толгойн орой луугаа санаатайгаар оруулах замаар хэзээ ч тийм байдалд хүрч чадахгүй. Цагийн зүүний эсрэгээр эргэхдээ энергийг гаргадаг, бүх амийг авардаг, зүй бус байдлыг засдаг, бясалгагчийн эргэн тойронд байгаа хүмүүст ашигтай. Манай оронд заан тараагдсан бүх *чигон* бясалгалын дундаас Фалунь Гон бол Ном хүнийг бясалгадаг цорын ганц бясалгалын арга юм.

Фалунь бол хамгийн нандин зүйл, хичнээн их мөнгөөр ч сольшгүй. Миний багш надад Фалунь дамжуулж өгөхдөө Фалунийг өөр хэнд ч дамжуулж өгч болохгүй, үүнийг мянган жил түүнээс ч олон жилээр бясалгасан хүн олж авахыг хүссэн ч олж авч чадахгүй гэж хэлсэн. Бусдаас ялгаатай нь энэ бясалгалын системийг маш урт хугацааны дараа зөвхөн нэг л хүнд уламжилж болно, хэдэн арван жил тутамд нэг хүнд уламжилдагтай адилгүй. Тиймээс Фалунь бол туйлын нандин, бид одоо үүнийг бага хүчтэй болгон нийтэд зориулж өөрчилсөн ч гэсэн туйлын нандин хэвээр. Үүнийг олсон бясалгагч бясалгалынхаа дунд хүрсэн, чамд зөвхөн зан чанараа дээшлүүлэх үлдсэн, мөн нэлээд дээд түвшин чамайг хүлээж байна. Мэдээж хувь тавилангаар олоогүй хүмүүс хэсэг бясалгаж байгаад магадгүй болино, тэгээд тэдэнд Фалунь байхгүй болно.

Фалунь Гон бол Буддын системийнх, гэхдээ Буддын системийн хүрээнээс хол давсан, Фалунь Гон бүх орчлон ертөнцийн дагуу бясалгадаг. Урьд Буддын системд зөвхөн Буддын системийн зарчмыг, Дао-гийн системд зөвхөн Дао-гийн системийн зарчмыг л ярьдаг байсан, аль нь ч ертөнцийг үндсээр нь дэлгэрэнгүй тайлбарлаагүй. Орчлон

ертөнц бол материаллаг бүтэцтэйгээс гадна өөрийн гэсэн мөн чанартайгаараа хүнтэй адилхан. Энэ мөн чанарыг гурван үгээр хураангуйлж болно: Жэнь-Шань-Рэн (Үнэн-Нинжин-Тэвчээр). Дао-гийн системийн бясалгалд гол анхаардаг нь Жэнь: үнэн хэлэх, шударга үйл хийх, өөрийнхээ эх үндэс жинхэнэ өөртөө буцаж эцэст нь үнэн хүн болох. Буддын системийн бясалгалд гол анхаардаг нь Шань: аугаа нинжин гарна, бүх амь бодийг аврах юм. Манай бясалгалд Жэнь, Шань, Рэн-ийг хамтад нь бясалгана, шууд орчлон ертөнцийн мөн чанар дагуу бясалгана, яваандаа орчлон ертөнцтэй ижилсэх юм.

Фалунь Гон бол амь бие, сэтгэлийн хос бясалгал, энэ орчлонд бясалгагчийн гон хүч болон зан чанар тодорхой түвшинд хүрэхэд тэр хүн Гэгээрэх (Гон чөлөөлөгдөх) байдалд мөн очирваань сүйдэшгүй бие олох байдалд хоёуланд нь хүрнэ. Фалунь Гон Гурамсан ертөнцийн ном, Гурамсан ертөнцөөс гарсан ном гэж хоёр хуваагддаг, энэ нь маш олон түвшнийг багтаадаг. Би бүх тууштай бясалгагчдыг шаргуу бясалгаж зан чанараа үргэлж дээшлүүлж Гэгээрлийн хутагт хүрэхийг хүсч байна.

2. Фалуний бүтэц

Фалунь Гон-ы Фалунь оюун ухаант, эргэлдэж байдаг дээд энергийн бие бодь юм. Фалунь орчлон ертөнцийн хөдлөх аугаа зүй тогтлын дагуу эргэдэг, өөрөөр хэлбэл Фалунь бол орчлон ертөнцийн хураангуй дүрс.

Фалуний голд нь Буддын системийн сриватса 卍 хас тэмдэг байдаг, (Санскрит хэлээр сриватса гэдэг нь “бүх сайн сайхны бэлэг тэмдэг” гэж Ци Хайн толь бичигт байдаг), энэ бол Фалуний зүрхэвч. Үүний өнгө нь алтан шаргал, суурь өнгө нь тод улаан өнгөтэй, гаднах хүрээний суурь өнгө нь

улбар шар өнгөтэй. Дөрвөн Тайжи тэмдэг, мөн Буддын системийн дөрвөн сриватса тэмдэг найман талд нь солбин байрладаг. Улаан хар өнгөтэй Тайжи нь Дао-гийн системийнх, улаан цэнхэр өнгөтэй Тайжи нь эртний аугаа Дао-гийнх. Дөрвөн жижиг сриватса 卐 бас алтан шар өнгөтэй, Фалуний суурь өнгө нь улаан, улбар шар, шар, ногоон, цэнхэр, хөх, ягаан өнгөөр ээлжлэн солигдож байдаг, өнгө нь маш гоё (номын эхний хуудсан дахь зураг), голд байгаа сриватса 卐 болон Тайжи өнгө нь өөрчлөгдөхгүй. Эдгээр том жижиг сриватса 卐 тэмдгүүд болон Фалунь өөрөө эргэдэг. Фалунь орчлон ертөнцөд үндэс суурьтай, орчлон ертөнц эргэж байдаг, бүх галагтикууд эргэж байдаг иймээс Фалунь бас эргэж байдаг. Тэнгэрийн мэлмий нь доогуур түвшинд нээгдсэн хүн Фалунийг сэнс шиг эргэж байгааг хардаг, тэнгэрийн мэлмий нь өндөр түвшинд нээгдсэн хүн Фалуний байдлыг бүхэлд нь харж чаддаг, энэ нь маш гайхамшигтай гоё, туяарсан байдаг, бясалгадаг хүн үүнийг хараад улам идэвхтэй бясалгах, хурдан дээшлэх урам зориг ордог.

3. Фалунь Гон бясалгалын онцлог

1) Ном хүнийг бясалгах

Фалунь Гоныг бясалгадаг хүмүүс *гон* хүч ба ер бусын чадвараа хурдан өсгөх төдийгүй, Фалунийг бясалгаж гаргана. Фалунь богино хугацаанд үүсдэг, үүсмэгц хүч нь нэлээд их, энэ нь бясалгагчийг буруу хазайхаас болон муу зан чанартай хүмүүс хөндлөнгөөс саад учруулахаас хамгаалдаг. Фалунь Гоны онол нь уламжлагдсан бясалгалын аргуудаас огт өөр. Яагаад гэвэл Фалунь үүссэний дараа зогсолтгүйгээр эргэдэг, нэг төрлийн оюун ухаант амь бодь хэлбэрээр оршдог, бясалгагчийн хэвлийн доод хэсэгт зогсолтгүйгээр энергийг цуглуулдаг. Фалунь эргэхдээ орчлон ертөнцөөс энергийг автоматаар татдаг. Фалунь зогсолтгүйгээр эргэдэг болохоор Ном хүнийг

бясалгадаг болох зорилгод хүрсэн, өөрөөр яривал дасгалаа хийгээгүй үед ч, Фалунь зогсолтгүйгээр хүнийг бясалгадаг. Энгийн хүмүүс өдөр ажилтай, орой нь амрах тул дасгал хийх цаг маш бага байдгийг та бүгд мэднэ. Дасгалаа хийхийг үргэлж бодоод ч өдөрт 24 цаг тасралтгүй хийж чадахгүй, ямар ч арга хэрэглээд өдөржин дасгалаа хийх зорилгод хүрч чадахгүй. Харин Фалунь тасралтгүй эргэдэг, дотогшоо эргэхдээ орчлон ертөнцөөс маш их хэмжээний *чий* татан авдаг (энергийн орших эхний үеийн хэлбэр). Фалунь бүх зүгээс татаж авсан *чий*-г өдөр шөнөгүй хурааж хувиргадаг. Энэ нь *чий*-г дээд түвшний бие бодь болгон хувиргана, улмаар бясалгагчийн биед *гон* болон хувирна. Үүнийг Ном хүнийг бясалгах гэдэг. Фалунь Гонь бясалгал нь үрлийг бясалгадаг бусад бүх *чигон* бясалгалын аргаас огт өөр.

Фалунь Гон-ы гол онцлог нь Фалунийг бясалгана, үрлийг бясалгахгүй. Өнөөг хүртэл нийтэд тархсан бүх бясалгалын аргууд аль ч номын үүдний бясалгал байсан, Буддын шашин, Даогийн шашины урсгалууд эсвэл, Буддын систем, Даогийн системийнх, эсвэл нийтэд уламжлагдсан бүх бясалгалын аргууд бүгд үрлийг бясалгадаг. Тиймээс хажуу үүдний бясалгал маш олон байдаг, эдгээрийг үрлийн *чигон* арга гэдэг. Лам хувраг, хандмаа, Дао-чид үрлийг бясалгах энэ замаар явдаг. Ийм хүмүүсийг нас барсны дараа чандарлахад сарира²⁰ гардаг, одоогийн шинжлэх ухааны тоног төхөөрөмжөөр түүний бүтцийг судалж чадахгүй, маш хатуу үзэсгэлэнтэй бодис. Үнэндээ бол энэ нь өөр орон зайнаас цугларсан дээд энергийн бодис, манай орон зайных биш, энэ бол тэр үрэл юм. Үрлийн замын *чигон* бясалгалаар нэг амьдралын насандаа гэгээрэлд хүрнэ гэвэл маш хэцүү, урьд үрлийн замаар бясалгадаг маш олон хүн үрлийг дээш гаргах гэж оролддог байсан, Ниван²¹ ордонд хүрээд дээш

²⁰ сарира- зарим бясалгагчийн чандарт үлддэг тусгай зүйл, чулуун сувд

²¹ Ниван ордон- Дао-д булцуут булчирхайг хэлдэг

явахаа больчихдог, тэгээд тэнд гацаад тэр хүн нас бардаг байсан. Зарим хүн үүнийг зориудаар задлах гэж оролддог, гэхдээ тэгэх арга байхгүй. Зарим ийм тохиолдол байсан: Нэг хүний өвөө нь бясалгаад үр дүнд хүрч чадаагүй, нас барахынхаа өмнө үрлийг амаараа гаргаж аавд нь дамжуулж өгсөн, аав нь үр дүнд хүрч чадахгүй нас барахаасаа өмнө үүнийг мөн амаараа гаргаж хүүдээ дамжуулсан. Одоог хүртэл энэ хүн бас л амжилтанд хүрч чадаагүй, энэ бол маш хэцүү! Мэдээж бясалгалын олон сайн арга байдаг, хэн нэгнээс жинхэнэ уламжлагдсан зүйл заалгавал муугүй, гэхдээ тэр чамд дээд түвшний зүйл уламжилсан уу үгүй гэдгээс шалтгаална.

2) Эзэн бодлоо бясалгах

Хүн болгон эзэн бодолтой, юм хийх, бодохдоо гол төлөв эзэн бодлоор болдог. Хүнд эзэн бодлоос гадна бас нэг эсвэл хэд хэдэн дэд бодол байдаг, мөн төрөл угсаанаас, өвөг дээдсээс уламжилсан мэдээлэл байдаг. Дэд сүнс эзэн сүнстэй адилхан нэртэй, гэхдээ ер нь эзэн сүнснээс илүү чадвартай, түвшин нь өндөр байдаг. Тэр бидний энгийн хүний нийгэмд төөрдөггүй, өөрийн тухайн орон зайг харж чаддаг. Маш олон бясалгал бүгд Дэд сүнсийг бясалгах замаар явдаг. Хүний махан бие, Эзэн сүнс нь тэдгээрийг зөвхөн тээх унаа нь болдог. Тэр *чигон* бясалгагч энэ зүйлийг мэдэхгүй, тэр ч байтугай өөртөө сэтгэл хангалуун байдаг. Хүн нийгмийн дунд амьдарч байхад бодит зүйлсийг орхих маш хэцүү, ялангуяа тэр зууралдсан, автсан зүйлээсээ салахад амаргүй. Иймээс маш олон бясалгал амгалан байдалд дасгал хийхийг чухалчилдаг, гүн ховсдолын байдалд. Ийм байдалд бясалгагчийн *гон* хувиралт явагддаг, үнэн хэрэгтээ түүний Дэд сүнсэнд хувирал гарч дээшилж байдаг, гэхдээ өөр орон зайн нийгмийн байдалд болдог. Нэг өдөр түүний Дэд сүнс бясалгаад дээширнэ, тэр чиний *гон*-ыг аваад явчихдаг, чиний Эзэн сүнс болон бодит биенд юу ч үлдэхгүй, чиний энэ насны бясалгал үр дүнгүй болно, маш харамсалтай. Зарим нэртэй *чигон* багшид янз бүрийн ер

бусын чадвар байдаг, мөн их нэр хүндтэй, гэхдээ тэр өөрийнх нь бие дээр түүний *гон* оршдоггүй гэдгийг мэдэхгүй.

Манай Фалунь Гон бол Эзэн бодлоо бясалгадаг, гон бодитоор чиний бие дээр өсөхийг шаарддаг, мэдээж Дэд бодол бас хувь хүртэнэ, тэр хоёрдугаар байранд дагаж дээширнэ. Манай бясалгалд зан чанарт хатуу шаардлага тавьдаг, чамд энгийн хүний нийгэмд, хамгийн төвөгтэй хэцүү орчинд зан чанараа хатуужуулж дээшрэх боломж олгоно, лянхуа цэцэг шавартай уснаас гарч дэлбээлдэг шиг. Ийм учраас чи бясалгаад үр дүнд хүрч чадна. Фалун Гон ийм л нандин юм, яагаад гэвэл чи өөрөө гон олж авна. Тэгэхдээ бас их хэцүү, хэцүү нь чи хамгийн ээдрээтэй төвөгтэй орчинд өөрийгөө хатуужуулах, сорих замаар явна.

Манай бясалгалын зорилго нь Эзэн бодлыг бясалгах учраас үргэлж Эзэн бодлоор өөрийгөө удирдаж дасгалаа хийх ёстой, Дэд бодол биш харин Эзэн бодол шийдвэр гаргах ёстой. Тэгэхгүй бол нэг өдөр Дэд сүнс дээд түвшинд бясалгаад үр дүнд хүрч гоноо аваад явчихна, харин чиний бодит биед болон Эзэн сүнсэнд юу ч үлдэхгүй. Чи дээд түвшинд бясалгахад чиний Эзэн бодол унтсан юм шиг юу хийж байгаагаа мэдэхгүй байж болохгүй, чи өөрөө дасгал хийж байгаа, дээшээ бясалгаж байгаа, зан чанараа дээшлүүлж байгаа гэдгээ мэдэж байх ёстой, зөвхөн тэр үед чи өөрийн мэдэлд байна, *гон* олж чадна. Заримдаа чи өөрийн ухаангүйгээр ямар нэгэн зүйлийг хийчихэж магад, яаж хийснээ ч мэдэхгүй. Энэ бол үнэндээ чиний Дэд бодол нөлөөлсөн, Дэд бодлоор удирдуулсан юм. Жишээ нь, чи бясалгаж суухдаа нүдээ нээн харахад чиний эсрэг талд өөр бас нэгэн чи сууж байвал тэр бол чиний Дэд сүнс юм. Хэрвээ чи хойд зүг рүү харан суугаад бясалгаж байтал гэнэт чи хойд талд сууж байгаа харагдана, тэгээд "Би яаж өөрийнхөө биенээс гарчихваа" гэж гайхна. Тэгвэл энэ бол жинхэнэ чи өөрөө биенээсээ гарсан юм, тэнд сууж байгаа нь

бол чиний бодит бие мөн Дэд сүнс. Үүнийг бол ялгаж болдог.

Фалунь Гоны дасгал хийж байхдаа өөрийгээ бүрэн мэдэхгүй болж болохгүй, тэгвэл Фалунь Гон бясалгалын аугаа номонд нийцэхгүй. Дасгал хийж байхдаа ухаан сэргэг байх ёстой. Дасгалын үед Эзэн бодол чинь хүчтэй байвал гажих зүйл гарахгүй, юу ч чамд гай болж чадахгүй. Хэрэв Эзэн бодол сул байвал зарим зүйл бие дээр чинь гарч болзошгүй.

3) Дасгал хийхэд зүг чиг, цагаас үл хамаарах

Их олон *чигон* бясалгалд дасгалыг хэдэн цагт аль зүг рүү харж хийвэл илүү сайн байх талаар ярьдаг. Бид ийм зүйл ярихгүй. Фалунь Гон бясалгалыг орчлон ертөнцийн мөн чанар, орчлон ертөнцийн хувьслын зарчим дагуу хийдэг, иймээс зүг чиг, цаг нь чухал биш. Бид дасгал хийхдээ Фалунь дээр сууж бясалгаж байгаатай адил, бүх зүг рүү харсан, үргэлж эргэж байдаг. Бидний Фалунь орчлон ертөнцтэй нэг хэмтэй. Орчлон ертөнц хөдөлж байдаг, Тэнгэрийн заадас галагтик хөдөлж байдаг, есөн гариг нарыг тойрон эргэдэг, дэлхий тэнхлэгээ тойрон бас эргэдэг, аль зүг нь урд, хойд, зүүн, баруун юм бэ? Эдгээр зүг чиг бол дэлхийн хүмүүсийн гаргасан зүйл. Иймээс чи аль зүг рүү харж дасгалаа хийсэн ч бүх зүг рүү харж хийж байгаатай адил.

Зарим хүн дасгалаа шөнө дунд, эсвэл үд дунд юмуу ямар нэг цагт хийхэд сайн гэж ярьдаг. Бид ингэж бас ярихгүй, яагаад гэвэл Фалунь чамайг дасгалаа хийгээгүй байхад ч бясалгадаг, Фалунь цаг мөч тутамд чамайг бясалгаж өгч байдаг, Ном хүнийг ариусгана. Үрлийн замаар явдаг *чигон* үрлийг бясалгадаг, Фалунь Гон-д бол Ном хүнийг бясалгаж өгдөг юм. Чамд цаг зав их байвал дасгалаа илүү хий, цаг зав бага байвал бага хий, энэ бол чөлөөтэй.

4.Амь бие, сэтгэлийн хос бясалгал

Фалунь Гон амь бие, сэтгэлийг хос бясалгана, дасгалаар хүний бодит бие эхлээд өөрчлөгдөнө, бодит биеэ орхихгүй, Эзэн сүнс махан биетэй нэг болж нийлнэ, бүхэлдээ бясалгаж үр дүнд хүрнэ.

1) Бодит биеэ өөрчлөх

Хүний бие янз бүрийн молекулын бүтэц бүрэлдэхүүнтэй мах, цус, яснаас бүтдэг. Бясалгалаар хүний биеийн молекулын бүрэлдэхүүн дээд энергийн бие бодь болж хувирдаг, ингээд хүний бие урьдын эд бодисноос тогтохоо болино, үндсээрээ өөрчлөгддөг. Гэхдээ бясалгагч энгийн хүмүүсийн дунд амьдарч бясалгаж байгаа, хүний нийгмийн байдлыг бусниулж болохгүй, иймээс энэ өөрчлөлт нь биеийн урьдын молекулын бүтэц, молекулын жагссан дэс дарааг өөрчлөхгүй, зөвхөн молекулын урьдын бүрэлдхүүнийг өөрчилдөг. Хүний биеийн мах нь хэвээрээ зөөлөн, яс нь хатуу, цус нь шингэн, зүсэхэд бас цус гарна. Хятадын эртний таван мах бодийн онолоор яривал бүх зүйлс төмөр, мод, ус, гал, шорооноос бүтдэг, хүний бие ч адилхан. Бясалгагчийн бодит биед өөрчлөлт гарч урьдны молекулын бүрэлдэхүүн дээд энергийн бие бодиор солигдоход хүний бие аль хэдийн урьдын бие бодиор бүтээгдсэн биш болдог. Таван мах бодиос гарах гэдгийн утга нь энэ л юм.

Амь бие, сэтгэлийн хос бясалгалын хамгийн гол онцлог нь хүний насыг уртасгадаг, хөгшрөлтийг удаашруулдаг. Манай Фалунь Гон бас ийм мэдэгдэхүйц онцлогтой. Фалунь гон-ы үйлчлэл нь хүний биеийн молекулын бүтцийг үндсээр нь өөрчилдөг, хураасан дээд энергийн бие бодь эс болгонд хадгалагддаг, эцэст нь дээд энергийн бие бодиор эсний бүрэлдэхүүн солигддог, бодисын солилцоо байхгүй болно. Тэгээд таван мах бодиос гарна, бие нь өөр орон зайн бодис элементээс бүтсэн болдог. Манай энэ цаг хугацааны орон

зайнд хязгаарлагдахгүй учраас тэр хүн үүрд залуугаараа байна. Фалунь Гон-д ийм замаар явдаг.

Түүхэнд их урт удаан насалсан олон лам хуврагууд байдаг, одоо хэдэн зуун настай хүн гудамжаар алхаж байдаг, гэхдээ чи түүнийг хараад хэн гэдгийг мэдэхгүй, түүнийг харахад маш залуу, энгийн хүний хувцастай болохоор ялгагдахгүй. Хүний нас одоогийнх шиг ийм богино байх ёсгүй. Одоогийн шинжлэх ухааны үүднээс үзэхэд хүн 200 гаруй насалж болно. Тэмдэглэгдсэн дээд хэмжээгээр Английн Фемкайт гэдэг хүн 207 жил насалсан. Японд Мицу Тайра гэдэг хүн 242 жил насалсан. Хятадын Тан гүрний үед нэг Хуй Жао гэдэг хувраг 290 насалсан. Фужиан мужийн Ёнгтай гэдэг газрын тэмдэглэлд Тан гүрний Ши Жонг хаан засаглалын үед Чен Жун гэдэг хүн Жон Хэ-гийн эхний жилд (881 он) төрсөн. Тэр Юан гүрний Тай Динг онд (1324 он) нас барсан, 443 жил насалсан. Энэ бүгд тэмдэглэлд үлдсэн, судалж үзэж болно, үлгэр домог биш юм. Манай Фалунь Гон бясалгагчдын нүүрний үрчлээс нь мэдэгдэхүйц багасдаг, нүүр нь ягаанаар туяарсан, бие нь хөнгөн, явган явах, ажил хийхэд ядрахыг мэдэхгүй, энэ бол түгээмэл байдал. Би өөрөө хэдэн арван жил бясалгасан, хүмүүс миний царайг хорин жил болоход бараг өөрчлөгдөөгүй гэдэг, ийм учиртай юм. Манай Фалунь Гон-д амь биеийг бясалгах их хүчтэй зүйл байдаг, Фалунь Гон-ы бясалгагчид энгийн хүнийг бодвол нас нь их ялгаатай харагддаг, бодит насандаа харагддаггүй. Иймээс амь бие сэтгэлийн хос бясалгалын нэн тэргүүн онцлог нь хүний насыг уртасгана, хөгшрөлтийг удаашруулна, хүний амьдрах хугацааг уртасгана.

2) Фалунь Тэнгэрийн эргүүлэг

Бидний хүний бие бол нэгэн жижиг орчлон ертөнц. Хүний биеийн энерги биеийн эргэн тойронд эргэлдэж байдаг, үүнийг жижиг орчлон ертөнцийн эргүүлэг буюу тэнгэрийн

эргүүлэг гэдэг. Түвшингийн хувьд яривал Рэн ба Дү²² энергийн суваг нийлэх нь зөвхөн өнгөцхөн тэнгэрийн эргүүлэг юм. Энэ нь амь биеийг бясалгах нөлөөгүй. Бага Тэнгэрийн эргүүлэг нь үнэн хэрэгтээ Ниван ордноос Үрлийн талбай руу биеийн дотуур эргэдэг. Энэ дотоод эргэлтийн нөлөөгөөр хүний бүх энергийн судлууд онгойдог, биений дотроос гадагш тэлдэг. Манай Фалунь Гон эхнээсээ бүх энергийн судлуудыг нээхийг шаарддаг.

Их Тэнгэрийн эргүүлэг гэдэг нь энергийн нэмэлт найман судлын хөдөлгөөн, бүх биеэр нэг бүтэн тойрдог. Их Тэнгэрийн эргүүлэг нээгдвэл хүн газраас хөөрөх байдалд ордог. Энэ нь Үрлийн жаяг сударт өгүүлсэн гэгээн цагаан өдрөөр хөөрөх гэдгийн утга нь юм. Тийм байсан ч чиний биеийн нэг хэсэг голдуу түгжигддэг болохоор чи хөөрч чадахгүй, гэхдээ чи төвөггүй хурдан алхаж чадна, өгсүүр газар алхахад ардаас чинь хэн нэгэн түлхэж өгч байгаа мэт санагдана. Их Тэнгэрийн эргүүлэг нээгдэхэд бас ер бусын чадвар гардаг, биеийн янз бүрийн эрхтэнд байгаа чий байраа солилцдог. Зүрхэнд орших чий гэдсэнд очино, гэдсэнд орших чий нарийн гэдэс рүү шилжих гэх мэт. Гон хүч нэмэгдэхэд энэ чадварыг биеийн гадна гаргавал юмыг зайнаас хөдөлгөх ер бусын чадвар болдог. Ийм Тэнгэрийн эргүүлгийг бас Энергийн сувгийн Тэнгэрийн эргүүлэг эсвэл Тэнгэр Газрын Тэнгэрийн эргүүлэг гэж нэрлэдэг. Гэсэн ч энэ хөдөлгөөнөөр биеийг хувиргах зорилгод хүрч чадахгүй, үүнд хамаарах өөр нэг Тэнгэрийн эргүүлэг байх хэрэгтэй, үүнийг Хиллэх заагийн (Мао Ю) Тэнгэрийн эргүүлэг гэдэг. Хиллэх заагийн Тэнгэрийн эргүүлэг тойрохдоо Хуйэн²³

²² Рэн ба Дү- Дү суваг буюу "Манлай хөлөг" аарцагны хөндийгөөс эхэлж нурууны голоор өгсөнө. Рэн суваг буюу "Санааны хөлөг" аарцагны хөндийгөөс биеийн урд талын голоор өгсдөг.

²³ Хуйэн - хязангийн голд байдаг цэг

эсвэл Байхуй²⁴ цэгээс эхлээд биеийн хажуугаар арга, билэг²⁵ хилийн заагаар явдаг.

Фалунь Гон-ы Тэнгэрийн эргүүлэг нь ердийн бясалгалын аргуудад ярьдаг нэмэлт найман Энергийн судлаас маш давуу, бүхэл биед сүлжилдэн орших бүх энергийн сувгуудын хөдөлгөөн юм. Бүхэл биеийн бүх энергийн сувгууд нэг зэрэг бүрэн онгойх хэрэгтэй, бүгд хамт хөдлөх ёстой. Энэ зүйл манай Фалунь Гон-д байдаг учраас чи санаатайгаар үүнийг хийх гэж эсвэл бодлоороо удирдах гэсний хэрэггүй. Хэрэв чи тэгж хийвэл буруутна. Би лекцийн явцад чиний биеийн гадна автоматаар эргэх энергийн механизмыг суулгана. Энергийн механизм нь дээд түвшний бясалгалд онцлог зүйл, бидний дасгалыг автомат болгодог нэг хэсэг нь. Энэ нь яг Фалуний адил зогсолтгүй эргэнэ, дотоод бүх энергийн сувгуудыг дагуулж эргэх хөдөлгөөнд оруулна. Чи Тэнгэрийн эргүүлгэндээ анхаарахгүй байсан ч эдгээр энергийн сувгууд аль хэдийн эргэлтэнд орсон байдаг, дотор гүнд болон гадна бүгд хамтдаа хөдөлж байдаг. Бид дасгалаар биеийн гадна орших энергийн механизмыг идэвхжүүлдэг.

3) Энергийн судлыг нээх

Энергийн судлыг нээх зорилго бол энергийн эргэлт явуулах, эсийн молекулын бүтцийг өөрчилж дээд энергийн бие бодь болгон хувиргахад юм. Бясалгадаггүй хүний энергийн судлууд нь бөглөрсөн нарийн байдаг. Бясалгадаг хүний энергийн судлууд аажимдаа гэгээтэй болж бөглөөстэй газрууд нь онгойдог. Удаан бясалгасан хүний энергийн суваг нь өргөсдөг, дээд түвшин лүү бясалгахад бүр ч өргөсдөг, зарим хүний энергийн судал хуруу шиг бүдүүрсэн

²⁴ Байхуй - толгойн оройд байдаг цэг

²⁵ арга, билэг (инь, ян) - Дао системд бүх зүйлд арга билэг эсрэг хүч оршдог, харилцан тусдаа ч хоорондоо хамааралтай, эм (билэг) эр (арга), биеийн урд тал билэг, ар тал арга гэж үздэг

байдаг. Гэхдээ бүх энергийн судлууд нээгдэх нь хүний бясалгалын түвшин, *гон*-ы өндрийг илэрхийлэхгүй. Дасгал хийх явцад энергийн судлууд гэгээтэй өргөн болсоор эцэст нь нэгдэж нэг том хэсэг болно. Энэ үед тэр хүнд энергийн суваг, зүү эмчилгээний цэг байхгүй болно. Өөрөөр хэлбэл тэр хүний бие бүхэлдээ энергийн судал, биологийн идэвхтэй цэг болно. Энэ байдалд хүрсэн ч энэ хүн Дао-д хүрсэн гэсэн үг биш, Фалунь Гон бясалгалын зөвхөн нэг түвшний илрэл. Энэ шатанд хүрвэл Гурамсан ертөнцийн ном бясалгалын төгсгөлд хүрсэн шинж, мөн үүний зэрэгцээ гаднаа илт ажиглагдах нэгэн байдал гардаг нь толгойн оройд цугласан гурван цэцэг юм. Гон багана нилээд өндөр болж хүчтэй ер бусын чадвар гарна, хэлбэр дүрстэй болно. Зулайн дээр гарах гурван цэцэгний нэг нь удвал цэцэгтэй, нөгөө нь лянхуа цэцэгтэй төстэй. Гурван цэцэг нэг нэгийгээ тойрон эргэхдээ бас тус тусдаа эргэлдэнэ, цэцэг болгон тэнгэрт хүрсэн маш өндөр иштэй, энэ гурван иш нь цэцгийн хамт бас эргэж байдаг. Тэр хүнд толгой нь хүндэвтэр болсон мэдрэгдэнэ, энэ үед Гурамсан ертөнцийн ном бясалгалын хамгийн сүүлчийн шатанд хүрдэг.

5. Бодлын үйл

Фалунь Гон бясалгалд бодлын үйл байхгүй, хүний бодлын үйл дангаараа юуг ч хийж гүйцэтгэхгүй зөвхөн команд өгдөг, жинхэнэ гүйцэтгэдэг нь ер бусын чадвар. Энэ нь тархинаас гарсан мэдээллийг хүлээн авч чаддаг сэтгэн бодох чадвартай оюун ухаант бие бодь. Харин олон хүмүүс, ялангуяа *чигон*-ы хүрээний хүмүүс энэ талаар янз бүрийн ойлголттой байдаг. Тэд бодлын үйлээр олон зүйлийг хийж болно гэдэг, зарим нь бодлын үйлээр ер бусын чадварыг гаргадаг, тэнгэрийн мэлмийг нээдэг, өвчнийг эдгээдэг, зайнаас юм хөдөлгөдөг гэх мэтийн зүйл ярьдаг. Энэ бол буруу ойлголт, доод түвшинд энгийн хүн бодлын үйлээр мэдрэх эрхтэн, дөрвөн мөчөө удирддаг. Дээд түвшинд бясалгагчийн бодлын үйлийн зэрэг ахидаг, чадавхыг

удирддаг, өөрөөр хэлбэл бодлын үйлээр ер бусын чадварыг удирддаг. Бодлын үйлийг бид ингэж хардаг. Бид заримдаа *чигон* багш хүн эмчилж байгааг харахад өвчтөн түүний гар хөдлөхөөс өмнө бие нь сайжирна гэдэгт итгэлтэй болдог, тэгээд тэр багшийн бодлын үйлээр өвчин нь эдгэрсэн гэж боддог. Үнэн хэрэгтээ тэр багш нэг янзын ер бусын чадвар гаргаж удирдан өвчин эдгээх эсвэл ямар нэгэн зүйл хийдэг. Ер бусын чадвар өөр орон зайд дамждаг тул энгийн хүний нүдэнд харагдахгүй, үүнийг мэдэхгүй хүн бодлын үйл өвчнийг эдгээж байна гэж боддог. Зарим хүн бодлын үйлийг өвчин эдгээхэд хэрэглэж болно гэж үздэг нь хүмүүсийг төөрөлдүүлсэн. Энэ үзлийг залруулах хэрэгтэй.

Хүний бодол бол нэг хэлбэрийн мэдээлэл, нэг төрлийн энерги, бодитоор оршдог зүйл. Хүн юм бодоход тархинаас долгиолог зүйл гардаг, заримдаа тарни уншихад энэ нь их үр дүнтэй. Яагаад вэ? Учир нь орчлон ертөнц өөрийн долгиолог давтамжтай байдаг, тарни унших давтамж орчлон ертөнцийн давтамжтай давхцахад нөлөө гардаг. Орчлон ертөнцөд хор хөнөөлтэй зүйл оршихыг зөвшөөрдөггүй, ийм нөлөө гаргахын тулд заавал дотоод мөн чанар байх ёстой. Бодлын үйл бол тодорхой хэлбэрийн бодол. Чигоны их багшийн Номын биес эзэн биений бодлоор удирдагдаж, захирагдаж байдаг. Номын бие бас асуудал шийдэх, үүрэг гүйцэтгэж чадах өөрийн гэсэн бодолтой, бие даасан чадвартай, бүрэн тусгаар тогтносон. Үүний зэрэгцээ Номын биес *чигон* багшийн эзэн биений бодлыг мэддэг, тэр бодлын дагуу үйл хийдэг. Жишээ нь, *чигон* багш ямар нэг хүний өвчинг эдгээхийг хүсвэл Номын биес тэнд очдог, тийм бодол гараагүй бол очихгүй. Маш сайн зүйл хийх хэрэгтэй бол тэд өөрийнхөөрөө хийдэг. Зарим багш гэгээрэлд хүрээгүй, түүний мэдэхгүй зүйлс байдаг, харин түүний Номын биес аль хэдийн мэдэж байдаг.

Бодлын үйл бас өөр нэг утгатай, энэ бол онгод орох. Онгод орох нь өөрийн Эзэн бодлоос гардаггүй. Эзэн бодлын

суурь мэдэхүй нь тун хязгаарлагдмал, энэ нийгэмд хараахан оршдоггүй зүйл гарч ирэхэд Эзэн бодолд бүрэн найдвал болдоггүй. Онгод орох нь Дэд бодлоос гардаг. Зарим хүн бүтээн туурвих ажил юмуу эсвэл шинжлэх ухааны судалгаа шинжилгээ хийхдээ тархиныхаа бүх хүч боломжоо шавхаад гацдаг, тэгээд ажлаа орхиод хэсэг амардаг, эсвэл гадагш гарч алхдаг. Тэгэхэд түүнд бодолгүй, санамсаргүй байхад гэнэт онгод ордог. Тэр нэн даруй энэ бүгдийг бичиж авна, тэгээд ямар нэг зүйлийг бүтээдэг. Яагаад гэвэл Эзэн бодол хүчтэй байхад тархийг эзэмдэж өөрийн нөлөөнөөс бусад юуг ч оруулдаггүй. Эзэн бодол амрангуут Дэд бодол үйлчилж эхэлнэ, тархийг эзэмдэнэ. Дэд бодол өөр орон зайд харьяалагддаг, энд хязгаарлагддаггүй учраас шинэ зүйл бүтээж чаддаг. Гэхдээ Дэд бодол давуу гарч хүний нийгмийн байдалд саад болж болохгүй, нийгмийн хөгжлийн явцад нөлөөлөхийг зөвшөөрөхгүй.

Онгод орох хоёр эх үүсвэр байдаг. Нэг нь бол Дэд бодол. Дэд бодол энэ нийгэмд төөрөөгүй, онгод оруулж чадна. Хоёр дахь нь бол дээд түвшний амь бодийн команд удирдлага, дээд түвшний амь бодийн удирдлагаар хүний ухаан тэлж том зүйлийг зохион бүтээж болно. Нийгмийн болон орчлон ертөнцийн хөгжил бүхэлдээ өөрийн тодорхой хуулийн дагуу явагддаг. Санаандгүй гарах зүйл гэж огт байдаггүй.

6.Фалуень Гон бясалгалын түвшин

1) Дээд түвшний бясалгал

Фалуень Гон бясалгал их өндөр түвшинд явагддаг учраас гон нилээд хурдан гардаг. Бясалгалын аугаа зам маш энгийн бөгөөд амар. Фалуень Гон дасгалын хэдхэн хөдөлгөөнтэй, гэхдээ өргөн хүрээнд харвал биеийн бүх байдлыг, үүсч гарах олон зүйлийг бүгдийг удирддаг. Тэр хүний зан чанар дээшилж л байвал түүний *гон* хурдан өснө, санаатайгаар

хийх гэж оролдох, ямар нэгэн арга барил хэрэглэж, тогоо зуух тавьж гал өрдөн цуглуулсан бодисоороо үрэл гарган авах нь бага нөлөөтэй. Бодлын үйлээр удирдуулахад найдвал бүр төвөгтэй болно, харин хүнийг амархан буруу замд оруулна. Бид энд бясалгалын хамгийн тохиромжтой зөв замыг өгч байна, гэхдээ бас хамгийн хэцүү. Бясалгагч өөр арга хэрэглээд Сүүн цагаан биений байдалд хүрэх гэвэл арав гаруй жил, хэдэн арван жил эсвэл түүнээс ч урт хугацаа шаардлагатай. Гэхдээ бид чамайг тийм байдалд нэн даруй хүргэнэ, чи үүнийг мэдрэхээсээ өмнө магадгүй энэ түвшинг аль хэдийн даваад өнгөрчихсөн байна, зөвхөн хэдэн цаг л болж магад. Чи нэг өдөр л их мэдрэмтгий байна, жоохон байгаад мэдрэмтгий байхаа болино. Үнэн хэрэгтээ чи маш чухал түвшинг давсан юм.

2) Гон илрэх хэлбэр

Фалунь Гон-ы сурагчид махан биений засал хийгдсэний дараа Дафа²⁶-гийн бясалгал хийхэд нийцсэн байдал, Сүүн цагаан биений байдалд хүрдэг. Зөвхөн энэ байдалд хүрсний дараа *гон* гарна. Дээд түвшний Тэнгэрийн мэлмийтэй хүн бясалгагчийн арьсан дээр *гон* үүсэхийг, дараа нь биерүү шимэгдэж орохыг харж чадна. Энэ *гон* үүсэх шимэгдэх явц өөрөө давтагдсаар байдаг, түвшнөөс түвшинд, заримдаа үнэхээр хурдан явагддаг. Энэ бол эхний үеийн *гон*. Эхний үеийн дараа бясалгагчийн бие энгийн бие биш болно, Сүүн цагаан биеийн байдалд хүрсний дараа бясалгагч өвчин тусахгүй болно. Энд тэнд өвдөлт гарч магад, эсвэл зарим хэсэгт таагүй болох нь өвчин биш гэхдээ төстэй илэрнэ, энэ бол нүглээс гаралтай. Хоёр дахь үеийн *гон* гарахад өөрийн оюун ухаант амь бодь том болж өснө, эргэн тойронд хөдөлгөөн хийх, ярих чадвартай болно. Заримдаа тэд сийрэг үүсдэг, заримдаа их нягтшилтай үүсдэг. Тэд нэг нэгэнтэйгээ ярьж чадна, тэдгээр оюун ухаант амь бодид их хэмжээний

²⁶ Дафа-Аугаа ном, Аугаа хууль, Фалунь Дафа-гийн товч нэр

энерги хадгалагддаг, энэ нь үндсэн эх биеийг хувирахад хэрэглэгддэг.

Фалунь Гон бясалгалын тодорхой дээд түвшинд хүрэхэд бясалгагчийн бүхэл биеэр заримдаа Бясалгасан нярай хүүхдүүд гардаг. Тэд дүрсгүй, тоглох дуртай, зөөлөн сэтгэлтэй. Өөр нэг бие бас гарч болно, Мөнхийн нярай хүүхэд. Тэр лянхуа цэцгийн суудал дээр суусан их үзэсгэлэнтэй. Бясалгалаар үүссэн Мөнхийн нярай хүүхэд хүний биеийн арга билиг нэгдсэнээр бүтээгддэг. Эрэгтэй, эмэгтэй бясалгагч аль нь ч Мөнхийн нярай хүүхдийг бясалгаж болно. Эхэндээ Мөнхийн нярай хүүхэд их өчүүхэн, аажмаар өсч яваандаа бясалгагчийн биеийн дайтай том болно, биен дотор нь байхдаа бясалгагчтай яг адилхан харагдана. Ер бусын чадвартай хүн хараад тэр хүнийг хоёр биетэй гэж хэлдэг. Энэ хүн үнэндээ өөрийн жинхэнэ биеэ төгс бясалгасан. Бясалгалаар бас Номын маш олон бие гарч болно. Товчхондоо орчлон ертөнцөд гарч болох бүх ер бусын чадварууд Фалунь Гон-оор гарч болдог, бусад бясалгалын аргаар гардаг ер бусын чадварууд бас Фалунь Гон-д багтдаг.

3) Гурамсан ертөнцөөс гарсан бясалгал

Фалунь Гон дасгал хийснээр бясалгагч энергийн судлуудаа өргөсгөсөөр хооронд нь нэгдүүлж нэг бүхэл хэсэг болтол нь өргөн болгож болно. Ингэхэд хүн бясалгаад энергийн судлуудгүй, биологийн идэвхт цэггүй байдалд хүрнэ, эсвэл эсрэгээр яривал хаа сайгүй энергийн судлууд, биологийн идэвхт цэгүүдтэй болно. Гэхдээ энэ хүн Дао-д хүрсэн хэрэг биш энэ бол зөвхөн Фалунь Гон бясалгалын явцад илрэх нэг хэлбэр, нэг түвшний илрэл. Энэ шатанд хүрэхэд тэр хүн Гурамсан ертөнцийн ном бясалгалын төгсгөлд хүрнэ, гаргасан гон нь аль хэдийн маш их хүчирхэг болсон, хэлбэрээ олж дууссан байна. Мөн түүний гон багана маш өндөр болно, толгой дээр нь гурван цэцэг гарч ирнэ, энэ үед

Гурамсан ертөнцийн ном бясалгалын бараг эцсийн шатанд хүрнэ.

Дахин нэг шат урагшилбал юу ч үлдэхгүй болно, хүний бүх ер бусын чадварууд биеийн хамгийн гүн орон зайд орж дарагдана. Тэр Ариун цагаан биений байдалд орно, бие нь тунгалаг болно, нэг шат урагшилхад Гурамсан ертөнцөөс гарсан номын бясалгалд орно, мөн Буддын биеийн бясалгал гэдэг. Энэ үед гарсан ер бусын чадварууд бурханы хүч чадалд харъяалагддаг, бясалгагч хязгааргүй хүч чадалтай болно, гайхамшигтай хүчирхэг болно. Дээд түвшинд хүрээд аугаа гэгээрэгч болох бясалгалд орно. Энэ бүгд чиний зан чанараа яаж бясалгахаас хамаарна. Ямар түвшин хүртэл бясалгана, тэр бол чиний хүрсэн Гэгээрлийн хутаг. Тууштай бясалгагч Ариун бясалгалын замыг олж Гэгээрлийн хутагт хүрнэ, зорилгынхоо эцэст хүрнэ.

Гуравдугаар бүлэг

Зан чанарын бясалгал

Фалунь Гон-ы бясалгагчид зан чанарын бясалгалыг тэргүүн зэрэгт тавих ёстой, зан чанарыг *гон* өсгөх гол түлхүүр гэж үзэх ёстой. Энэ бол дээд түвшинд бясалгах зарчим, шууд хэлэхэд хүний түвшинг тодорхойлдог *гон* хүч дасгал хийснээр гардаггүй харин зан чанарын бясалгалаар гардаг. Зан чанар дээшлүүлэх нь хэлэхэд амар хийхэд хэцүү. Бясалгагч их чармайлт гаргаж чаддаг байх ёстой, гэгээлэг чанараа дээшлүүлэх, бараг тэвчихийн аргагүй зүйлийг ч тэвчих, гэх мэт. Яагаад зарим хүмүүсийн *гон* олон жилээр хичээллээд ч өсдөггүй вэ? Үндсэн шалтгаан нь бол Нэгд: тэд зан чанарт анхаардаггүй, Хоёрт: дээд түвшний ариун бясалгалын аргыг мэддэггүй. Энд дурьдсан зүйлийг авч үзэх хэрэгтэй. Бясалгалын систем заадаг олон багш зан чанарыг ярьдаг, тэд жинхэнэ зүйлийг зааж байна. Зан чанарын талаар хэзээ ч ярьдаггүй зөвхөн дасгал, хөдөлгөөн заадаг тэдгээр хүмүүс бол үнэндээ хор учруулах бясалгал зааж байна. Иймд бясалгагч зан чанараа дээшлүүлэхэд их чармайлх хэрэгтэй, тэгж байж дээд түвшинд бясалгана.

1.Зан чанарын агуулга

Фалунь Гон-д ярьж байгаа зан чанарт зөвхөн ёс суртахуун багтдаггүй, үүнд ёс суртахуунаас гадна их олон зүйлс багтдаг, ёс суртахууны зүйлсийг оролцуулан олон талын зүйлс ордог. Ёс суртахуун бол зан чанарын зөвхөн нэг илрэл, тэгэхээр зөвхөн ёс суртахуунаар зан чанарын ухагдахууныг ойлговол хангалтгүй. Зан чанар нь олох ба алдах дээр яаж хандах асуудлыг багтаадаг. Олох гэдэг нь орчлон ертөнцийн мөн чанарт зохицон олох юм. Орчлон ертөнцийн мөн чанарт Жэнь-Шань-Рэн (Үнэн, Нинжин, Тэвчээр) ордог. Бясалгагч орчлон ертөнцийн мөн чанарт хэр нийцэх нь түүний буянгийн хэмжээнд тусгагддаг. Алдах

гэдэг нь шунал, хувийн ашиг сонирхол хөөцөлдөх, тачаал, хүсэл, амь хөнөөх, тэмцэлдэх, хулгай, дээрэм, хууран мэхлэл, атаархал гэх мэт муу зан үйл, бодлыг хаях юм. Дээд түвшинд бясалгавал энгийн хүний хүсдэг, хөөцөлддөг зүйлээсээ салах хэрэгтэй, өөрөөр хэлбэл бүх зууралдсан сэтгэлээ орхих, хувийн ашиг сонирхол, нэр хүндийн асуудал дээр хөнгөн харах хэрэгтэй.

Махан бие, зан чанараас бүхэл бүтэн хүн бүрддэг. Орчлон ертөнцийн хувьд бас адилхан, матери бодиос гадна бас Жэнь-Шань-Рэн гэсэн мөн чанар цуг оршдог. Агаарын жижиг элемент болгон энэ мөн чанарыг агуулдаг. Энэ мөн чанар хүний нийгэмд сайн үйл хийвэл шагнал хүртэнэ, муу үйл хийвэл шийтгэл хүлээнэ гэсэн зарчим бий болгосон. Дээд түвшинд энэ мөн чанар ер бусын чадвараар бас илэрдэг. Энэ мөн чанарт нийцсэн хүн бол сайн хүн, үүнээс эсрэг болсон хүн муу хүн. Үүнийг мөрддөг, үүнтэй ижилссэн бол Дао-д хүрсэн хүн. Энэ мөн чанарт нийцэхийн тулд бясалгагч хүний зан чанар маш өндөр байх ёстой. Ийм байж л дээд түвшин лүү бясалгана.

Сайн хүн болоход амархан, харин зан чанараа бясалгахад амаргүй, бясалгагчид сэтгэл санаагаа бэлдэх хэрэгтэй. Шулуун шударга зан бол сэтгэл санаагаа ариусгахын урьдчилсан нөхцөл. Нийгэм нь ийм хэцүү төвөгтэй болсон энэ дэлхийд хүмүүс амьдарч байна. Чи сайн зүйл хийхийг хүссэн ч зарим хүн чамд саад болно, чи бусдад муу зүйл хийхийг хүсдэггүй, гэвч зарим хүн чамд янз бүрийн шалтгаанаар муу юм хийнэ. Зарим зүйлүүд ердийн бус шалтгаанаар гарна, чи тэр шалтгааныг ойлгох уу? Чи яах вэ? Энэ орчин нийгэм дэх тэмцэл чиний зан чанарыг мөч бүрийд шалгана. Үгээр илэрхийлэхийн аргагүй доромжлолтой тулгарахад, чиний эрх сонирхол зөрчигдөхөд, мөнгө шунал тачаалтай учирхад, хүчинд автахад, зөрчлөөс өш хонзон, атаархал гарахад, нийгмийн болон гэр бүлийн янз бүрийн зөрчилд, янз бүрийн зовлонд

унахад, чи үргэлж өөрийгээ зан чанарын шалгуурын дагуу хатуу барьж чадах уу? Бүхнийг тэгж хийж чадаж байвал чи аль хэдийн гэгээрсэн хүн. Ихэнх бясалгагчид энгийн хүн байхаасаа эхэлдэг, зан чанарын бясалгал аажим явагддаг, дээш бага багаар ахидаг. Тууштай зорьсон бясалгагчид асар их бэрхшээлийг тэвчээртэй давж чадвал, хүнд нөхцөлд тууштай сэтгэлтэй байвал эцэст нь Гэгээрлийн хутагт хүрч чадна. Би бясалгаж байгаа хүн бүрийг зан чанараа сайн барьж *гон* чадлаа хурдан дээшлүүлэхийг хүсье!

2. Алдах ба Олох

Чигон-ы болон Шашны хүрээнд алдах ба олохын талаар ярьдаг. Зарим хүн алдахыг өглөг өгөх, зарим сайн зүйл хийх, тусламж хэрэгтэй хүмүүст гар сунгахыг хэлдэг ба олох гэдгийг *гон* олохыг хэлдэг. Сүм хийдийн лам хуврагууд хүртэл хүн өглөг өгдөг байх хэрэгтэй гэдэг. Энэ ойлголт бол алдахын утгыг багасгаж байна. Алдахын тухай бидний ярьдаг бол их өргөн, том хүрээнд. Бидний шаарддаг алдах зүйл бол энгийн хүний зууралдсан сэтгэл, түүнээс салж чаддаггүй үзэл бодол юм. Алдах гэдгийн жинхэнэ утга бол чи чухал гэж үздэг, орхиж чадахгүй гэж боддог зууралдсан зүйлээсээ салах юм. Тусламж үзүүлэх, өглөг өгөх бол алдахын зөвхөн нэг хэлбэр.

Энгийн хүн таатай байхын тулд нэр хүнд, хувийн ашиг, амьдралын хангалуун байдал, илүү ая тух, их мөнгө хүсдэг. Энэ бол энгийн хүний зорилго. Бясалгадаг хүний хувьд бол өөр, бидний олох зүйл бол *гон*, харин тэдгээр зүйл биш. Бид хувийн ашгаар хөөцөлдөхгүй үүнийг хөнгөн авч үзэх хэрэгтэй, гэхдээ бид аливаа материаллаг зүйлээсээ сал гээгүй, бид хүний нийгэмд бясалгаж байгаа учраас энгийн хүнтэй адил амьдрах хэрэгтэй. Гол гогцоо нь бол зууралдсан сэтгэлээ орхих, чамайг үнэндээ бүх зүйлээсээ салахыг шаардаагүй. Чи өөрт хамааралтай зүйлээ алдахгүй, гэхдээ чамд хамааралгүй зүйлийг авч болохгүй, авсан бол

бусдад буцааж өгөх хэрэгтэй, олохын тулд чи алдах ёстой. Мэдээж бүх зүйлийг тэр дор нь их сайн хийх боломжгүй, нэг шөнийн дотор гэгээрэх боломжгүйтэй адил. Гэхдээ бага багаар бясалгасаар, шат шатаар ахисаар хүрч болно. Чи хэр алдахын хэмжээгээр олно, хувийн ашиг хөөцөлдөхийг үргэлж хөнгөн харах хэрэгтэй, сэтгэл санаагаа тайван байлгахын тулд бага олох хэрэгтэй. Материаллаг зүйлийн хувьд чи зарим хохирол үзэж зовж магад, гэхдээ буян *гон*-ы хувьд бол чи олно. Үнэн нь үүнд оршино. Чи санаатайгаар нэр хүнд, мөнгө, хувийн ашгаа буян, *гон*-оор сольж байгаа хэрэг биш. Үүнийг өөрийн гэгээлэг ухаанаар тунгаан ойлгох хэрэгтэй.

Дао-гаар бясалгадаг байсан нэг хүн ингэж хэлсэн: Би бусдын хүсдэг зүйлийг хүсэхгүй, би бусдын авдаг зүйлийг авахгүй, гэхдээ надад бусдад байхгүй зүйл байгаа, би бусдын хүсдэггүй зүйлийг хүснэ. Энгийн хүний сэтгэл ханах гэж бараг байдаггүй, ийм хүн бусдын авахыг хүсдэггүй газарт хэвтдэг чулуунаас бусад бүхнийг хүснэ, харин тэр Дао-гийн бясалгагч, тэгвэл тэр чулууг би авна гэж хэлсэн. Ийм нэг зүйр үг байдаг: Хомсхон зүйл нандин, ховорхон зүйл онцгой. Энд чулуунууд хэрэггүй байсан ч өөр орон зайд хамгийн үнэ цэнтэй байж болно. Энэ зарчмыг энгийн хүн ойлгож чадахгүй. Гэгээрсэн, дээд түвшний олон аугаа буянтай багш нарт материаллаг өмч гэж байдаггүй, тэдэнд орхиж чадахгүй зүйл гэж байхгүй.

Бясалгалын зам бол хамгийн зөв зам, бясалгагчид бол үнэндээ хамгийн ухаалаг хүмүүс. Энгийн хүмүүсийн зүтгэдэг зүйлс, олдог өчүүхэн орлого зөвхөн богинохон хугацааны л зүйл. Чи зүтгэж байж ямар нэгэн зүйл үнэгүй олсон ч, жоохон ашиг олсон ч тэглээ гээд яах юм? Энгийн хүмүүсийн дунд ийм үг байдаг: Чи төрөхдөө юуг ч хамт авчирч чадахгүй, үхэхдээ юуг ч хамт аваад явж чадахгүй. Чи дэлхийд юу ч үгүй ирнэ, буцахдаа юу ч авч явж чадахгүй, яс чинь хүртэл чандарлагдаж үнс болно, хичнээн

их мөнгөтэй, өндөр албан тушаалтай байгаад юуг ч өөртэйгээ хамт аваад явж чадахгүй. Харин *гон* бол чиний Эзэн сүнсэн дээр ургадаг, авч явж болно. Би чамд *гон* олоход хэцүү гэж хэлж байна, энэ бол маш нандин зүйл, олоход маш хэцүү тул ямар ч их мөнгөөр сольшгүй. Чиний *гон* дээд түвшинд хүрэхэд нэг өдөр чи цааш бясалгахаа болихоор шийдвэл, ямар ч муу зүйл хийхгүй байхад *гон* чиний хүссэнээр юу ч болж хувирна, чи тэр бүгдийг авч болно, гэхдээ чамд бясалгагч хүнд байдаг зүйл үлдэхгүй. Үүний оронд чи зөвхөн энэ дэлхийд олж болдог зүйлстэй л болно.

Зарим хүн хувийн сонирхолдоо хөтлөгдөн бусдын зүйлсийг зүй бусаар авдаг, тэгээд сайн арилжаа боллоо гэж боддог. Үнэн хэрэгтээ өөрийнхөө буянаар бусадтай сольж ашгаа нэмэгдүүлсэн, үүнийг тэр мэдэхгүй. Бясалгагч хүний хувьд бол түүний *гон*-оос суутгагдана, бясалгагч биш хүнээс бол түүний амьдралын хувь тавилангаас нь эсвэл өөр ямар нэгэн зүйлээс суутгагдана, товчхондоо өгөө аваа тэнцэнэ. Энэ бол орчлон ертөнцийн зарчим. Бас зарим хүн бусдыг үргэлж завшдаг, үг хэлээр доромжилдог гэх мэт. Ийм үйлдлээрээ тэр үүнтэй тэнцэх хэмжээний буянг өөрөөсөө шидэж нөгөө талд өгдөг, бусдыг хохироосныхоо хариуд буянаараа төлдөг.

Зарим хүн сайн хүн байх нь сул тал гэж боддог, энгийн хүний байр суурьнаас харахад сайн хүн байх нь сул талтай. Гэхдээ түүний олж байгаа нь энгийн хүн олж чадахгүй зүйл: буян, цагаан бие бодь, энэ бол маш нандин. Буянгүй бол *гон* байхгүй, энэ бол туйлын үнэн. Яагаад олон хүмүүс бясалгаад *гон* гардаггүй вэ? Энэ нь тэд буянг бясалгадаггүй учраас. Олон хүн буянг онцолж ярьдаг, буянг бясалгахыг чухалчилдаг ч буян яаж *гон* болж хувирдаг жинхэнэ зарчмыг тайлбарлаж чаддаггүй, хувь хүний ойлгох асуудал болж үлддэг. Арван мянган боть Буддын гурван хөлгөн сударт болон Шагжмүнигийн дөч гаруй жил заасан номонд

нэг зүйлийн талаар л ярьсан: энэ бол буян. Эртний Хятадын Дао-гийн бясалгалын бүх номонд буянг ярьдаг. Лао Зи²⁷-гийн таван мянган үгтэй Дао Зан номонд бас буянг тухайлан авч үздэг, зарим хүн үүнийг ердөө ойлгодоггүй.

Бид "алдах" талаар ярья. Чи олохын тулд алдах ёстой, бясалгахыг үнэхээр хүсвэл зарим бэрхшээлтэй тулгарна, чиний амьдралд илрэхэд бие чинь жоохон зовлонтой, энд тэнд чинь таагүйрхэнэ, гэхдээ энэ бол өвчин биш. Бэрхшээл зовлон нийгэмд, гэр бүлд, ажлын газарт хаана ч гарч болно. Хувийн ашиг, сэтгэл санааны зөрчилдөөнөөс болж хэрүүл маргаан гэнэт гарна, зорилго нь чиний зан чанарыг дээшлүүлэхэд юм. Ийм зүйл голдуу гэнэт тохиолддог их ширүүн байдаг. Чамд ямар нэгэн ээдрээтэй асуудал тулгарахад, ичгүүртэй байдалд орж нүүрээ хийх газаргүй болоход, эсвэл хүнд байдалд ороход чи үүнд яаж хандах вэ? Хэрэв чи уцаарлахгүй тайван байвал, тийм байж чаддаг бол чиний зан чанар зөрчлийн дунд дээширнэ, *гон* тэр хэмжээгээр бас өснө. Чи бага зэрэг ахивал бага зэрэг олно, хэр их зориулна тэр хэмжээгээр олно. Бид бэрхшээл дунд байхдаа үүнийг ухаарахгүй байж мэднэ, гэхдээ хичээх хэрэгтэй, өөрийгээ энгийн хүнтэй адил санаж болохгүй. Зөрчилдөөн гарахад бид өөртөө өндөр шалгуураар хандах ёстой, бид энгийн хүмүүсийн дунд бясалгадаг болохоор тэдний дунд зан чанараа хатуужуулна. Бид зарим алдаа хийвэл түүнээс суралцана, ямар ч асуудалтай тулгарахгүй, тааламжтай байвал чамд *гон* гарах боломжгүй.

²⁷ Лао Зи- Дао Зан номыг бичсэн, Дао-гийн шашинг үндэслэгч м.э.ө 4-р зуунд амьдарч байсан хүн.

3. Жэнь, Шань, Рэн (Үнэн, Нинжин, Тэвчээр)-ийг зэрэг бясалгах

Манай бясалгалд Жэнь, Шань, Рэн-ийг зэрэг бясалгадаг. "Жэнь" бол үнэн үг хэлэх, юмыг үнэнчээр хийх, өөрийн эх үндэс жинхэнэ өөртөө буцах, эцэсдээ үнэн хүн болох. "Шань" бол аугаа нинжин сэтгэл гаргах, сайн үйл хийх, хүмүүсийг аврах. Бид гол нь Рэн-ийг чухалчлана. Зөвхөн тэвчээртэй байж бясалгаад аугаа буянтай хүн болж чадна. Рэн бол маш хүчирхэг зүйл, Жэнь, Шань-аас давна. Бясалгалын бүхий л явцад чамаас тэвчихийг, зан чанараа барихыг, өөрийгээ удирдаж сурахыг шаардана.

Асуудалтай тулгарахад тэвчихэд амаргүй. Зарим хүн чамайг хэрэв цохиулсан ч хариу цохихгүй, доромжлуулсан ч дугарахгүй байвал, эсвэл гэр бүл, төрөл садан, сайн найз нөхдийнхээ өмнө нүүрээ хийх газаргүй болсон ч тэвчиж өнгөрөөвөл Аку²⁸-тай адил болсон биш үү гэнэ. Хэрэв чи энэ бүгдэд хэвийн байвал, бусдаас дутуугүй оюун ухаанаа барьж байвал, хувийн ашгийг хөнгөн хардаг бол хэн ч чамайг тэнэг гэхгүй гэж би хэлдэг. Тэвчиж чаддаг байх нь сул тал биш, Аку шиг болсон биш, энэ бол хүчтэй сэтгэлийн тэнхээ, өөрийгээ барих чадвартай байгаагаа харуулж байна. Хятадын түүхэнд Хан Син гэдэг хүн байсан, тэр нэг удаа хүний салтаан доогуур мөлхөж гарч доромжлуулсан, энэ бол их тэвчээр. Эртний нэг үг байдаг, "Энгийн хүн доромжлуулбал сэлмээ сугалаад үзэлцэнэ" Жирийн хүн доромжлуулбал сэлмээ сугалан хариугаа авна, бусдыг загнана, гар зангидан цохино. Амьдралын турш ийм байх амаргүй, зарим хүн нэр төрийн төлөө амьдардаг, энэ бол ямар ч утгагүй зүйл бас маш их ядаргаатай. Хятадын ийм нэг зүйр үг байдаг, "Алхам ухарваас чиний өмнө уужим тэнгэр далай нээгдэнэ". Зөрчил тулгарахад алхам ухар, тэгвэл маш өөр нөхцөл байдлыг олж харна гэсэн утгатай.

²⁸ Аку- Хятадын нэртэй туужид гардаг тэнэг хүний дүр.

Бясалгагч хүн өөртэй нь зөрчилдсөн хүнийг, ичгэвэрт байдалд оруулсан хүнийг тэвчээд зогсохгүй бас түүнд өгөөмөр хандах хэрэгтэй, тэр ч байтугай баярлах хэрэгтэй. Тэр хүн зөрчилдөөн үүсгээгүй бол чи яаж зан чанараа дээшлүүлэх юм? Зовлон дунд хар бие бодийг цагаан бие бодинд яаж хувиргах юм? Чи яаж *гон* гаргах юм? Зовлон шаналалын дунд байхдаа тийм хэмжээнд өөрийгээ барих маш хэцүү. Чиний *гон* чадвар өсөх тутам саад бэрхшээл тасралтгүй нэмэгдэнэ. Бүх зүйл чиний зан чанараа яаж дээшлүүлэхээс шалтгаална. Тэр саад бэрхшээл эхний үед чамайг сэтгэл санаагаар унагаж мэднэ, тэвчихийн аргаггүй болтол уур хүргэж болно, судсыг чинь гүрийтэл уурлуулна. Чи дүрсхийн уурлахгүй уураа барьж чадвал, тэр сайн. Чи тэвчдэг болж эхэлсэн, санаатайгаар тэвчдэг. Чи тэгвэл зан чанараа аажмаар, тасралтгүйгээр дээшлүүлнэ, энэ зүйлийг үнэхээр хөнгөн авч үздэг болбол бүүр сайн дээшрэлт. Энгийн хүмүүс үл ялих сөргөлдөөнийг, жижиг асуудлыг их ноцтойгоор хүлээж авдаг. Тэд өөрийнхөө төлөө амьдардаг, юуг ч тэвчдэггүй, тэвчихийн аргагүй уурласан үедээ юу хийхээс ч буцахгүй. Харин бясалгагч хүнд тэдний ноцтой авч үздэг асуудал бол маш өчүүхэн зүйл, хэтэрхий үл шалих зүйл, яагаад гэвэл чиний зорилго бол туйлын урт хугацааны бөгөөд холч юм. Чи энэ ертөнц хэр удаан оршихтой адил амьдарна. Тэгээд бодоод үз, чамд тэдгээр зүйлс байсан байгаагүй ямар ч хамаагүй. Чи хэтийн уужим бодлоор харвал тэдгээрийг ардаа орхиж чадна.

4.Атаархах сэтгэлийг арилгах

Атаархал бол бясалгалд маш том саад бэрхшээл, бясалгагч хүнд том цохилт, энэ нь *гон* хүчинд шууд цохилт учруулдаг, бясалгалын хамт олондоо хор учруулдаг, бидний бясалгалдаа дээшлэхэд ноцтой саад болдог. Бясалгагч хүний хувьд үүнийг зуун хувь устгах хэрэгтэй, зарим хүн бясалгаад тодорхой түвшинд хүрсэн ч гэсэн атаархлаас

салаагүй байдаг. Атаархлаас салахад хэцүү, харин энэ нь нэмэгдэж хүчтэй болох нь амархан. Энэ зууралдсан сэтгэлийн сөрөг нөлөө зан чанарын сайжирсан талыг хэврэг болгодог. Атаархалыг яагаад онцолж авч ярьж байгаа вэ? Яагаад гэвэл атаархал их хүчтэй, Хятад хүмүүсийн дунд байдаг хамгийн давамгай зүйл, хүмүүсийн бодол санаанд хамгийн их жинтэй, олон хүмүүс үүнийг мэддэггүй. Дорнын атаархал эсвэл Азийн атаархал гэдэг, Зүүнд байдаг шинж чанар. Хятад хүмүүс нилээд бүрэг, зожигдуу, сэтгэлээ илэн далангүй илчилдэггүй, энэ бүгд атаархалд хүргэдэг. Бүх зүйл хоёр талтай байдаг, тиймээс бүрэг чанар сайн ба муу талтай. Барууныхан харьцангуй илэн далангүй. Жишээ нь, сургуульдаа зуун оноо авсан хүүхэд гэртээ харих замдаа баяртай хашгирна, "Би зуун оноо авсан!" Хөршийнхэн нь хаалга, цонхоо онгойлгон түүнд баяр хүргэнэ, "Тоом, баяр хүргье!" Бүгд түүнд баяртай байна. Харин Хятадад байсан бол бодоод үздээ, хүмүүс үүнийг сонсоод дургүй нь хүрнэ, "Тэр зуун оноо авсан гэнэ, тэгээ л биз, онгилоод байх юу байгаа юм?" Атаархах сэтгэлтэй хүний хүлээж авах нь шал өөр.

Атаач хүн бусдыг доогуур үзнэ, өөрөөс нь илүү гарахыг зөвшөөрөхгүй. Тийм хүн өөрөөс нь илүү чадвартай хүнийг харангуугаа бодол нь үймрэнэ, тэсэшгүй болно, бодит байдлыг хүлээн зөвшөөрөхгүй. Бусдын цалин нэмэгдвэл барьцана, адилхан нэмэгдэл авахыг хүснэ, ямар нэгэн зүйл нь буруутвал хариуцлагаа хуваалцахыг хүснэ. Бусад хүн их мөнгө хийхийг хараад нүд нь ногооноор эргэлдэнэ, атаархана. Бусад хүн өөрөөс нь ямар ч болов илүү хийвэл хүлээн зөвшөөрөхгүй. Зарим хүн судалгаа шинжилгээ, ажилдаа амжилт гаргавал нэмэлт урамшуулал авахаасаа айдаг, бусад хүний атаархлаас айна. Зарим хүн атаархал, шоглолоос айгаад авсан цол шагналаа хэлж зүрхэлдэггүй. Зарим *чигон* багш бусад *чигон* багшийн заахыг тэвчдэггүй, тэгээд тэдэнд саад хийдэг. Энэ бол зан чанарын асуудал, жишээ нь *чигон* дасгал хийдэг хүмүүс дунд сүүлд хичээллэж

эхэлсэн зарим хүнд ч гэсэн бусдаас түрүүнд ер бусын чадвар гардаг. Тэгвэл зарим хүн ингэж хэлнэ: Түүнд гайхуулаад байх юу байгаа юм? Би их олон жил бясалгасан надад давхарлаастай олон гэрчилгээ бий. Түүнд яаж надаас түрүүнд ер бусын чадвар гарах юм? Түүний атаархал хөдөлнө. Бясалгал дотогшоо чиглэдэг, бясалгагч хүн өөрийнхөө дотор луу хар, болохгүй байгаа асуудлын эх үүсвэрийг хайх хэрэгтэй. Чи өөр дээрээ сайн ажиллах хэрэгтэй, ямар талын асуудал дээр хангалтгүй байна түүнийгээ дээшлүүлэх хэрэгтэй. Бусдаас бурууг хайгаад байвал чи ганцаараа энд үлдэнэ бусад хүн бясалгалынхаа үр дүнг үзээд дээшилнэ. Чи хамаг цагаа дэмий үрсэн болохгүй гэж үү? Бясалгал бол өөрийгээ бясалгах!

Атаархал бас бясалгал нэгт нөхдөдөө уршигтай, нэгнийх нь хов жив бусдын амгаланд ороход саад болдог. Тийм хүн ер бусын чадвартай бол атаархлаасаа болоод бясалгал нэгт нөхөддөө хэрэглэж гай болж магадгүй. Жишээ нь, тэнд нэг хүн суугаад бясалгаж байна, нэлээд дажгүй бясалгадаг. Түүнд *гон* байгаа учраас тэнд уул шиг сууна, тэгэхэд хоёр амь бодь нисэн ирнэ. Нэг нь урьд лам байсан, атаархлаасаа болоод гэгээрэлд хүрч чадаагүй, тэр тодорхой хэмжээний *гон* чадалтай ч гэсэн үр дүнд хүрч чадаагүй. Тэд бясалгаж байгаа хүн дээр ирэхэд нэг нь хэлсэн: Тийм нэртэй, тийм хүн энд бясалгаж байна, түүний хажуугаар нь гарья. Гэтэл нөгөөдөх нь хэлсэн: Би урьд Тай уулын буланг тас цавчсан. Тэгээд тэр бясалгагчийг цохихыг завдана, гэвч тэр гараа далайгаад буулгаж чадаагүй, цохиж чадаагүй яагаад гэвэл тэр хүн ариун Номын бясалгагч учраас хамгаалах бүрхүүлтэй. Тэр ариун Номын бясалгагчид муу юм хийхийг хүссэн учраас ноцтой асуудал болно, тэгээд шийтгэгдэх болно. Атаархдаг хүн өөрийгөө ч хохирооно, бас бусдыг ч хохирооно.

5. Зууралдсан сэтгэлийг арилгах

Зууралдсан сэтгэл гэдэг нь өөрийгээ татан авч чаддаггүй, ямар ч зөвлөлгөөг хүлээн авдаггүй хэтэрхий зөрүүд бясалгагчийн ямар нэг зүйл, зорилгын хойноос улайран хөөцөлдсөн хүсэл. Зарим хүн энэ дэлхийд ер бусын чадварын хойноос хөөцөлддөг, энэ нь тэдний дээд түвшинд бясалгахад гарцаагүй хүнд цохилт болдог. Их хүчтэй хүсэх тусам салахад хэцүү, тэдний бодол улам тэнцвэргүй, туйлбаргүй болно. Тийм хүмүүс эцэст нь юу ч олж авахгүй, түүнчлэн сурч байгаа зүйлдээ эргэлзэж эхэлнэ. Зууралдах сэтгэл хүний хүслээс үүсэлтэй. Зууралдсан сэтгэлийн шинж чанар, зорилго болон чиглэл нь мэдээж хязгаарлагдмал, нилээд ил тод, бодит, олон давтагддаг учраас тэр хүн зууралдсан сэтгэлээ мэдэхгүй байж болно. Энгийн хүнд их олон зууралдсан сэтгэл байдаг, тэр хүссэн зүйлдээ хүрэх, олохын тулд шаардлагатай арга болгоныг хэрэглэж магадгүй. Бясалгагч хүний зууралдсан сэтгэл өөрөөр илэрдэг, ямар нэгэн ер бусын чадвар хүсэх, тодорхой зүйлийг харж баясах, ямар нэгэн үзэгдэлд автах, гэх мэт. Чи бясалгагч хүний хувьд юу ч байсан түүнийг хүсэх, хөөцөлдөх бол буруу, хүслийг орхих хэрэгтэй. Дао системд үл оршихуйг ярьдаг, Буддын системд хоосон чанарыг, яаж хоосны үүдээр орохыг ярьдаг. Бид яваандаа үл орших, хоосон байдалд хүрэх, зууралдсан бүх сэтгэлээ орхихыг хүснэ. Салж чадахгүй байгаа бүх зүйлээ чи орхих хэрэгтэй. Ер бусын чадварын хойноос хөөцөлдөх бол нэг жишээ, чи үүнийг хөөцөлдвөл хэрэглэхийг хүсч байна гэсэн үг. Үнэн хэрэгтээ орчлон етөнцийн мөн чанарын эсрэг явж байна гэсэн үг, тухайлбал бас зан чанарын асуудал. Чи үүнийг олоод бусдын өмнө өөрийгээ гайхуулах онгирохыг хүсч байна. Тэдгээр ер бусын чадварууд бол бусдад харуулдаг үзүүлбэрийн зүйл биш. Чиний үүнийг хэрэглэх зорилго гэм хоргүй, зөвхөн ямар нэгэн сайн үйл хийхийг хүссэн байлаа ч гэсэн хийвэл тэр зүйл нь сайн биш болж мэднэ. Энгийн хүний асуудлыг ер бусын чадвар хэрэглэн шийдэх бол зөв

санаа биш. Намайг энэ ангийнхнаас далан хувь нь тэнгэрийн мэлмий нээгдсэн гэж хэлэхийг сонсоод зарим нь "Би яагаад юу ч мэдрэхгүй байна вэ?" гэж гайхаж эхэлнэ. Тэд гэртээ хариад дасгалаа хийж байхад анхаарал нь тэнгэрийн мэлмийд чиглэнэ, бүүр толгой нь өвдөх хэмжээнд хүрнэ. Гэсэн ч эцэст нь тэд юу ч харж чадахгүй хэвээр. Энэ бол зууралдсан сэтгэл. Хувь хүн болгон биеийн байдал болон төрөлхийн суурь чанараараа ялгаатай. Бүгд нэгэн зэрэг тэнгэрийн мэлмийгээр хардаг болох боломжгүй, хүн болгоны тэнгэрийн мэлмийн түвшин бас ижилгүй. Зарим хүн харж чадна, зарим нь чадахгүй, энэ бүгд бол хэвийн.

Зууралдсан сэтгэл бол бясалгагчид *гон* хүч гарахыг чангаан зогсоож чадна. Зарим ноцтой тохиолдолд бясалгагчийг буруу номын зам руу орох шалтгаан ч болж болно. Тухайлбал зан чанар доогуур хүн зарим ер бусын чадвар хэрэглээд муу зүйл хийж болно. Зан чанар тууштай биш хүн ер бусын чадвар хэрэглээд муу зүйл хийсэн тохиолдлууд байдаг. Хаа нэгтээ, коллежийн нэг эрэгтэй сурагч байсан, түүнд бодлыг удирдах ер бусын чадвар гарсан. Тэр үүнийгээ ашиглан бодлоороо бусдын бодлыг залж удирдаж чадах болсон, тэгээд энэ чадвараа муу юм хийхэд ашигласан. Зарим хүн дасгал хийж байхад нь магадгүй зарим нэг дүрс харагдана, тэд үргэлж тодорхой харахыг, бүрэн ойлгохыг хүсдэг. Энэ бол бас зууралдсан сэтгэлийн нэг хэлбэр. Зарим хүний хийх дуртай зүйл сонирхол нь автах сэтгэл болж болно, тэд үүнээсээ салж чаддаггүй. Энэ бас зууралдсан сэтгэлийн хэлбэр. Төрөлхийн суурь чанар, зорилгын ялгаанаас болж зарим хүн дээд түвшинд хүрэхийн төлөө бясалгадаг, тэгэхэд зарим нь зөвхөн ямар нэгэн зүйл олохын тулд бясалгадаг. Сүүлчийн сэтгэлгээ бол хүний бясалгалын зорилгыг хязгаарлах нь мэдээж. Хэрэв ийм янзын зууралдсан сэтгэлээ арилгахгүй бол түүнд бясалгаад ч *гон* гарахгүй. Тиймээс бясалгагч хүн материаллаг зүйл олохыг хөнгөн харах хэрэгтэй, юуг ч хөөцөлдөхгүй бүх зүйлийг жам ёсоор нь байлгавал шинэ

зууралдсан сэтгэл гарахаас зайлж чадна. Үүнийг хийж чадах нь бясалгагчийн зан чанараас хамаарна, хүний зан чанар үндсээрээ өөрчлөгдөхгүй бол, мөн ямар нэгэн зууралдсан сэтгэл үлдвэл бясалгаад үр дүнд хүрч чадахгүй.

6. Нүгэл

1) Нүглийн эх үүсвэр

Нүгэл бол нэг янзын хар бие бодь, буяны яг эсрэг. Буддын шашинд үүнийг муу үйлийн үр гэдэг, бид энд нүгэл гэж хэлдэг. Муу зүйл хийхийг нүгэл үйлдэх гэдэг, хүн энэ насандаа эсвэл урд насандаа буруу үйл хийснээс нүгэл үүсдэг. Жишээ нь: амь хөнөөх, бусдыг завших, бусдын сонирхолд халдах, хэн нэгний талаар ардуур нь хов жив ярих, хүнд нөхөрсөг бус хандах гэх мэт бүгд нүгэл үүсгэж болно. Түүнчлэн зарим нүгэл өвөг дээдсээс, гэр бүл төрөл садангаас, мөн ойрын найз нөхдөөс дамжин ирдэг. Хэн нэгэн рүү нударга явуулахад тэр хүн бас өөрийн цагаан бие бодийг нөгөө хүн лүү явуулдаг, тэгээд тэр хоосорсон зай нь хар бие бодиор дүүрдэг. Амь хөнөөх бол хамгийн муу ёр, энэ бол маш муу үйл тэгээд том нүгэл үүсгэнэ. Нүгэл бол өвчин тусах анхдагч хүчин зүйл. Энэ нь мэдээж үргэлж өвчний хэлбэрээр илрэхгүй, мөн зарим гай барцад тохиолдох гэх мэтийн байдлаар илэрч болно. Энэ бүгд бол нүглийн хийж байгаа үйл. Тиймээс бясалгагч хүн ямар ч муу зүйл хийж болохгүй. Аливаа буруу үйлдэл сөрөг үр дагавар үзүүлж чиний бясалгалд ноцтой саад учруулна.

Зарим хүмүүс ургамлаас *чий* хураахыг дэмждэг. Тэд дасгал заахдаа ургамлаас яаж *чий* авахыг бас заадаг, ямар модны *чий* илүү сайн байдаг, янз бүрийн модны *чий*-н өнгөний талаар ярих их дуртай. Манай зүүн хойд мужийн нэг паркад хэсэг хүмүүс газраар өнхөрдөг дасгал хийдэг байсан, үүнийгээ *чигон* гээд нэрлэчихсэн, тэгээд босч ирээд

нарс модыг тойрч зогсон чийг хураадаг. Хагас жилийн дотор нэг хэсэг нарс модон төгөл хувхайрч шарласан. Энэ бол нүгэлт үйлдэл! Бас алж байна! Ургамлаас *чий*-г хурааж авах нь манай орны цэцэрлэгжүүлэлтийн талаас ч харсан, экологийн тэнцвэрийг ч бодсон, дээд түвшний өнцгөөс ч харсан буруу. Орчлон ертөнц хязгааргүй уудам, цуглуулах *чий* хаа сайгүй байгаа, гадагш үсэрч гараад цуглуул, ургамлыг хохироох ямар хэрэг байна вэ? Бясалгагч юм бол чиний нинжин сэтгэл энэрэл хаана байна?

Бүх зүйл оюун ухаантай, орчин үеийн шинжлэх ухаан ургамлыг зөвхөн амьтай төдийгүй бас оюун ухаантай, бодолтой, мэдрэмжтэй, бүр гоц мэдрэмтгий чадвартай болохыг аль хэдийн танин мэдсэн. Чиний Тэнгэрийн мэлмий Номын нүдний түвшинд хүрвэл хорвоо дэлхий огт өөрөөр харагдана. Чи гадагш гарахад чулуу, хана, мод хүртэл чамтай ярина, бүх биет амьтай. Нэгэн биет бүтээгдмэгц амь түүнд ордог. Дэлхий дээр амьдарч байгаа хүмүүс бодисыг органик ба органик бус гэж ангилсан. Сүм хийдэд амьдардаг хүн аяга хагалахаараа сэтгэлээр унадаг, хагарч эвдрэхэд түүний амь бодь чөлөөлөгддөг. Тэр амьны амьдралын зам төгсөөгүй байсан учраас очих газаргүй болдог, тиймээс амьдралыг нь дуусгасан хүнийг маш ихээр үзэн яддаг, их уурлах тусам тэр хүнд улам их нүгэл нэмэгдэнэ. Зарим *чигон* багш тэр байтугай ан хийдэг, түүний энэрэл, нинжин сэтгэл хаачсан бэ? Буддын болон Дао-гийн системд тэнгэрийн зарчмыг зөрчих зүйл хийдэггүй. Ийм зүйл хийх нь амь хөнөөсөн үйлдэл юм.

Зарим хүн урьд маш их нүгэл үйлдсэн гэж ярьдаг, жишээ нь загас, тахиа алж, загасчилж гэх мэт. Энэ нь тэд бясалгах аргагүй болсон гэсэн хэрэг үү? Үгүй, тийм биш. Тэр үед, чи уршиг үр дагаварыг нь мэдэхгүйгээр үйлдсэн, тэгэхээр илүү нүгэл бий болохгүй. Цаашид үүнийг дахиж бүү хий, тэгвэл л болоо. Чи давтан хийвэл санаатайгаар тэнгэрийн зарчмыг зөрчсөн болно, үүнийг зөвшөөрөхгүй. Манай зарим

бясалгагчид тийм нүгэлтэй, чи бидний энэ семинарт сууж байгаа нь хувь тавилангийн ерөөлтэй, энэ нь дээш бясалгах. Бид орж ирсэн ялаа шумуулыг цохих уу? Чи үүнийг одоогийн түвшиндөө арга хэмжээ авч байгаа болохоор цохиод албал бурууд тооцогдохгүй, чи тэдгээрийг хөөж гаргаж чадахгүй бол алахад том асуудал биш. Ямар нэгэн зүйлийн үхэх цаг нь болбол жамаараа үхдэг. Шагжамүни амьд байхдаа усанд орохыг хүсч нэг удаа ваннаа цэвэрлүүлэх гэж шавиа дуудсан. Шавь нь ванн дотор их олон хорхой байхыг хараад яахаа мэдэхгүй буцаж ирээд асуусан. Шагжмүни дахиад "Би чамаас ванн цэвэрлэхийг л асуусан" шүү дээ гэсэн. Шавь нь тэр дороо ойлгож буцаж очоод ванныг цэвэрлэсэн. Чи зарим зүйлийг хэт нухацтай авч үзэх хэрэггүй, бид чамайг хэтэрхий хашир хүн байлгах гэж зориогүй. Ийм төвөгтэй орчинд чи цаг мөч бүр санаа зовсон, ямар нэгэн зүйл буруу хийчих вий гэж айгаад байвал буруу гэж би хэлнэ. Энэ нь зууралдсан сэтгэлийн нэг хэлбэр, айх бол зууралдсан сэтгэл.

Бид нинжин өршөөнгүй сэтгэлтэй байх ёстой, юманд энэрэнгүй өршөөнгүй сэтгэлээр хандвал асуудалд орох нь бага магадлалтай. Хувийн сонирхлыг хөнгөн авч үзэж сайхан сэтгэлтэй бай, чиний нинжин сэтгэл чамайг муу зүйл хийхээс зайлуулж байх болно. Итгэнэ үү, байна уу хэрэв чи үргэлж уурлах уцаарлах зантай, үргэлж тэмцэлдэж өрсөлдөхийг хүсдэг бол сайн зүйл ч муу болохыг үзнэ. Зарим хүн зөв юман дээр бусдыг зөвшөөрдөггүй, би ийм хүмүүстэй тааралддаг, тэд бусдын зөв байсныг ойлгохоороо буруу хандсан болохоо хожим ойлгодог. Үүнтэй адил зарим зүйлд санал нэг биш байвал бид зөрчилдөөн үүсгэж болохгүй. Чиний дургүй зүйл тухайн үед буруу биш байж болно, бясалгагч хүний хувьд чи түвшнөө байнга дээшлүүлээд байвал чиний хэлсэн үг болгон энергитэй болно. Чи санасан зоргоороо ярьж болохгүй, чи энгийн хүмүүсийг хязгаарлачихна. Чи ялангуяа асуудлын үнэн

учрыг мэдэхгүй, тэдгээрийн нүглийн шалтгааныг харж чадахгүй үедээ буруу зүйл хийж нүгэл үүсгэх нь амархан.

2) Нүглийг арилгах

Энэ дэлхийн зарчим тэнгэрийн зарчимтай ижил, чи бусдад өртэй бол эцэст нь төлөх л болно. Энгийн хүмүүс хүртэл бусдад тавьсан өрөө төлнө. Чиний амьдралын туршид чамд тохиолдох бүх бэрхшээл зовлон нүглээс болдог, чи төлнө. Жинхэнэ бясалгадаг хүний хувьд бидний амьдралын зам өөрчлөгдөнө, шинэ зам нь чиний бясалгалд тохируулан зохицуулагдана. Чиний багш нүглийн чинь зарим хэсгийг арилгаж өгнө, үлдсэн нь чиний зан чанарыг дээшлүүлэхэд хэрэглэгдэнэ. Чи дасгал хийж, зан чанараа бясалгахад нүгэл солигдоно, нүглээ наминчлана. Одооноос эхлээд чамд гарах асуудал тохиолдлын зүйл биш, тиймээс сэтгэл санааны бэлтгэлтэй бай. Чи зарим бэрхшээл зовлонг тэвчиж энгийн хүний салж чаддаггүй бүх зүйлийг орхих болно, их олон саад бэрхшээлийг туулна. Бэрхшээл зовлон гэр бүлд, нийгэмд болон өөр шалтгаанаас гарч болно, эсвэл гэнэт сүйрэл гамшиг тохиолдож магад, бусдын буруу байсан ч чамайг буруутан болгож болно, гэх мэтчилэн үргэлжилнэ. Бясалгагч хүн өвдөхгүй байх учиртай, тэгтэл чи хүнд өвчин гэнэт тусч магад, өвчин их хүндэрч болно, чамайг тэсэхийн аргагүй болтол зовоож болно. Эмнэлэгт хүртэл оношлогдохгүй байж магадгүй, гэтэл өвчин дараа нь ямар ч шалтгаангүйгээр ямар ч эмчилгээгүйгээр зүгээр болж болно. Ингэж чиний өр ийм хэлбэрээр төлөгдөнө. Нэг өдөр чиний эхнэр эсвэл нөхөр магадгүй тэвчээр алдаж ямар ч учир шалтгаангүй чамтай хэрэлдэнэ, ялихгүй зүйлээс болж том хэрүүл үүснэ. Сүүлд нь тэр юундаа тэгж уурласандаа гайхна. Бясалгагч хүний хувьд чи иймэрхүү зөрчил яагаад гардгийг мэддэг байх хэрэгтэй, энэ нь яагаад гэвэл тэр "нэг зүйл" ирж чамайг нүглээ төлөхийг асуудаг. Ийм янзын зөрчлийг давахын тулд чи энэ үед өөрийгээ барьж зан чанараа анхаарч байх хэрэгтэй, чамайг нүглээ төлөхөд чинь тусалж байгаа ханьдаа баярлах хэрэгтэй.

Бясалган удаан завилж суухад хөл өвдөж эхэлнэ, заримдаа тэсэхийн аргагүй өвдөнө. Дээд түвшний Тэнгэрийн мэлмийтэй хүн их өвдөлтийн үед биеийн доторхи, гаднах том хэмжээний хэсэг хар бодис доош бууж устгагдаж байгааг нь хардаг. Завилж суун бясалгахад гардаг өвдөлт хэсэг үе үеэр болдог, тэсэхэд бэрх, зарим хүн үүнийг ойлгодог хөлөө тэнийлгэдэггүй. Тэгэхэд хар бие бодь устгагдаж цагаан бие бодь болж хувирдаг, улмаар *гон* үүсч гарна. Бясалгагч хүн завилж суун бясалгаад мөн дасгал хийгээд бүх нүглээ төлөх боломжгүй, бас зан чанар, гэгээлэг байдлаа дээшлүүлэх хэрэгтэй, зарим бэрхшээл зовлон туулах хэрэгтэй. Юу их чухал вэ гэвэл, бид нинжин сэтгэлтэй байх хэрэгтэй. Манай Фалунь Гон-д хүний нинжин сэтгэл амархан гардаг, олон хүн бясалган сууж байхад ямар ч шалтгаангүйгээр нүднээс нь нулимс дусдагийг мэднэ. Юуны ч тухай бодсон гэсэн тэдэнд уйтгар гуниг төрдөг, хүн болгон зовлонд байгааг хардаг. Энэ бол аугаа нинжин сэтгэл гарсных, чиний зан байдал, жинхэнэ чи өөрөө орчлон ертөнцийн мөн чанар Үнэн, Нинжин, Тэвчээртэй холбогдож эхэлнэ. Чамд нинжин зан байдал гарахад юм хийхдээ маш илүү сайхан сэтгэлээр ханддаг болно. Хүн болгон чиний дотоод сэтгэл, гадаад байдлаас чинь чамайг үнэхээр сайхан сэтгэлтэй хүн гэдгийг хэлж чадна. Тэгэхэд чамд хэн ч дахин муу хандахгүй, хэн нэгэн чамд шударга бус хандсан ч чи аугаа нинжин сэтгэлийн үүднээс хариуд нь тийм янзаар хандахгүй. Энэ бол нэг төрлийн хүч, чамайг энгийн хүнээс ялгаатай болгох хүч.

Гай зовлон тохиолдоход нинжин сэтгэл түүнийг даван туулахад тусална. Үүний зэрэгцээ миний Номын биес чамайг харж хандана, чиний амийг хамгаална, гэхдээ чи бэрхшээл зовлон туулах болно. Жишээ нь, Би Тайюуанд лекц уншиж байхад нэг настай эмэгтэй нөхөртэйгээ лекцэнд суудаг байсан. Тэд нэг удаа зам хөндлөн уаруу гарч яваад замын голд хүрэхэд нэг машин хажуугаар нь хурдан

зөрөхдөө настай эмэгтэйг хувцаснаас нь гогдон татаж унагаад арав гаруй метр хол чирээд замын дунд унагасан, машин өшөө хорин метр явж байж зогссон. Жолооч машинаасаа бууж ирээд бүдүүлгээр загнасан, дотор нь сууж байсан зорчигчид бас муугаар үгэлцгээсэн. Энэ үед настай эмэгтэйд миний хэлсэн санаанд нь орсон, тэгээд юу ч хэлээгүй, босч ирээд "Би зүгээрээ, юу ч гэмтээгүй" гэж хэлсэн. Тэгээд нөхөртэйгээ лекц болох газар луу явсан. Хэрэв тэр үед "Ёо, ёо энд ч, бас тэнд ч өвдөөд байна, намайг та нар эмнэлэгт хүргэж өг" гэж хэлсэн бол юм үнэхээр муугаар эргэх байсан, харин тэгж хэлээгүй. Тэр эмэгтэй надад ингэж хэлсэн: "Багшаа, би яагаад тийм явдал болсныг мэднэ, нүглээ төлөхөд минь надад тусалсан!" Том гай зовлон арилсан, их хэмжээний нүгэл авч хаягдсан. Та нар энэ хүний зан чанар үнэхээр өндөр, мөн хэр их гэгээлэг болохыг нь төсөөлж чадна. Тэр эмэгтэй настай хүн, машин тийм хурдан явж байсан, тийм хол чирэгдээд газарт хүчтэй унасан, гэвч тэр зөв бодолтойгоор босоод ирсэн.

Заримдаа гай зовлон ирэхдээ тун хэцүү, давж гарахын аргагүй санагддаг, энэ нь магадгүй нэлээд олон өдрөөр ч үргэлжилнэ. Тэгтэл гэнэт гарах зам нээгдэж том эргэлт гардаг. Үнэндээ энэ бол бид зан чанараа дээшлүүлснээс бэрхшээл зовлон өөрөө аяндаа арилдаг.

Чиний бодол санааны хүрээг дээшлүүлэхийн тулд энэ дэлхийд чамайг янз бүрийн зовлон бэрхшээлээр шалгана. Чиний зан чанар үнэхээр сайжирч тогтвортой болсон бол явцын дунд нүгэл арилж, гай зовлон өнгөрч чамд *гон* гарна. Зан чанараа барьж чадахгүй өөртөө буруу хандаж шалгалтанд унасан бол битгий зоригоор мох, алдаанаасаа сурч санаа ав, юун дээр доголдож байгаагаа ол, тэгээд Үнэн, Нинжин, Тэвчээр-ийн дагуу бясалгахдаа идэвхи гарга. Чиний зан чанарыг шалгах дараагийн сорилт удахгүй ирж магадгүй. Чиний *гон* хүч нэмэгдэх тусам дараагийн зовлон бэрхшээлийн сорилт улам хүчтэй мөн улам гэнэтийн болж

магад, тэгээд саад бэрхшээлийг давах бүрд *гон* бага багаар өснө. Чи саад бэрхшээлийг давж чадахгүй бол *гон*-ы өсөлт зогсонги байдалд орно. Бага сорилт бага ахиц авчирдаг, том сорилт их ахиц авчирдаг. Би бясалгагч болгонд аугаа зовлон бэрхшээлийг тэвчих бэлтгэлтэй, хүнд бэрхшээлийг хүлээж авах сэтгэлийн тэнхээтэй, зориг төгс байна гэдэгт найдаж байна. Чи идэвхи зүтгэл гаргахгүйгээр жинхэнэ *гон* олж авч чадахгүй, ая тухтай байдлаар, ямар ч зовлонгүйгээр, идэвхи зүтгэл гаргахгүйгээр *гон* олж авна гэсэн зарчим байхгүй. Чиний зан чанар үндсээрээ сайжрахгүй, өөрийн зууралданги сэтгэлээсээ салахгүй хэвээр байвал чи бясалгаад хэзээ ч гэгээрэгч болж чадахгүй!

7. Буг чөтгөрийн үймүүлэл

Буг чөтгөрийн үймүүлэл гэдэг нь бясалгаж байгаа хүнийг үймүүлдэг бясалгалын явцад гардаг, үзэгддэг зүйлс. Тэдгээрийн зорилго нь хүнийг дээд түвшинд бясалгахад саад болох, өөрөөр хэлбэл буг чөтгөрүүд өр төлүүлэхээр ирдэг.

Буг чөтгөр үймүүлэх асуудал дээд түвшинд бясалгахад заавал гардаг. Хүн амьдралдаа буруу зүйл хийхгүй байх аргагүй, өвөг дээдсийн амьдралд бас байсантай адил, үүнийг нүгэл гэдэг. Хүний суурь чанар сайн муу байх нь тэр хүн хэр их хэмжээний нүгэл тээж явдгаас хамаардаг. Хэдий сайн хүн байсан ч нүглээс чөлөөлөгдөх арга байхгүй, чи бясалгадаггүй учраас үүнийг мэдрэхгүй. Чиний бясалгал зөвхөн өвчин эдгээх бие сайжруулах төдийд бол буг чөтгөр тоохгүй, харин чамайг дээд түвшин лүү бясалгаж эхэлмэгц саад болно. Тэд олон янзын арга хэрэглэж чамайг саатуулна, зорилго нь чамайг дээд түвшин лүү бясалгуулахгүй байх, унагах юм. Буг чөтгөрүүд янз бүрийн хэлбэрээр илэрдэг, зарим нь өдөр тутмын амьдралд тохиолддог зүйлсийн хэлбэрээр, зарим нь өөр орон зайн үзэгдэл байдлаар илэрдэг. Чамайг суугаад бясалгах болгонд

тэд янз бүрийн зүйлсийг удирдаж үймүүлнэ, гүн амгалан байдалд оруулахгүй, улмаар дээд түвшинд бясалгах аргагүй болгоно. Суугаад бясалгахад заримдаа чи үүрэглэж эхэлнэ, эсвэл янз бүрийн бодол толгойд чинь орж гарна, тэгээд бясалгах байдалд орж чадахгүй. Зарим үед дасгал хийж эхэлмэгц чимээгүй байсан орчин гэнэт шуугианаар дүүрнэ, хаалга савчина, машин сигналдана, утас дугарна, өөр янз бүрийн үймүүлэл чамайг гүн амгаланд орох боломжгүй болгоно.

Өөр нэг янзын үймүүлэл бол дур тачаалын шулам. Бясалгал хийж байхад эсвэл зүүдэнд үзэсгэлэнтэй бүсгүй эсвэл залуу гарч ирнэ, тэр нь чиний харцыг булаана, дур хүслийг чинь хүргэхээр өдөөх хөдөлгөөн хийнэ. Эхний удаа түүнийг давж чадахгүй бол аажимдаа улам даамжирна, үргэлжлэн чамайг дээд түвшинд бясалгах бодлоо орхитол чинь хүсэл шохоорхлыг чинь татна. Энэ бол давахад хэцүү сорилт, үүнээс болж их олон бясалгагчид унадаг. Би та нарыг үүнд сэтгэл санааны бэлтгэлтэй байхыг хүсч байна. Хэн нэгэн зан чанараа сайн барьж чадахгүй эхний удаа унавал алдаанаасаа үнэхээр ухамсарлах хэрэгтэй. Энэ нь чамайг зан чанараа үнэхээр барьж чаддаг болтол чинь, энэ зууралдсан сэтгэлээсээ бүрэн салтал чинь олон дахин ирж үймүүлнэ. Энэ бол чиний давах ёстой том саад сорилт, эс бөгөөс чи Дао-д хүрч бясалгалынхаа үр дүнг үзэж чадахгүй.

Дасгал хийж байхад эсвэл зүүдэнд гарч ирдэг өөр төрлийн буг чөтгөрүүд бас байдаг. Зарим хүнд гэнэт аймшигтай муухай, яг бодит царай дүрс үзэгдэнэ, эсвэл хутга бариад алахыг завдсан биес харагдана. Гэхдээ тэд хүнийг зөвхөн айлгаж чадна, үнэхээр хутгалах гэсэн ч бясалгагчийн биед хүрч чадахгүй, яагаад гэвэл бясалгагчийн биений эргэн тойронд Багшийн суулгасан бүрхүүл түүнийг гэмтээхгүй хамгаална. Тэд хүнийг айлгаж бясалгахыг болиулах гэж оролдоно. Ийм байдал зөвхөн тодорхой түвшинд, хэсэг хугацаанд л үзэгдэж хэдэн өдөр,

нэг долоо хоног эсвэл хэдэн долоо хоног болоод л хурдан өнгөрдөг. Энэ нь чиний зан чанар хэр өндөр байхаас, энэ асуудалд яаж хандахаас шалтгаална.

8. Төрөлхийн суурь ба Гэгээлэг чанар

Төрөлхийн суурь гэдэг нь хүн төрөхдөө хамт авч ирдэг цагаан бие бодь. Үнэн хэрэгтээ энэ бол буян - биет бодис. Чамтай хамт ирэх энэ бодис их байх тусам чиний төрөлхийн суурь улам сайн. Төрөлхийн суурь сайтай хүний бодол нь төөрөөгүй учраас үнэн биендээ буцах, гэгээрэх нь арай амархан. Тийм хүн *чигон* сурах, эсвэл бясалгалтай холбоотой зүйл сонсонгуутаа тэр даруй сонирхож сурахыг хүсдэг, тэд орчлон ертөнцтэй холбогдож чаддаг. Энэ бол яг Лао Зи-гийн хэлснээр: "Ухаантай хүн Дао сонсвол тэр уйгагүй суралцана. Дундаж хүн сонсвол алдаг оног суралцана. Тэнэг хүн сонсвол шоолж чанга инээнэ. Тэр чангаар инээхгүй бол энэ бол Дао биш." Үнэн биендээ амархан буцаж гэгээрч чадах хүн бол ухаантай хүн. Үүний эсрэг, их хар бие бодистой, төрөлхийн суурь муутай хүний биеийн гадуур сайн зүйл хүлээж авах боломжгүй болгох хаалт үүсдэг. Тэр хар бодис түүнийг сайн зүйлтэй учрахад итгэхгүй болгодог, энэ бол нүглийн хийдэг зүйлийн нэг.

Төрөлхийн суурийг ярихад гэгээлэг чадварын асуудал бас ордог. Бид гэгээлэг болохын талаар ярихад зарим хүн үүнийг сэргэлэн байхтай адил боддог. Энгийн хүний хэлдэг сэргэлэн, овсгоотой хүн бол үнэндээ бидний ярьж байгаа бясалгал дасгалаас маш хол. Ийм нэг овсгоотой хүн гэгээрэлд амархан хүрч чадахгүй. Тэд зөвхөн материаллаг бодит орчлонг анхаардаг учраас бусдад завшигдахгүй байж чадна, аливаа ашгаа алдахаас зайлж чадна. Нэн ялангуяа өөрийгээ мэдлэгтэй, боловсролтой, ухаантайд тооцдог хүмүүс бясалгалыг хоосон үлгэрийн зүйл гэж үздэг. Тэдний

хувьд бясалгах, зан чанараа дээшлүүлэх нь бүтэшгүй зүйл. Тэд бясалгагч хүнийг тэнэг, мухар сүсэгтэн гэж үздэг. Бидний ярьж байгаа гэгээлэг болох нь ухаантай байхыг хэлээгүй харин хүн мөн чанар, жинхэнэ мөн чанартаа буцах, сайн хүн байх, орчлон ертөнцийн мөн чанарт нийцэхийг хэлж байгаа юм. Хүний төрөлхийн суурь гэгээлэг чанарыг тодорхойлдог, төрөлхийн суурь сайтай бол гэгээлэг чанар бас дагаад сайн байх талтай. Төрөлхийн суурь гэгээлэг чанарыг тодорхойлдог ч гэсэн гэгээлэг чанар бүхэлдээ төрөлхийн сууриас шалтгаалахгүй. Чиний төрөлхийн суурь ямар ч сайн байсан чиний хүлээн авах чадвар, ойлгоц адилхан байж чадахгүй. Зарим хүний төрөлхийн суурь тийм сайнгүй гэхдээ гайхалтай гэгээлэг чанартай байдаг, тиймээс дээд түвшин лүү бясалгаж чаддаг. Бид бүх хүнийг аврахыг ярьдаг учраас гэгээлэг чанарыг хардаг, төрөлхийн суурийг хардаггүй. Чамд их олон сөрөг зүйлс байдаг ч бясалгаж дээшлэхээр шийдвэл энэ нь ариун бодол. Ийм бодолтой бол чи бусдаас жоохон түрүүнд яв тэгвэл яваандаа гэгээрэлд хүрнэ.

Бясалгагчийн бие ариусч байдаг, *гон* гарснаас хойш өвчин тусахгүй, яагаад гэвэл ийм дээд энергийн бодис биенд байхад хар бие бодь байхыг зөвшөөрөхгүй. Зарим хүмүүс үүнд итгэдэггүй, өөрийгээ дандаа өвдлөө гэж боддог, "Би яагаад ийм тавгүй байна аа?" гэж өгүүлэл тавьдаг. Бид чиний олж авсан зүйл бол *гон* гэж хэлдэг, тийм сайн зүйл олж авч байхад тааламжгүй байдал гарахгүй байх уу? Бясалгалд үүний хариуд юм өгөх хэрэгтэй, үнэндээ тэр тааламжгүй байдал бол зөвхөн өнгөн дээрээ юм, чиний биенд ямар ч нөлөө байхгүй. Энэ нь өвчин мэт илэрдэг, гэхдээ өвчин биш, энэ бүгд чиний ухамсраас шалтгаална. Бясалгагч хүн хамгийн хүнд зовлон бэрхшээлийг тэвчиж чаддаг байгаад зогсохгүй бас сайн гэгээлэг чанартай байх ёстой. Зарим хүн бэрхшээлтэй тулгарахдаа үүнийг ойлгоё ч гэж боддоггүй, би түүнд дээд түвшинд зааж, өөрийгээ яаж өндөр шалгуураар хэмжихийг харуулж байгаа ч гэсэн тэр

өөрийгээ энгийн хүнтэй адил авч үздэг, жинхэнэ бясалгагч шиг байж чаддаггүй, дээд түвшинд хүрнэ гэдэгтээ ч итгэж чаддаггүй.

Дээд түвшинд ярьж байгаа гэгээрэл бол гэгээрэхийг хэлж байгаа, энэ нь Гэнэт гэгээрэх, Аажим гэгээрэх гэж хуваагддаг. Гэнэт гэгээрэх гэдэг нь бясалгалын бүх явцад түгжигдмэл байдалд байдаг, эцсийн шатанд чиний бясалгалын явц бүрэн дуусахад, чиний зан чанар дээд түвшинд хүрэхэд чиний бүх ер бусын чадварууд нэгэн зэрэг нээгдэнэ, чиний Тэнгэрийн мэлмий хамгийн дээд түвшиндээ шууд нээгдэнэ, чиний оюун санаа өөр орон зайн дээд түвшний амь бодьтой харилцаж чаддаг болно. Чи тэр даруйд бүхэл сансар ертөнцийн үнэн байдлыг харж чадна, янз бүрийн орон зай, диваажингуудыг харна түүнтэй харьцаж чаддаг болно, бас өөрийн аугаа бурхны хүч чадлыг хэрэглэж болно. Гэнэт гэгээрэх зам бол хамгийн хэцүү, түүхийн туршид зөвхөн нэг аугаа төрөлхийн суурьтай хүнийг сонгон авч шавиа болгодог, түүнд ганцаарчлан нууцаар дамжуулдаг байсан. Дунд зэргийн хүнд тэвчихийн аргагүй байдаг, би Гэнэт гэгээрэх замаар явсан.

Миний та нарт өгч байгаа зүйлс бол Аажим гэгээрэлд багтана. Цаг нь болоход чиний бясалгалын явцад ер бусын чадвар гарна, гэхдээ тэр гарсан ер бусын чадварыг чамд хэрэглүүлэх аргагүй байж болно, учир нь чиний зан чанар тодорхой хэмжээнд хүртэл дээшлээгүй байхад буруу зүйл хийх нь амархан бас өөрийгээ зөв барьдаг болох арай болоогүй. Чи тэр ер бусын чадварыг хэсэг хугацаанд хэрэглэх боломжгүй, гэхдээ аажимдаа хэрэглэх боломжтой болно. Бясалгалын явцад чиний түвшин аажмаар дээшилнэ, энэ орчлон ертөнцийн үнэнийг ойлгодог болно. Гэнэт гэгээрэхийн адил чи яваандаа Гэгээрлийн хутагт хүрнэ. Аажмаар гэгээрэх зам нь арай амар бас эрсдэлгүй. Үүний хэцүү нь гэвэл бясалгалын бүх явцыг чи харж байх боломжтой, тиймээс өөртөө тавих шаардлага улам хатуу.

9. Цэвэр, ариун сэтгэл

Зарим хүн *чигон* дасгал хийж байхдаа амгаланд орж чаддаггүй, тэгээд арга зам хайдаг. Зарим хүн надаас ингэж асуудаг: "Багшаа би *чигон* дасгал хийхдээ яагаад амгаланд орж чадахгүй байна аа? Та надад бясалгал хийж суухад амгаланд ордог арга техник зааж өгч болох уу?" Би асуудаг, чи яаж тэгж амгаланд орж чадах юм?! Бурхан ирээд ч чамд арга заасан чи амгаланд орж чадахгүй. Яагаад вэ? Учир нь чиний сэтгэл цэвэр ариун биш, чи ийм нийгэмд амьдарч байна, янз бүрийн сэтгэлийн хөдлөл, хүсэл, хувийн асуудал, сонирхол, гэр бүл найз нөхдийн асуудал хүртэл чиний сэтгэлийг хэтэрхий эзэмдэнэ, түүнийг хамгийн тэргүүн зэрэгт авч үздэг. Чи бясалгаж суухдаа яаж амгаланд орох юм? Чи тэдгээрийг санаатайгаар дарсан ч өөрсдөө ил гараад л ирнэ.

Буддын шашны бясалгалд "орхих, амгаланд орох, билгүүн ухаан" гэж заадаг. Орхих бол зууралдсан сэтгэлээ орхих юм. Зарим Буддын сүсэгтэн Буддын нэрийг давтан унших арга хэрэглэдэг, мянган бодлыг нэг бодлоор солихын тулд уншлагандаа төвлөрөхийг шаарддаг. Гэхдээ энэ бол амар хийчихдэг арга биш, харин чадвар, чи үнэмшихгүй бол оролдоод үз. Чамайг Буддын нэрийг амандаа бувтнан уншихад өөр зүйлс толгойд чинь орж ирэхийг би баттай хэлнэ. Төвдийн Тантрын шашинд анх Буддын нэрийг унших арга гарч ирсэн, Буддын нэрийг өдөр болгон хэдэн зуу, хэдэн мянга дахин долоо хоногийн турш уншина. Тэд толгойгоо дүйнгэ болтол уншина, эцэст нь бодолд юу ч үлдэхгүй, бусад бүх бодлыг нэг бодлоор солих юм. Энэ бол нэг хэлбэрийн чадвар, чи хийж чадахгүй байх. Анхаарлаа төвлөрүүлж сурахыг заадаг өөр аргууд бас байдаг, үрлийн талбайд анхаарлаа төвлөрүүлэх, тоолох, хараагаа нэг зүйл дээр төвлөрүүлэх гэх мэт. Үнэндээ эдгээр аргуудаас аль нь ч чамайг бүрэн амгаланд оруулж чадахгүй. Бясалгагч хүн

цэвэр, ариун бодолтой байх ёстой, зууралдсан хувийн сонирхлоосоо сал, сэтгэл дэх шуналаа орхи.

Хөдөлгөөнгүй гүн амгалан байдалд орж чадах эсэх нь үнэндээ чиний түвшин чадварыг харуулж байгаа юм. Суугаад л гүн амгаланд орж байвал дээд түвшинд байгааг харуулж байна. Нэг хэсэгтээ гүн амгаланд орж чадахгүй байвал зүгээр, бясалгалаар чи аажимдаа үүнд хүрнэ. Чиний зан чанар дээшлэхийн сацуу *гон* дээшилнэ. Чи хувийн сонирхол, хүслээ хөнгөн харахгүй бол *гон* хэзээ ч гарахгүй.

Бясалгагч хүн өөрийгөө цаг ямагт дээд шалгуураар барих хэрэгтэй. Бясалгагч хүн нийгмийн янз бүрийн төвөгтэй үзэгдэл, маш их бүдүүлэг эрүүл бус зүйлийн болон янз бүрийн сэтгэл хөдлөл, хүслийн үймүүлэлд байнга байдаг. Телевиз, кино болон уран зохиолд сурталчилдаг зүйлс чамд энгийн хүмүүсийн дунд хүчтэй, илүү бодь хүн болохыг заадаг. Чи энэ бүхний цаана гарч чадахгүй бол бясалгагчийн зан чанар, бодлын түвшнөөс улам холдоно. Бясалгагч хүн тэдгээр бүдүүлэг, эрүүл бус зүйлсээс хол байх хэрэгтэй, тэдгээрийг харахгүй сонсохгүй байх, тийм хүмүүст, зүйлд татагдахгүй байх хэрэгтэй. Энгийн хүний бодол намайг хөдөлгөж чадахгүй гэж би дандаа хэлдэг, хүн намайг магтвал би хөөрөхгүй, хүн намайг доромжилбол сэтгэлээр унахгүй, энгийн хүний дунд зан чанарын ямар ч ноцтой зөрчил гарсан надад нөлөөлөхгүй. Бясалгагч хүн хувийн ашгин дээр даруу харах хэрэгтэй, бүр сонирхохгүй байх хэрэгтэй, тэгвэл чиний гэгээрэх зорилго ул суурьтайд тооцогдоно. Хэрэв чи нэрд гарах, хувийн ашиг олох гэсэн их хүсэлгүй, түүнийг ямар нэгэн зайлшгүй зүйл гэж үзэхгүй байвал чи санаагаар унаж гутрах зүйлгүй, сэтгэл чинь үргэлж тайван байна. Бүхнийг орхиж чаддаг болоход чиний сэтгэл жамаараа цэвэр ариун болно.

Би та бүхэнд Дафа болон таван дасгалыг бүгдийг заалаа, чиний биеийг засч Фалунь болон энергийн механизм

суулгаж өглөө. Миний Номын бие чамайг хамгаална, энэ бүх өгөх ёстой зүйлсийг өглөө. Хичээлийн явц надаас хамаарна, үүнээс хойш бүх зүйлс чамаас хамаарна. Багш чамайг бясалгалын хаалгаар оруулж өглөө харин цааш бясалгах нь чиний хэрэг. Чи Дафа-г сайтар ухамсарлаж, танин мэдэхийн төлөө уйгагүй хичээж, цаг мөч бүр зан чанараа сахиж, тууштай бясалгаж, бүхнээс хэцүү зовлон бэрхшээлийг давж, хүндээс хүнд саад бэрхшээлийг тэсвэрлэж чадвал чамайг бясалгалынхаа үр дүнд хүрнэ гэдэгт би итгэж байна.

Сэтгэл бол гон бясалгалын харгуй зам
Дафа- далай тэнгис лугаа хязгааргүй
Бэрхшээл зовлон бол чиний завь

Дөрөвдүгээр бүлэг

Фалунь Гон бясалгалын систем

Фалунь Гон бол Буддын системийн онцгой бясалгал. Энэ нь бусад Буддын ердийн бясалгалуудаас ялгагдах онцлог талуудтай. Фалунь Гон бол дээд бясалгалын систем. Урьд энэ нь маш хатуу бясалгалын арга байсан, бясалгагчаас туйлын өндөр зан чанар, аугаа бишрэл үнэмшилтэй байхыг шаарддаг байсан. Ийм шалтгаанаас болж энэ бясалгалын системийг нийтэд дэлгэрүүлэхэд хэцүү байсан. Гэхдээ энэ бясалгалын системийг олон хүнд мэдүүлэх, тэдний түвшинг дээшлүүлэх, олон тууштай бясалгагчдын хүсэлд нийцүүлэхийн тулд бясалгалын цогц дасгалыг нийтэд тохируулан өөрчилсөн. Хэдий өөрчилсөн ч гэсэн энэ дасгалууд нь дундаж бясалгалын системүүдээс түвшин болон үр нөлөөний хувьд хол давсан.

Фалунь Гоны бясалгагчид *гон* хүчээ болон ер бусын чадвараа хурдан өсгөөд зогсохгүй бас маш богино хугацаанд зүйрлэшгүй хүчит Фалунийг олж авна. Фалунь үүссэн цагаасаа бясалгагчийн хэвлийн доод хэсэгт автоматаар үүрд эргэж байх болно. Энэ нь тасралтгүйгээр орчлон ертөнцөөс энергийг цуглуулж авч бясалгагчийн бие дотор *гон* болгон хувиргана. Ном хүнийг бясалгах зорилгод ингэж хүрнэ.

Фалунь Гон, дасгалын таван цогц хөдөлгөөнтэй. Үүнд: Буддын мянган гарын суниалт дасгал, Фалунь багана зогсолт дасгал, сансрын хоёр туйлыг нэвтрэх дасгал, Фалунь тэнгэрийн эргүүлэг дасгал, мөн Ер бусын чадварыг эрчимжүүлэх дасгал ордог.

1.Буддын мянган гарын суниалт.

(Фо Жань Чиань Шоу Фа)

Дасгалын зарчим: Буддын мянган гарын суниалт дасгалын үндэс нь бол бүх энергийн сувгийг нээхэд юм. Эхлэн суралцагч энэ дасгалыг хийснээр богино хугацаанд энерги олж авна, мөн дадлагатай сурагч түргэн дээширнэ. Дасгалын эхнээс бүх энергийн сувгууд онгойхыг шаарддаг, бясалгагчид шууд дээд түвшинд бясалгах боломж өгдөг. Аугаа номыг сурахад энгийн бөгөөд хялбар байдаг учраас дасгалын хөдөлгөөн ч гэсэн нилээд хялбархан. Хөдөлгөөн хялбар ч гэсэн бясалгалын системд байдаг бүх зүйлсийг удирддаг. Энэ дасгалыг хийхэд бие халуун оргино, их хүчтэй энергийн орон байгааг мэдрэх онцгой байдал гардаг. Энэ байдал суниалтаар бүх биеийн энергийн судлууд нээгдсэнээс гардаг. Зорилго нь энерги түгжигдсэн газрыг нээх, энергийн чөлөөтэй жигд эргэлтийг бий болгох, биений дотоод болон арьсан доогуурхи энергийн урсгалыг эрчимжүүлэх, мөн орчлон ертөнцөөс их хэмжээний энергийг шингээж авахад юм. Энэ нь бясалгагчийг нэгэн зэрэг *чигон* энергийн оронтой болох байдалд түргэн хүргэдэг. Энэ бол Фалунь Гон-ы суурь дасгал, гол төлөв

Уншлага: ²⁹

Шэньшэнь Хөи ³⁰

Донжин Сүйжи ³¹

Динтиань Дүзүнь ³²

Чианьшоу Фоли ³³

²⁹ Уншлагыг дасгал хийх болгоны өмнө зөвхөн нэг удаа Хятадаар уншина, дасгалын хөдөлгөөн бүр өөрийн гэсэн уншлагатай, үүнийг дотроо нэг удаа унш эсвэл дасгалын бичлэгэнд хэлэхийг сонс.

³⁰ Шэньшэнь Хөи-Амь бие, сэтгэл нэгдлээ

³¹ Донжин Сүйжи- Энергийн механизмын дагуу хөдөлнө, бас зогсоно

³² Динтиань Дүзүнь- Тэнгэр баганадсан өндөр

³³ Чианьшоу Фоли- Мянган гартай Будда зогсож байна

хамгийн эхэнд хийдэг. Энэ бол бясалгалыг эрчимжүүлэх аргын нэг хэлбэр.

Бэлтгэх байдал: Бүх биеэ сул тавь, гэхдээ хэт суллаж болохгүй. Хөлдөө мөрний хэмжээтэй зай аваад сул зогс, өвдгөө бага зэрэг нугална, өвдөг ташаагаа сул байлга. Эрүүгээ жоохон тат, хэлний үзүүрээ тагнайндаа хүргэ, шүдний хооронд жоохон завсар гарган уруулаа зөөлөн жимийнэ, нүдээ аяархан аниад нүүрэндээ амгалангуй байдалтай бай. Дасгалын үед чи өөрийгээ их том өндөр гэж мэдэртнэ.



(Зураг 1-1)

Хоёр гараа нийлүүлэх (Лианшоу Жэинь)³⁴ -Хоёр алгаа дээш харуулан барина. Хоёр гарын эрхий хуруунуудын үзүүр хоорондоо зөөлөн шүргэнэ, бусад хуруунуудаа

³⁴ Лианшоу Жиэнь- Хоёр гараа нийлүүлэх.

нийлүүлэн дээр дээрээс нь давхцуулан тавина. Эрэгтэй хүн зүүн гараа дээр нь тавина, эмэгтэй хүн баруун гараа дээр нь тавина, хоёр гараа зуйван хэлбэртэйгээр хэвлийн доод хэсэгт барина. Хоёр гараа тохойгоор нугалан жоохон урагш барина, сугаа хавчихгүй зайтай байлгана.

(Зураг 1-1)



(Зураг 1-2)

(Зураг 1-3)

(Зураг 1-4)

Майдар бурхан³⁵ нуруугаа тэнийлгэх (Милэ Шэньяо)

Жэинээс эхэлнэ, хоёр гараа дээшээ өргөхөд хоёр хөл аажмаар тэнийнэ. Гар нүүрний урд ирэхэд гараа салгаж аажмаар алгаа эргүүлэн дээш сунгана. Гар толгой дээр ирэхэд алга дээшээ харж, хоёр гарын хуруунууд өөд

³⁵ Майдар- Буддизмд энэ нь ирээдүйд дэлхийд ирж хүн аврах Будда.

өөдөөсөө харна. (Зураг 1—2) хоёр гарын хурууны үзүүрүүдийн хооронд 20—25 см байна. Толгойгоо дээш түлхэж хөлөө доош хүчтэй жийнэ, улаараа жигд гишгэнэ, хоёр бугуй алгаа дээш нь сайн түлхэж бүх биеэ 2-3 секунд хүчтэй сунгаж бариад гэнэт бүх биеэ сул тавь, өвдөг ташаагаа буцаагаад суллаж эхний байдалд оруулна.

Рулай³⁶ бурхны энергийн адислалт (Рулай Гуаньдин) - Урьдын байдлыг үргэлжлүүлэн хоёр гараа гадагшаа 140 градус зэрэг эргүүлэн бугуйнууд дотор талаараа өөд өөдөөсөө харан юүлүүр хэлбэртэй болно, хоёр бугуйгаа эгцэлж хоёр алгаа бие рүү харуулан доош буулгана (Зураг 1-3), алга цээжнээс 10см-ээс илүүгүй байна, гараа үргэлжлүүлэн буулгаж хэвлийн доод хэсэгт авчирна. (Зураг 1-4).

Цээжний өмнө хоёр алгаа хавсран залбирах (Шуаньшоу Хөши) -Гар хэвлийн доод хэсэгт ирэхэд гарын ар талаа өөд өөдөөс нь харуулан дээш өргөн цээжний өмнө авчирч дээш эргүүлэн залбирна. (Зураг 1-5). Залбирахдаа хуруунуудаа болон бугуйгаа нийлүүлнэ, алганы хонхорт жоохон зай үлдээнэ, тохой дээшээ, хоёр гарын шуу тэгшхэн байна. (Хоёр гар залбирах болон Жэинээс бусад үед хуруунуудаа үргэлж “Лянхуа цэцгийн дэлбээ³⁷” хэлбэртэй барина). Дараачийн дасгалуудад бас адил.

Алгаа тэнгэр газар луу харуулах (Жаньши Чианькун)¹⁹ Залбиралтаас эхэлнэ. Хоёр алгаа 2-3 см зайтай салгаад эсрэг зүг рүү эргүүлнэ, эрэгтэй хүн зүүн гараа (эмэгтэй хүн баруун гараа) цээж рүү эргүүлнэ, нөгөө гараа гадагш эргүүлнэ, ингэхэд зүүн гар дээр, баруун гар доор ирнэ, гар

³⁶ Рулай - Архад болон Бодьсадваас дээд түвшинд гэгээрсэн Будда. (Татагата)

³⁷ Лянхуа цэцгийн хэлбэр- Бясалгал хийж байх турш гараа Лянхуа цэцгийн дэлбээ хэлбэртэй байлгана, энэ нь дунд хуруу бусад хуруунаас ялимгүй урагшаа байна.

шуутай нэг шулуунд байна. (Зураг 1—6) Үргэлжлүүлээд дээд гараа хажуу дээш нь ташуугаар тэнийлгэнэ, алга доош харна, толгойтой чацуу өндөртэй барина. Нөгөө гараа цээжний өмнө хэвээр байлгана, алга дээш харсан байна.



(Зураг 1-5)



(Зураг 1-6)



(Зураг 1-7)

Дээд гараа сунгахын дагуу биеэ аажмаар сунгана, толгойгоо дээш түлхэнэ, хоёр хөлөө доош жийнэ. Дээд гараа зүүн дээшээ сунгана, (эмэгтэй хүн баруун тийш) мөн цээжний өмнөх гарыг гадагш хамт сунгана. (Зураг 1-7) 2-3 секунд сунгаж бариад бүх биеэ гэнэт сул тавина. Өргөсөн гараа цээжний өмнө авчирч хоёр гараар залбирна. Дараа нь хоёр гараа дахин эсрэг зүг рүү эргүүлэхэд эрэгтэй хүний баруун гар дээр нь зүүн гар доор нь байна. (эмэгтэй хүний зүүн гар дээр нь баруун гар доор нь) (Зураг 1-8) Баруун гараар зүүн гарын адил урьдын сунгах хөдөлгөөнийг давтан хийнэ (Зураг 1-9), сунгасны дараа бүх биеэ огцом сул тавиад хоёр гараа цээжний өмнө авчирч залбирна. (Зураг 1-5).



(Зураг 1-8)



(Зураг 1-9)

Алтан сармагчин биеэ салгах (Жинхоу Фэньшэн)
Залбиралтаас эхэлнэ. Хоёр гараа цээжний урдаас хоёр тийшээгээ салгаж мөртэй тэгшхэн сунгана. Аажмаар бүх биеэ сунгана, толгойгоо дээш түлхэнэ, хоёр хөлөө доош жийнэ, хоёр гараа хоёр тийш нь хүчтэй сунгана, дөрвөн зүг рүү 2-3 секунд сунгаж барина. (Зураг 1-10) Дараа нь бүх биеэ гэнэт сул тавиад хоёр гараа залбирах байдалд авна.

Хоёр луу далай руу шумбах (Шуанлон Сиахай)
Залбиралтаас эхэлнэ. Хоёр гараа салган биеийн урд талаар доош тэнийлгэнэ. Хоёр гар зэрэгцсэн шулуун, биенээс ойролцоогоор 30° налуу байна, (Зураг 1-11) бүх биеэ сунгана, толгойгоо дээш түлх, хоёр хөлөө доош жийнэ, 2-3



(Зураг 1-10)



(Зураг 1-11)

секунд бариад дараа нь бүх биеэ гэнэт сул тавина, хоёр гараа буцааж цээжний өмнө авчирч залбирна.

Бодьсадва ³⁸ **Лянхуа цэцгийг элбэх-** (Пуса Фүлиан) Залбиралтаас эхэлнэ. Хоёр гараа салган биеийн хоёр талаар доош ташуугаар тэнийлгэ (Зураг 1–12), гар хөлнөөс ойролцоогоор 30° налуу байна. Бүх биеэ аажмаар сунга, хурууны үзүүрүүд доош чиглэсэн бага зэрэг хүчтэй сунгана, энэ үед толгойгоо дээш түлхэн хоёр хөлөө хүчтэй гишгэнэ, 2-3 секунд бариад дараа нь бүх биеэ огцом сул тавина. Хоёр гараа цээжний өмнө авчирч залбирна.

³⁸ Бодьсадва- Архадаас дээш, Рулайгаас доош түвшинд гэгээрсэн бурхан.



(Зураг 1-12)



(Зураг 1-13)

Архад³⁹ уулыг үүрэх (Лүохань Бэйшан)- Залбиралтаас эхэлнэ. Хоёр гараа салган биеийн ар тал руу тэнийлгэн сунгахдаа алгаа хойш харуулна. Хоёр гар биеийн хажуугаар өнгөрөхөд хоёр бугуйгаа аажмаар дээш нугална, гар биеийн ард хүрэхэд тохойгоор шулуун биенээс 45° налуу байна (Зураг 1-13). Бүх биеэ аажмаар сунга, гар байрлалдаа хүрэхэд толгойгоо дээш түлхэж хоёр хөлөө доош жийнэ, биеэ эгцхэн байлгана, 2-3 секунд суниаж бариад дараа нь бүх биеэ гэнэт сул тавина. Буцаагаад хоёр гараа цээжний өмнө авчирч залбирна.

Очирваань⁴⁰ уулыг түлхэх (Жиньган Пайшан) - Залбиралтаас эхэлнэ. Хоёр гараа салган урагш чигээр түлхэнэ,

³⁹ Архад - Бодьсадвагаас доош, дөнгөж Гурамсан ертөнцөөс гарсан бурхан.

⁴⁰ Очирваань- Буддын шадар цэрэг.

хурууны үзүүрүүд дээш чиглэсэн, гар мөртэй чацуу өндөртэй байна. Хоёр гар тэгшрэн шулуун болоход толгойгоо дээш түлхэнэ, хоёр хөлөө доош жийнэ,



(Зураг 1-14)



(Зураг 1-15)



(Зураг 1-16)

(Зураг 1—14) 2-3 секунд сунгаж барьсны дараа бүх биеэ гэнэт сул тавьж хоёр гараа залбирах байдалд авна.

Хэвлийн урд алгаа давхарлан барих (Диекоу Шиаофү) Залбиралтаас эхэлнэ. Хоёр гараа аажмаар доош буулган алгаа хэвлий рүү харуулна. Гар хэвлийн доод хэсэгт хүрэхэд хоёр алгаа давхарлан барина (Зураг 1-15). Эрэгтэй хүн зүүн алгаа дотор талд, эмэгтэй хүн баруун алгаа дотор талд барина, гадна талын алга дотор талын алганы ар талруу харна. Хоёр алганы хооронд, дотоод алга хэвлийн хооронд ойролцоогоор гурав гурван сантиметр зайтай байна. Хэвлий гэдэсний урд гараа давхарлан 40—100 секунд зогсоно. Хоёр гараа Жэинь хэлбэрт барин дасгалаа дуусгана. (Зураг 1-16).

2. Фалунь багана зогсолт

(Фалунь Жуан Фа)

Дасгалын зарчим: Энэ бол Фалунь Гон-ы хоёр дахь дасгал, дөрвөн байдлаар хүрд барин хөдөлгөөнгүй зогсож хийх дасгал. Хэдхэн хөдөлгөөнөөс тогтоно, барилт болгоныг нилээд урт хугацаагаар хийнэ. Шинэ сурагчдын гар эхэндээ чилж хөндүүр болж магадгүй, гэхдээ дасгалыг хийсний дараа ажил хийсэн шиг ядрахгүй, бүх бие нь дорхноо хөнгөрснийг мэдэрнэ. Дасгал хийх хугацааг уртасгаж мөн дасгалыг тогтмол хийх тусам хоёр гарын хооронд Фалунь эргэж байгааг мэдэрнэ. Фалунь багана зогсолтыг тогтмол хийвэл бясалгагчийн бүх бие онгойход тустай бөгөөд *гон* хүчийг эрчимжүүлнэ. Энэ бол бүх талын бясалгал, оюун ухааныг тэлнэ, бясалгагчийн түвшинг дээшлүүлнэ, мөн ер бусын чадварыг хүчирхэгжүүлнэ. Хөдөлгөөн нь энгийн боловч дасгалаар олох зүйл нь маш их бөгөөд бүхнийг багтаасан. Дасгалын үед хөдөлгөөн нь аясаараа байх ёстой, өөрөө хийж байгаагаа мэдэж байх ёстой, ганхаж болохгүй, гэхдээ бага зэрэг хөдлөх бол хэвийн. Фалунь хэзээ ч эргэхээ зогсдоггүй учраас бусад Фалунь Гон бясалгалуудын адил энэ дасгалыг хийж дуусах нь бясалгал хийж дууссан гэсэн үг биш. Хүрд барих дасгалын хугацаа нь урт байх тусам улам сайн, гэхдээ хүн болгон адилгүй.

Уншлага:
Шэнхүй Зэнли⁴¹
Роншин Чинти⁴²
Симиао Сивү⁴³
Фалунь Чөчи⁴⁴

Бэлтгэх байдал: Хөлдөө мөрний хэмжээтэй зай аваад сул зогс, өвдгөө бага зэрэг нугалан өвдөг ташаагаа сул байлга, бүх биеэ сул тавь, гэхдээ хэт сул тавихгүй. Эрүүгээ жоохон тат, хэлний үзүүрээ тагнайндаа хүргэнэ, шүдний хооронд жоохон завсартай, уруулаа жимийгээд, нүдээ зөөлөн анина,



(Зураг 2-1)



(Зураг 2-2)



(Зураг 2-3)

⁴¹ Шэнхүй Зэнли - Оюун ухаан нэмэгдэж хүч бэхэжлээ.

⁴² Роншин Чинти- Сэтгэл төвшин, бие хөнгөн.

⁴³ (Симиао Сивү)- Гайхалтай ч юм шиг, гэгээрсэн ч юм шиг.

⁴⁴ (Фалунь Чөчи)- Фалунь гарч ирэх

нүүрэндээ амгалан байдалтай бай. Хоёр гараа Жэинь байдалд авна (Зураг 2-1).

Толгойн өмнө хүрд барих (Тоучиан Баолун)-Жэинээс эхэлнэ. Гараа хэвлийн өмнүүр аажмаар дээш өргөнгөө Жэиенээс хоёр гараа салгана. Хоёр гар толгойн өмнө ирэхэд алга нүүр лүү харсан, хөмсөгний харалдаа байна. Хурууны үзүүрүүд өөд өөдөөсөө харна, хоорондын зай ойролцоогоор 15см, хоёр гар дугуйрсан хэлбэртэй байна, бүх биеэ сул тавь (Зураг 2-2).

Хэвлийн өмнө хүрд барих (Фүчиан Баолун) Хоёр гараа толгойн өмнө хүрдийг барих -аас аажмаар доошоо буулгана, барилаа өөрчлөхгүйгээр хэвлийн өмнө авчирна (Зураг 2-3). Хоёр тохой урагшаа, суга хөндий байна, алга дээшээ харна, хуруунууд өөд өөдөөсөө харсан, хоорондоо 10см зайтай, хоёр гар дугуй хэлбэртэй байна.

Толгойн дээр хүрд барих (Тоудин Баолун) -Хэвлийн өмнө хүрдийг барих -аас эхэлнэ. Хэлбэр нь өөрчлөгдөхгүй, хоёр гараа аажмаар өргөж толгойн дээр авчирна, толгой дээр хүрдийг барина (Зураг 2-4). Хуруунууд өөд өөдөөсөө харсан, хоорондоо 20-30см зайтай, алга доошоо харсан, хоёр гар дугуй хэлбэртэй байна. Мөр, гар, тохой, бугуйгаа бүгдийг нь сул байлгана.



(Зураг 2-4)



(Зураг 2-5)

Толгойн хоёр талд хүрд барих (Лианцэ Баолун) -Толгой дээр хүрд барих-аас эхэлнэ, хоёр гараа доош буулгаж (Зураг 2-5) толгойн хоёр талд авчирна, алга чих рүү харна. Мөрөө сул тавь, шуугаа эгц байлга, гар чихний хоорондын зай нь хэтэрхий ойр байж болохгүй.



(Зураг 2-6)



(Зураг 2-7)

Алгаа давхарлаад хэвлийн доод хэсэгт барих

(Диэкоу Сиафу) Хоёр талд хүрдийг барих байдлаас хоёр гараа доош нь аажмаар буулгаж хэвлийн өмнө авчирна, алгаа давхарлан барина (Зураг 2-6). Гараа Жэинь барилд авч дасгалаа дуусгана (Зураг 2-7).

3. Сансрын хоёр туйлыг нэвтрэх (Гуаньтон Лианжи Фа)

Дасгалын зарчим: Сансрын хоёр туйлыг нэвтрэх нь орчлон ертөнцийн энергийг биеийн дотоод энергитэй холих арга юм. Энэ дасгалыг хийх үед оруулах, гаргах энергийн хэмжээ асар их, бясалгагчийн биенээс өвчний хар чийг маш богино хугацаанд гаргана, орчлон ертөнцөөс их хэмжээний энергийг авч биеийг ариусгана, сүүн цагаан биений байдалд хурдан хүрнэ. Түүнчлэн гарын дээш доош хөдлөх дасгал нь толгойн оройн оруулах суваг нээгдэхэд түлхэц болно, мөн хөлний уланд байдаг гаргах сувгууд онгойдог.

Дасгал хийхээс өмнө өөрийгөө тэнгэр газрын хооронд босоогоор байрлах хоёр том хөндий хоолой, агуу том гэж төсөөл. Гарын дээшлэх хөдөлгөөнөөр толгойн оройгоор гарсан биений чий шууд орчлон ертөнцийн дээд туйл руу явдаг, гарын доошлох хөдөлгөөнөөр хөлийн улаар гарсан чий орчлон ертөнцийн доод туйл руу явдаг. Гарын энэ хөдөлгөөний дараа хоёр туйлаас энерги буцаж ирж биенд орно, дараа нь эсрэг зүгүүд рүү гарна. Хоёр гарын дээш доош эсрэг зүгт хөдлөх нь тус бүр есөн удаа. Ес дэх удаа зүүн гар дээш өргөөстэй үлдэнэ (эмэгтэй хүний баруун гар) тэгээд нөгөө гар дээш ирнэ. Дараа нь хоёр гар зэрэг доош бууна, энергийг доод туйлд хүргэнэ, мөн биеийн дагуу дээш хөдөлж дээд туйл руу хүргэнэ. Хоёр гар дээш доош есөн удаа явсны дараа энерги биенд буцаж орно. Фалунь хэвлийн доод хэсэгт цагийн зүүний дагуу дөрвөн удаа эргэж (урд талаас харахад) биеийн гадна байгаа энергийг дотогш оруулдаг. Хоёр гар Жэинь байдалд орж дасгал дуусна, гэхдээ *гон*-ы үйл ажиллагаа зогсохгүй.

Уншлага:
Жинхуа Бэньти⁴⁵
Факай Динди⁴⁶
Шиньци Иймэн⁴⁷
Тонтиан Чөди⁴⁸



(Зураг 3-1)



(Зураг 3-2)

Бэлтгэх байдал: Хөлдөө мөрний хэмжээтэй зай аваад сул зогс, өвдгөө бага зэрэг нугална, өвдөг ташаагаа сул тавь, бүх биеэ сул тавь, гэхдээ хэт суллаж болохгүй. Эрүүгээ жоохон тат, хэлний үзүүрээ тагнайндаа хүргэнэ, дээд доод шүдний хооронд жоохон завсар үлдээ, уруулаа зөөлөн жимийгээд нүдээ аяархан анина, нүүрэндээ амгалангуй төрхтэй бай.

⁴⁵ Жинхуа Бэньти- Бие ариуслаа

⁴⁶ Факай Динди- Ном энергийн дээд доод гарцыг онгойлголоо

⁴⁷ Шиньци Иймэн- Сэтгэл энэрэнгүй, хүсэл зориг шийдмэг

⁴⁸ Тонтиан Чөди- Эгц тэнгэрт хүрнэ, доош газрын гүнд хүрнэ

Хоёр гараа Жэинь барилд ав, (Зураг 3-1) дараа нь цээжний өмнө авчирч залбирна. (Хөши) (Зураг 3-2).

Нэг гарын дээш доош сэлгэх хөдөлгөөн (Даньшоу Чонгуан) Залбиралтаас эхэлнэ. Дасгал нэг гарын хөдөлгөөнөөр эхэлнэ, хоёр гар биеийн гаднах энергийн механизмын дагуу аажмаар хөдөлнө. Гарын хөдөлгөөний дагуу биеийн дотоод энерги дээш доош тасралтгүй урсана. Эрэгтэй хүн эхлээд зүүн гараа дээш өргөнө (Зураг 3-3) (эмэгтэй хүн баруун гараа). Гараа зөөлөн өргөн нүүрний өмнүүр өнгөрөөж толгойн дээш сунгана, мөн үүнтэй зэрэг нөгөө гараа аажмаар доошлуулна. Хоёр гараар энэ байдлаар ээлжилнэ (Зураг 3-4), хоёр алга бие рүү харсан 10см-ээс холгүй зайтай байна. Дасгалын үед бүх биеэ сул байлга, гарын нэг дээш доош хөдөлгөөнийг нэг удаа гэж тоолно, нийт есөн удаа давтана.



(Зураг 3-3)



(Зураг 3-4)

Хоёр гарын дээш доош сэлгэх хөдөлгөөн (Шуаншоу Чонгуань) -Нэг гарын ес дэх сэлгэх хөдөлгөөний дараа зүүн гар (эмэгтэй хүний баруун гар) өргөсөн хэвээр үлдэж нөгөө гараа дээш авчирч хоёр гар дээш чиглэнэ (Зураг 3-5), тэгээд хоёр гараа зэрэг доош буулгана (Зураг 3-6).



(Зураг 3-5)



(Зураг 3-6)

Хоёр гарын алга бие рүү харсан байна, биенээс 10см-ээс холгүй зайтай байна. Нэг удаа дээш доош хийснийг нэг гэж тоолно, давтан есөн удаа хийнэ.

Хоёр гараар Фалунийг эргүүлэх (Шуаншоу Туйдон Фалунь) -Хоёр гарын ес дэх хөдөлгөөн хийж дууссаны дараа хоёр гар нүүр, цээжний урдуур өнгөрч доош буун хэвлийн доод хэсэгт ирнэ. (Зураг 3-7). Хэвлийн доод хэсэгт



(Зыпар 3-7)



(Зыпар 3-8)



(Зыпар 3-9)



(Зыпар 3-10)

хоёр гараар Фалунийг эргүүлнэ (Зураг 3-8), (Зураг 3-9). Эрэгтэй хүний зүүн гар нь дотор талд, эмэгтэй хүний баруун гар нь дотор талд байна, хоёр гарын хооронд болон дотор талын гар ба хэвлийн хооронд 2-3см зайтай байна, цагийн зүүний дагуугаар Фалунийг дөрвөн удаа эргүүлж биеийн гаднах энергийг биеийн дотор луу татна. Фалунийг эргүүлэхдээ хоёр гараа хэвлий гэдэсний хүрээнээс хэтрүүлэхгүй.

Хоёр гараа Жэинь байдалд авна (зураг 3-10).

4.Фалунь тэнгэрийн эргүүлэг (Фалунь Жоутиан Фа)

Дасгалын зарчим: Фалунь тэнгэрийн эргүүлэг нь хүний биеийн энергийг өргөн хэмжээнд эргэлтэнд оруулдаг, энерги зөвхөн нэг судал эсвэл хэдэн судлаар эргэхийн оронд биеийн бүхэл билиг талаас арга тал руу дахин дахин эргэдэг. Энэ дасгал судлыг нээх ердийн аргаас болон их бага тэнгэрийн эргүүлгээс маш их давуутай. Энэ бол Фалунь Гон-ы дунд түвшингийн дасгал юм, өмнөх гурван дасгал бол суурь, энэ дасгалын зорилго бол бүх биеийн судлыг онгойлгох (Их тэнгэрийн эргүүлэг бас багтана), тэгснээр судлууд аажмаар дээрээс доошоогоо бүх бие дагуу холбогдоно. Фалунь тэнгэрийн эргүүлэг дасгалын хамгийн гол онцлог нь Фалуний эргэлтээр хүний биеийн бүх хэвийн бус байдлыг засдаг, хүний биеийг - жижиг орчлон ертөнцийг хамгийн анхны төрөлх байдалд буцаана, бүх биеийн судлууд онгойж энергийн эргэлт чөлөөтэй жигд болно. Ийм байдалд хүрэхэд, бясалгагч Гурамсан ертөнцийн номын бясалгалын маш өндөр түвшинд хүрнэ. Хэрэв тэр аугаа итгэл үнэмшилтэй бол Дафа бясалгал руу орж болно, тэгэхэд *гон* хүч, ер бусын чадвар илт нэмэгдэнэ. Дасгалыг хийхэд хоёр гар энергийн механизмын дагуу

хөдөлнө, хөдөлгөөн бол зугуухан, аажим, дугуйрсан хэлбэртэй.

Уншлага:

Шуаньфа Жишү⁴⁹

Шиньчин Сиюү⁵⁰

Фаньбэнь Гүйжэнь⁵¹

Юуюю Сичи⁵²

Бэлтгэх байдал: Бүх биеэ сул тавь, гэхдээ хэт сул тавихгүй хөлдөө мөрний хэмжээтэй зай аваад сул зогс, өвдгөө бага зэрэг нугалсан, өвдөг ташаагаа сул тавь. Эрүүгээ жоохон тат, хэлний үзүүр тагнайд хүрсэн, дээд доод шүдний хооронд бага зэрэг зайтай, уруулаа сул жимийгээд нүдээ зөөөлөн анина, нүүрэндээ амгалан дүртэй бай.

Хоёр гараа Жэинь байдалд авна (Зураг 4-1) дараа нь цээжний өмнө авчирч залбирна (Зураг 4-2). Хоёр гараа залбиралтаас салгаад хоёр алгаа бие рүү харуулан хэвлийн доош явуулна, гар биенээс 10см-ээс хэтрэхгүй зайтай байна. Гараа хэвлийгээс доош буулган хөлний дотор талаар явуулна, бэлхүүсээрээ бөхийж доошилно, тахимаар нугалж хагас сууна (Зураг 4-3). Хурууны үзүүр газарт ойртоход хоёр гар хөлний урдаас хоёр хажуу талаар дугуйран өсгийн ард тойрч ирнэ (Зураг 4-4). Дараа нь хоёр бугуйгаа бага зэрэг нугалан хоёр гараа хөлний ар талаар аажмаар дээш өргөнө (Зураг 4-5). Хоёр гар нуруу даган дээшлэхэд

⁴⁹ Шуаньфа Жишү- Номын эргэлт огторгуйд хүрнэ

⁵⁰ Шиньчин Сиюү- Сэтгэл хаш лугаа ариун

⁵¹ Фаньбэнь Гүйжэнь- Үнэнд хүрч эх үндсэндээ буцна

⁵² Юуюю Сичи- Хөөрөх мэт хөнгөн мэдрэмжтэй



(3ypar 4-1)



(3ypar 4-2)



(3ypar 4-3)



(3ypar 4-4)



(3ypar 4-5)



(3ypar 4-6)

бэлхүүсээ тэнийлгэнэ (Зураг 4-6). Дасгалын туршид хоёр гараа биендээ битгий хүргэ, тэгвээс хоёр гарт байгаа энерги биенд буцаад орчихно. Хоёр гар ар талаар дээш тултлаа өргөгдөхөд, хоёр алгаа хоосон атгана (Зураг 4-7), дараа нь хоёр гараа суганы доогуур гаргаж ирээд цээжний өмнүүр зөрүүлнэ (аль гар нь дээр доор байх нь эрэгтэй, эмэгтэй ялгаагүй, өөртөө эвтэйхэн байдлаар нь хий,) (Зураг 4-8). Хөндий атгасан гараа тэнийлгэж мөрөн дээгүүрээ авчирна (зайтай байна), хоёр алгаа үргэлжлүүлэн гарын арга талаар (гадна тал) явуулж гарын бугуйнд хүрэхэд хоёр алга өөд өөдөөсөө харна, хоорондоо 3-4см зайтай байна. Энэ үед гадна гарын эрхий хуруу дээш харсан, дотор талын гарын эрхий хуруу доош харна, гар, шуу нэг шулуунд байна (Зураг 4-9). Дараа нь хоёр алганы



(Зураг 4-7)



(Зураг 4-8)



(Зураг 4-9)

хооронд бөмбөг байгаа мэт гараа эргүүлнэ, гадна талын гар дотор талд, дотор талын гар гадна талд орж байраа солино. Хоёр алга дээд доод гарын билиг (дотор) талын дагуу



(Зыпар 4-10)



(Зыпар 4-11)



(Зыпар 4-12)



(Зыпар 4-13)



(Зыпар 4-14)

түлхэж дээш өргөн толгойн ар талруу давуулна (Зураг 4-10). Хоёр гар толгойн ард хүрэхэд "х" хэлбэртэй байна (Зураг 4-11), үргэлжлүүлэн нурууны дагуу доош явуулж хоёр гараа салгахад хурууны үзүүр доошоо харна, нурууны энергитэй холбогдоно. Дараа нь хоёр гараа зэрэгцээгээр толгойн дээгүүр урагш давуулж цээжний өмнө авчирна (Зураг 4-12). Энэ бол тэнгэрийн нэг эргүүлэг юм. Хөдөлгөөнийг есөн удаа давтана. Дасгал дууссаны дараа хоёр гараа цээжнээс хэвлийн доош буулгана. Хэвлийн өмнө хоёр алгаа давхарлан барина (Диэкоу Шиаофу) (Зураг 4-13). Тэгээд хоёр гараа Жэинь байдалд авна (Зураг 4-14).

5. Ер бусын чадварыг эрчимжүүлэх

(Шэньтон Жиачи Фа)

Дасгалын зарчим: Ер бусын чадварыг эрчимжүүлэх дасгал нь Фалунь Гон-ы гүн амгаланд бясалгах дасгал юм. Энэ нь Буддын мутар ба гарын барилаар Фалунийг эргүүлж, ер бусын чадварт хүч өгөх, (увьдас чадвар багтана) гон хүчийг эрчимжүүлэх олон талын зорилготой дасгал юм. Энэ нь дундаас дээш түвшний дасгал, урьд нууц дасгалд харьяалагддаг байсан. Суурь түвшинд хүрсэн хүмүүсийн хүслийг хангах, ялангуяа тэдгээр урьдаас хувь төөрөгтэй хүмүүсийг аврахын тулд би зориуд энэ бясалгал дасгалыг нийтэд дэлгэрүүлсэн. Дасгалыг хоёр хөлөө давхар завилж (бүтэн лянхуа суудал) суун хийх шаардлагатай. Давхар завилж сууж хийх нь илүү сайн, гэхдээ дан завилж (хагас лянхуа суудал) сууж хийж болно. Дасгал хийхэд *чий* энергийн урсгал хүчтэй байдаг, мөн биеийн гаднах энергийн орон нэлээд том. Багшийн суулгаж өгсөн энергийн механизмын дагуу гар хөдөлнө, дасгалын үед сэтгэл санаагаа хоосон байлга, хоёр алган дээрээ л анхаарлаа жоохон төвлөрүүл. Алганы хонхорт халуун оргино, гар

хүнд, цэнэгтэй, бадайрсан, хүнд юм барьж байгаа мэт гэх мэтийн мэдрэмж төрдөг. Гэхдээ ингэж мэдрэх гэж битгий хөөцөлд, жамаар нь бол. Хөлөө удаанаар завилж суух тусам сайн, өөрийнхөө тэвчээрээр бол. Удаан суух тусам дасгал улам хүчтэй болно, гон улам хурдан өснө. Дасгал хийхдээ юу ч битгий бод, бодлын оролцоо байхгүй, хөдөлгөөнгүй нам байдалд орно. Аажмаар тайван хөдөлгөөнт байдлаас хөдөлгөөнгүй амгалан байдалд шилжинэ. Гэхдээ эзэн бодол өөрөө дасгал хийж байгаагаа мэдэж байх ёстой.

Уншлага:
Юуи Вуи⁵³
Инсүи Жичи⁵⁴
Сикон Фэйкон⁵⁵
Донжин Руи⁵⁶

Бэлтгэх байдал: Лянхуа завилалтаар сууна. Бүх биеэ сул тавь, гэхдээ хэт сул тавихгүй. Нуруу, хүзүү тэгшхэн, эрүүгээ бага зэрэг тат, хэлний үзүүрээ тагнайнд хүргэнэ, дээд доод шүдний хооронд бага зэрэг зайтай, уруулаа жимийнэ, хоёр нүдээ зөөлөн анина. Сэтгэлдээ энэрэнгүй, нүүрэндээ амгалан байдалтай сууна. Хоёр гараа хэвлийн өмнө Жэинь барилд авна, аажмаар гүн амгаланд орно. (Зураг 5-1)

Эхний мутар барил: Гарын хөдөлгөөн Багшийн суулгаж өгсөн энергийн механизм дагуу зугуухан аажим, дугуйрсан байх хэрэгтэй. Хоёр гараа Жэинь барилаас аажмаар дээш өргөн нүүрний өмнө авчирч хоёр гараа салган алгаа аажмаар дээш эргүүлнэ. Хоёр алга дээшээ харахад гар дээд цэгтээ хүрсэн байна (Зураг 5-2). Дараа нь хоёр гараа

⁵³ Юуи Вуи- Бодол орно, гарна

⁵⁴ Инсүи Жичи- Мутар энергийн механизмын дагуу хөдөлнө

⁵⁵Сикон Фэйкон- Хоосон гэхдээ арай хоосон биш

⁵⁶ Донжин Руи- Нэг яваад нэг зогсоно, бүгд чөлөөтэй

хооронд нь салгаад толгой дээрээс хагас дугуй замаар нүүрний урд тал руу буулгана, (Зураг 5-3). Тохойгоо биелүүгээ шах, алгаа дээш харуулна, хурууны үзүүр урагш чиглэнэ (Зураг 5-4). Дараа нь хоёр бугуйгаа тэгшилж цээжний өмнө зөрүүлнэ, эрэгтэй хүн зүүн гараа гадна талаар, эмэгтэй хүн баруун гараа гадна талаар явуулна. Хоёр гар, шуу нэг эгнээнд ороход (Зураг 5-5) гадна талд байгаа бугуйгаа алга дээш харсан байдлаар гадагш хагас дугуйгаар эргүүлнэ, алга дээш, хурууны үзүүрүүд арагшаа харна (гараа бага зэрэг хүчтэй хөдөлгөнө). Үүнтэй зэрэг нөгөө гарын бугуйгаа аажмаар доош эргүүлэн буулгаж гараа бүрэн тэнийлгэнэ, гар тэгшрэхэд алгаа эргүүлээд дээш харуулна, доод гар биенээс 30° налуутай байна (Зураг 5-6).



(Зураг 5-1)



(Зыпар 5-2)



(Зыпар 5-3)



(Зыпар 5-4)



(Зыпар 5-5)



(Зураг 5-6)



(Зураг 5-7)

Хоёр дахь мутар барил: Дараа нь мөрөн дээр байгаа гараа дотор талаар доош явуулна, доод гар алгаа бие рүү харуулан нэгэн зэрэг дээш явна. Хөдөлгөөн нь өмнөх барилтай адил, зүүн гар баруун гарын байрлал солигдоно, хоёр гараа зөвхөн эсрэг байдлаар хийнэ (Зураг 5-7).

Гурав дахь мутар барил: Эрэгтэй нь баруун бугуйгаа (эмэгтэй нь зүүн бугуйгаа) тэгшлэн алгаа бие рүүгээ харуулна. Цээжний өмнө хоёр гар зөрөхөд баруун гараа бугуйгаар эргүүлэн алгаа доош харуулан гараа тэнийлгэж шилбэн дээр авчирна. Мөн үүнтэй зэрэг эрэгтэй нь зүүн гарын (эмэгтэй нь баруун гарын) алгаа бие рүүгээ харуулан эргүүлж өргөн цээжний өмнө зөрсний дараа зүүн мөрний урд (эмэгтэй нь баруун мөрний урд) авчирна. Бугуйгаа эргүүлэхэд алга дээш харсан, хурууны үзүүр урагшаа чиглэсэн байна (Зураг 5—8).



(Зураг 5-8)



(Зураг 5-9)

Дөрөв дэх мутар барил: Энэ нь өмнөх хөдөлгөөнтэй адил гэхдээ гараа эсрэг байдлаар хийнэ, өөрөөр хэлбэл эрэгтэй нь зүүн (эмэгтэй нь баруун) гараа дотор талаар явуулна, баруун гараа (эмэгтэй нь зүүн гараа) гадна талаар явуулна, хоёр гарын байрлал яг эсрэгээр солигдоно (Зураг 5-9). Мутрын аль ч дөрвөн барил хийхэд хөдөлгөөн үргэлжилсэн зогсолтгүй жигд байна.

Бөмбөлөг хэлбэрээр ер бусын чадварыг эрчимжүүлэх
Дөрөв дэх мутар барилаас үргэлжлүүлнэ. Дээрх гараа дотор талаар явуулна, доодох гараа гадна талаар явуулна. Эрэгтэй нь баруун гарын алгаа (эмэгтэй нь зүүн гарын алга) аажмаар цээжрүү харуулан эргүүлээд доош явуулна, зүүн гараа (эмэгтэй нь баруун гараа) дээш өргөнө. Хоёр гарын шуу цээжний өмнө хүрэхэд хэвтээ нэг шулуунд болно (Зураг 5-10). Хоёр гараа хоёр талруугаа тэнийлгэн алгаа доош харуулна (Зураг 5—11). Хоёр гар тэнийж өвдөгнөөс өнгөрөхөд гараа бэлхүүсний харалдаа өндөрт газартай зэрэгцээ барина, гарын шуу ба бугуй тэгшхэн нэг түвшинд, хоёр гараа сул байлгана. (Зураг 5-12). Энэ барил нь биен доторхи увьдас чадлыг гадагш гар луу шилжүүлж бөмбөлөг

хэлбэрээр ер бусын чадварыг эрчимжүүлнэ. Энэ үед алга халуун, хүнд, бадайрсан, цэнэгтэй, ямар нэг хүнд юм барьж байгаа гэх мэт мэдрэмж төрдөг. Гэхдээ үүнийг мэдрэх гэж битгий хөөцөлд, зүгээр аясаар нь бол. Энэ байдлаар удаан суух тусам сайн, чилж тэвчиж чадахгүй болтлоо барь.



(Зураг 5-10)



(Зураг 5-11)



(Зураг 5-12)

Босоо хэлбэрээр ер бусын чадвар эрчимжүүлэх

Өмнөх байрлалаас эргэгтэй нь баруун гараа (эмэгтэй нь зүүн гараа) тохойгоор эргүүлж алгаа дотогш харуулан нугалж хэвлий рүү буулгана. Энэ гарын хөдөлгөөнтэй зэрэг нөгөө гараа өргөж эрүүний дор авчирна, алга доош харсан, гарын шуу мөрний хэмжээтэй өндөрт байна. Энэ үед хоёр алга өөд өөдөөсөө харсан байна, ийм байдалд аль болох удаанаар сууна. (Зураг 5-13). Энэ нь босоо хэлбэрээр ер бусын чадварыг эрчимжүүлдэг, жишээ нь: алган тэнгэрийн нүргээн гэх мэт. Энэ байдлаар цааш удаан барьж чадахгүй болтлоо суу. Дараа нь дээдэх гараа урд талаар дугуйруулан буулгаж хэвлийн өмнө авчирна, мөн нэг зэрэг доод гараа дээш өргөн эрүүний дор авчирна, алга доош харна. (Зураг 5—14) Гар мөрний хэмжээтэй өндөрт байна, хоёр алга өөд өөдөөсөө харна. Энэ нь бас ер бусын чадварыг эрчимжүүлнэ, зөвхөн гарын барил эсрэгээр. Энэ байдалд аль болох удаанаар суу, удаан суух тусам сайн.



(Зураг 5-13)



(Зураг 5-14)

Гүн амгаланд бясалгах - Өмнөх байдлаас эхэлнэ. Дээд гараа урагш хагас тойргоор эргүүлж хэвлий рүү буулгана,

хоёр гараа Жэинь барилд авна (зураг 5-15), хөдөлгөөнгүй гүн амгаланд орж бясалгана. Удаан суух тусам сайн.



(Зураг 5-15)



(Зураг 5-16)

Төгсөх байдал: Хоёр гараа цээжний өмнө авчирч залбирна (Зураг 5-16), гүн амгалангаас гарч лянхуа завилалтаа буулгана.

Фалунь Гон бясалгалд тавигдах үндсэн шаардлага ба анхаарах зүйлс

1. Фалунь Гоны таван дасгалыг дараалуулан эсвэл сонгон хийж болно. Гэхдээ гол төлөв нэгдүгээр дасгалыг эхэлж хийхийг шаарддаг, мөн үүнийг гурван удаа хийх нь маш сайн. Мэдээж бусад дасгалуудыг ч нэгдүгээр дасгалгүйгээр хийж болно, тус бүрийг дангаар нь хийж бас болно.

2. Хөдөлгөөн бүрийг зөв бас хэмнэлтэй хийх хэрэгтэй. Гар шуу дээш доош, хойш урагш, зүүн баруун тийш энергийн

механизмын дагуу яаралгүй, аажим, жигдхэн хөдлөх ёстой. Хэт хурдан юмуу хэт удаан хөдөлж болохгүй.

3. Фалунь Гон эзэн бодлыг бясалгадаг учраас дасгал хийж байхдаа өөрийгээ эзэн бодлын удирдлаган дор барих ёстой. Санаатайгаар битгий ганх, бие чинь ганхвал зогсоо, шаардлагатай бол нүдээ харж болно.

4. Бүх биеэ сулла, ялангуяа өвдөг ташаагаараа. Хэт биеэ барьж зогсвол судлууд хаалттай үлдэнэ.

5. Дасгал хийж байхад хөдөлгөөн тайван аясаараа, сул чангалаагүй, чөлөөтэй саадгүй байх ёстой. Хөдөлгөөн хатуу мөртлөө зөөлөн, бага зэрэг хүчтэй ч хатуу хөшүүн биш байх хэрэгтэй. Хэрэв ийм байвал үр дүн илүү мэдэгдэхүйц гарна.

6. Чи дасгал хийж дуусах болгондоо хөдөлгөөнийг зогсоодог, гэхдээ бясалгалын механизмыг биш. Дасгалын эцэст зөвхөн Жэинь барил хийдэг, гараа нийлүүлснээр дуусгадаг нь хөдөлгөөн дууслаа гэсэн үг. Бясалгалын механизмыг хүчээр битгий зогсоо, тэглээ ч гэсэн Фалуний эргэлт зогсохгүй.

7. Сул биетэй болон архаг өвчтэй хүн өөрийнхээ биеийн байдлын дагуу хий, дасгалаа багаар эсвэл таван дасгалын аль нэгийг хийж болно. Хөдөлж чадахгүй хүн бол зүгээр лянхуа суудлаар сууж болно. Чи ямар ч байдалтай байсан дасгалаа үргэлжлүүлэн хийх хэрэгтэй.

8. Дасгал хийхэд байрлал, цаг, зүг чигт тавих онцгой шаардлага гэж байхгүй. Гэхдээ цэвэр, нам гүм орчин байвал сайн.

9. Эдгээр дасгалуудыг хийхэд ямар ч бодлын оролцоо байхгүй, тийм учраас чи хэзээ ч буруу хазайхгүй. Фалунь Гон-ыг бусад аль ч бясалгалын аргатай битгий холь. Тэгвэл Фалунь гажина.

10. Дасгалын үед үнэхээр тайван байж чадахгүй бол багшийнхаа нэрийг унш. Цаг хугацаа өнгөрөхөд аажимдаа чи тайван байдалд орж чаддаг болно.

11. Дасгал хийхэд зарим бэрхшээл гарч магад, энэ бол нүглээ хариулж байгаа нэг хэлбэр, хүн бүр нүгэлтэй. Чиний биед таагүй байдал мэдрэгдэхэд үүнийг өвчин гэж битгий бод, чиний нүгэл ингэж арилж байж болно, чамд тавьсан бясалгалын замд зарим зовлон бэрхшээл эрт, орой нэгэн цагт гарч болно.

12. Чи давхар завилж сууж бясалгаж чадахгүй бол эхэндээ сандлын ирмэг дээр суу, адилхан үр дүн гарна. Гэхдээ бясалгагч хүн лянхуа завилалт хийж чаддаг байх ёстой, яваандаа чи хийж чаддаг болно.

13. Чамайг дасгал хийж байхад чинь ямар нэгэн дүрс зураг харагдвал битгий анхаар зүгээр дасгалаа л хий, аймшигтай юм харагдаж үймүүлбэл эсвэл аюултай санагдвал нэн даруй "Би Фалунь Гон-ы багшийн хамгаалалтанд, Би юунаас ч айхгүй" гэж бод, мөн Ли багшийн нэрийг дуудаж дасгалаа үргэлжлүүлэн хий.

Тавдугаар бүлэг

Асуулт ба Хариулт

1. Фалунь ба Фалунь Гон

Сурагч: Фалунь ямар бүтэцтэй вэ?

Багш: Фалунь бол дээд энергийн материас тогтсон оюун ухаант амь бодь, автоматаар гон-ыг хувиргаж байдаг, манай орон зайд оршдоггүй.

Сурагч: Фалунь ямар харагддаг вэ?

Багш: Фалуний өнгөний хувьд чи алтан шаргал гэж хэлнэ, гэхдээ тэр өнгө манай орон зайд байдаггүй. Дотоод дугуйн суурь өнгө тод улаан, гаднах дугуйн суурь өнгө улбар шар. Дао системийн улаан хар хоёр Тайжи тэмдэг, мөн үндсэн аугаа Дао системийн улаан цэнхэр хоёр Тайжи тэмдэг байдаг, эдгээр нь хоёр өөр төрлийнх юм. Хас тэмдэг “卍” алтан шар өнгөтэй. Доод түвшинд Тэнгэрийн мэлмий нээгдсэн хүн Фалунийг сэнс шиг эргэж байгааг хардаг. Чи үүнийг тод харж чадвал их гоё, бясалгагч хүнд энэ нь улам хичээнгүй тууштай бясалгах урам зориг өгнө.

Сурагч: Фалунь анхандаа хаана оршдог вэ? Дараа нь хаана орших вэ?

Багш: Би зөвхөн нэг Фалунь өгдөг. Энэ нь хэвлийн доод хэсэгт оршдог, бидний ярьсан үрлийг бясалгадаг хадгалдаг тэр газарт оршдог, тэр байршил өөрчлөгддөггүй. Зарим хүн олон Фалунь эргэж байгааг хардаг, тэдгээр нь миний номын бие чиний биеийг засахад хэрэглэдэг Фалунь.

Сурагч: Фалунийг дасгал, бясалгалаар гаргаж авч болох уу? Хичнээнийг гаргаж болох вэ? Тэдгээр нь Багшийн өгснөөс ямар ялгаатай вэ?

Багш: Фалунийг дасгал, бясалгалаар гаргаж болно. Чиний гон хүч нэмэгдэх тусам улам олон Фалунь гарна. Бүх

Фалунь адилхан, гэхдээ хэвлийн доод хэсэгт оршдог Фалунь эргэн тойронд явдаггүй, тэр бол үндсэн Фалунь.

Сурагч: Фалунь оршиж байгааг болон эргэж байгааг яаж ажиглаж мэдэрч болох вэ?

Багш: Үүнийг ажиглах мэдрэх гэсний хэрэг байхгүй. Зарим хүн мэдрэмтгий, Фалунь эргэж байгааг мэдэрдэг. Фалунийг суулгасны дараа эхэндээ бие чинь дасахгүй байж болно, гэдэс хөндүүрлэх, ямар нэгэн зүйл хөдөлж байгаа мэдрэмж, халуу оргих, гэх мэт болдог. Үүнд дассаны дараа чамд тийм мэдрэмж байхгүй болно, гэхдээ ер бусын чадвартай хүнд харагдана. Энэ нь чи ходоодныхоо хөдөлж байгааг мэдэрдэггүйтэй адил.

Сурагч: Фалуний зурган дээрхи Фалунь эргэх чиглэл нь сурагчдын үнэмлэх дээр байгаа Фалунь-тай адилгүй, (Бээжинд болсон нэг, хоёрдугаар семинарын үнэмлэх) Сурагчдын үнэмлэх дээрх Фалунь цагийн зүүний эсрэг эргэж байсан. Яагаад вэ?

Багш: Зорилго нь чамд сайн зүйл өгөхийн тулд, эсрэгээр эргэхэд гарах энерги хүн болгоны биеийг засдаг, тийм учраас цагийн зүүний дагуу эргэдэггүй, чи эргэж байгааг нь харж болно.

Сурагч: Багш хэдийд сурагчдад Фалунь суулгаж өгдөг вэ?

Багш: Энэ талаар ярьцгаая. Бидний зарим сурагчид олон дасгалаар хичээллэсэн, хэцүү зүйл нь гэвэл бид биен дэх замбараагүй болсон бүх зүйлсийг арилгах хэрэгтэй болдог, сайн зүйлийг үлдээж мууг хаях хэрэгтэй. Ингэж шат ахидаг, үүний дараа Фалунийг суулгаж болно. Суулгаж өгсөн Фалуний хэмжээ бясалгаж байгаа хүний түвшнөөс хамаардаг. Зарим хэзээ ч чигон-оор хичээллэж байгаагүй, харин суурь сайтай хүн, миний энэ хичээлийн явцад засал хийлгэж өвчин нь арилсны дараа чий түвшнөөс гарч сүүн цагаан биений байдалд орно, тэгээд Фалунь суулгаж өгч болно. Гэхдээ олон хүний биеийн байдал нь их муу, тэд

байнга засал хийлгүүлж байдаг, тэгэхээр засал дуусахаас өмнө яаж Фалунийг суулгах юм? Зөвхөн цөөн хэсэг хүмүүст л Фалунь суулгаж өгөх боломжгүй. Гэхдээ санаа зовох хэрэггүй, би аль хэдийн Фалунь үүсгэх энергийн механизмыг суулгасан.

Сурагч: Фалунийг яаж авч явдаг вэ?

Багш: Үүнийг авч явдаггүй, Би Фалунийг чиний хэвлийд суулгаж өгдөг, манай энэ материаллаг орон зайд биш, өөр орон зайд. Хэрэв энэ орон зайд чиний хэвлийд эргэж эхэлбэл гэдэс чинь юу болох вэ? Энэ нь өөр материаллаг орон зайд байдаг, энэ биенд ямар ч зөрчил гарахгүй.

Сурагч: Та дараачийн ангид Фалунийг үргэлжлүүлэн өгөх үү?

Багш: Чи зөвхөн нэгийг л авна, зарим хүн олон Фалунь эргэж байгааг мэдэрдэг, тэдгээр нь бол зөвхөн биед засал хийх гадны үйл ажиллагаанд үйлчилдэг. Манай дасгалын хамгийн том онцлог нь гэвэл энерги гаргахад Фалуний цуваа гардаг, чамайг дасгал хийгээгүй байхад ч олон Фалунь эргэж чиний биед засал хийж байдаг. Миний өгсөн Фалунь бол чиний хэвлийн доод хэсэгт оршдог тэр нэг л юм.

Сурагч: Хэрэв бясалгахаа боливол Фалунь алга болох уу? Фалунь миний биенд хэр удаан байх вэ?

Багш: Чи өөрийгээ бясалгагч хүн гэж үзэж миний тавьсан зан чанарын шаардлагын дагуу явбал, чамайг дасгалаа хийгээгүй байхад алга болохгүй төдийгүй эрчимжиж байдаг, чиний гон хүч үргэлжлэн өсч байдаг. Чи дасгалаа хэнээс ч сайн хийсэн миний зан чанарт тавьсан шалгуурыг дагахгүй бол чиний оролдлого үр дүнгүй болно, чи дасгал хийгээд ч нөлөө байхгүй. Чи ямар ч бясалгал хийсэн түүний шаардлагыг дагахгүй бол буруу замаар бясалгах магадлалтай. Хэрэв чиний толгойд дандаа муу бодол байвал, "Тэр яагаад тийм зэвүүн байна аа? Би ер бусын

чадвартай болоод түүнийг чадна даа" гэж бодно, тийм байвал чи Фалунь Гон сурч байсан ч дасгал хийхдээ ийм зүйл дотроо нэмээд миний тавьсан зан чанарын шаардлагыг дагахгүй бол чи буруу номоор бясалгасантай адил биш үү?

Сурагч: Багшаа та үргэлж ингэж хэлдэг: Фалунийг 100 сая доллараар ч худалдан авч чадахгүй. Үүний учир нь юу вэ?

Багш: Энэ нь үнэхээр маш нандин. Миний чамд өгсөн нь зөвхөн Фалунь биш, чиний бясалгалыг баттай болгох бусад зүйлс бас бий, тэдгээр нь бүгд нандин. Энэ бүгд бол мөнгөөр хэмжишгүй.

Сурагч: Сүүлд ирсэн хүн Фалунь авах уу?

Багш: Лекцийн сүүлчийн гурван өдрөөс өмнө ирсэн хүний биед засал хийж болно, түүнчлэн бусад олон зүйлийн хамт Фалунийг суулгаж өгнө. Хэрэв чи сүүлчийн гурван өдөрт ирсэн бол хэлэхэд хэцүү, тэгсэн ч чиний биед засал хийгдэнэ. Тэдгээр зүйлийг суулгаж өгөхөд амаргүй, чиний нөхцөл байдал гайгүй бол магадгүй тэдгээр зүйлсийг суулгаж өгч болно.

Сурагч: Фалунаар хүний биеийн буруу байдлыг засах нь нэг төрлийн арга уу?

Багш: Бид зөвхөн Фалунаар засч байгаа биш, Багш бас өөр олон арга хэрэглэж засдаг.

Сурагч: Түүхийн өмнө Фалунь Гон-ыг бүтээсэн үндэслэл нь юу байсан бэ?

Багш: Чи асар том асуулт тавьж байна, хэтэрхий их дээгүүр байна. Энэ бол бидний энэ түвшинд мэдвэл зохих хүрээнээс хэтэрсэн асуулт, тийм учраас би энд ярьж болохгүй. Гэхдээ нэг зүйлийг та бүгд мэдэх ёстой: Энэ бол Буддын шашны чигон биш, харин Буддын системийн чигон, Буддын шашин ч биш. Бид Буддын шашинтай ижил зорилготой ч гэсэн бидний бясалгалын зарчим өөр, хоёр өөр замаар явдаг. Бидний зорилго бол ижил.

Сурагч : Фалунь Гон хэр эртний түүхтэй вэ?

Багш: Миний бясалгаж байсан ном миний нийтэд тараасан цогц аргатай бүхэлдээ ижил биш. Миний бясалгасан Фалунь бол миний тарааж байгаа Фалунаас илүү хүчирхэг, мөн гон өсөх нь ч одоогийн цогц аргаас хурдан. Гэсэн ч миний нийтэд тараасан бясалгалын аргад гон бас хурдан өсдөг, тиймээс бясалгагчийн зан чанарт тавих шаардлага ердийнхээс илүү хатуу ба өндөр. Миний нийтэд тараасан зүйлс нь дахин цэгцлэгдсэн, арай зөөлөн шаардлагатай, тэгсэн ч ердийн бясалгалуудаас илүү хатуу шаардлагатай, урьдын зүйлтэй адилгүй. Иймээс би үүсгэгч нь юм. Фалунь Гон-ы түүхийг хэр урт вэ гэж асуувал, нийтэд тараахаас өмнөх үеийг оролцуулахгүйгээр би өнгөрсөн жил (1992 оны) таван сард Хятадын зүүн хойд хэсэгт зааж эхэлсэн. Чи нодлингийн таван сард эхэлсэн гэж хэлж болно.

Сурагч: Таны лекцийг сонсоход Багш бидэнд юу өгдөг вэ?

Багш: Би та бүгдэд Фалунь өгдөг. Бясалгалын Фалунь, биед засал хийх Фалунь гэж байдаг, үүний зэрэгцээ миний Номын бие чамайг хариуцна, Фалунь Гон-оор бясалгаж байвал хүн болгонд байна. Чи бясалгахгүй бол мэдээж Номын бие хариуцахгүй, чам дээр оч гэсэн ч тэр очихгүй. Чиний юу бодож байгааг миний номын бие тов тодорхой мэднэ.

Сурагч: Фалунь Гон-оор бясалгахад миний биеийг гэгээрлийн хутагт хүргэж өгч чадах уу?

Багш: Дафа бол хязгааргүй, чи бясалгаад Рулай түвшинд хүрсэн ч бас л дээд хязгаар биш. Биднийх бол ариун бясалгалын зам, чи бясалга! Чиний хүрэх бүгд гэгээрлийн хутагт.

2. Дасгалын зарчим ба Арга

Сурагч: Зарим хүн Их тэнгэрийн эргүүлэг дасгал хийсний дараа гэртээ хариад тэнгэрт нисч байна гэж их тодхон зүүдэлдэг, энэ ямар учиртай вэ?

Багш: Би та бүхэнд хэлье, иймэрхүү зүйл чиний бясалгаж байхад эсвэл зүүдэнд гарвал үнэндээ энэ бол зүүд биш. Энэ бол чиний сүнс бодит биенээсээ гарч явсных, зүүд шиг зүйл биш. Чи зүүдэндээ юмыг тийм тодорхой нарийн харж чадахгүй, харин чиний сүнс биенээсээ гарахад тэр харсан зүйлс, тэр ч байтугай яаж нисч байгаа нь санаанд их тодорхой үлддэг.

Сурагч: Хэрэв Фалунь гажвал ямар муу үр дагавартай вэ?

Багш: Энэ нь тэр хүн буруу хазайсныг харуулж байна, мөн Фалунь үр нөлөөгөө алдана, мөн чиний бясалгалд их бэрхшээл учирна. Гол замаар явахгүй салаа замаар орж төөрөөд замаа олохгүй болсонтой адил, чи бэрхшээлтэй тулгарна, ийм зүйл энгийн хүний амьдралд тохиолдоно.

Сурагч: Ганцаар бясалгахдаа гэртээ ямар орчинг бүрдүүлэх хэрэгтэй вэ? Манай гэрт Фалунь байгаа юу?

Багш: Энд сууж байгаа олон хүн Фалунь гэртээ байхыг харсан, гэр бүлийнхэн чинь ашиг тус хүртэж эхэлсэн. Бид нэг цагт, нэг газарт маш олон орон зай зэрэг оршдог гэж хэлсэн, чиний гэрийг ч бас гадна үлдээхгүй, зохицуулж өгнө. Зохицуулах арга нь бол муу зүйлийг арилгана, хамгаалах бүрхүүл байрлуулна, тэгэхэд ямар ч муу зүйлс орж ирж чадахгүй.

Сурагч: Дасгал хийж байхад чий өвчтэй газарт хүрэхэд өвдөж хавддаг, яагаад тэгдэг вэ?

Багш: Өвчин бол нэг янзын хар энергийн бөөгнөрөл, хичээлийн эхний үед бид үүнийг хэсэгчлэн хуваахад тэр газар хавдана, үндэс нь тасрахад гадагш ялгарч эхэлнэ.

Хурдан гадагшилж дуусахад өвчин бүр мөсөн байхгүй болно.

Сурагч: Хэдэн хичээлд суусны дараа миний хууч өвчнүүд алга болсон, харин хэдэн өдрийн дараа гэнэт дахиад хөдөлсөн. Яагаад вэ?

Багш: Манай бясалгалын түвшин их хурдан дээшилдэг, чамайг мэдрээгүй байхад чиний бясалгалын нэг түвшин маш богино хугацаанд өнгөрдөг, үнэндээ өвчин чинь аль хэдийн эдгэрсэн. Дараагийн шинж тэмдгүүд нь миний хэлснээр гай зовлонгоос гардаг. Мэдэрч анхааралтай ажигла, чамд урд байсан өвчний шинж тэмдэгтэй адилгүй. Чи өөр чигон багшаар биеэ засуулах гэвэл тэд чадахгүй, энэ бол гон өсгөхөд нүглийн хариулалт байдаг.

Сурагч: Бясалгаж байхдаа эм уух хэрэг байна уу?

Багш: Чи энэ асуудлыг өөрөө ухамсарла. Бясалгаж байхдаа эм ууна гэдэг нь чи бясалгалын эдгээх чадварт итгэхгүй байна гэсэн үг, чи итгэж байвал эм ууж яах юм. Чи өөрийгээ манай зан чанарын шалгуураар барихгүй бол асуудал гарахад чи Ли Хонжи эм уулгаагүй гэнэ, харин Ли Хонжи чамайг зан чанартаа хатуу шаардлагатай бай гэсэн, чи түүнийг биелүүлсэн үү? Жинхэнэ Дафа-гаар бясалгадаг хүний биед байдаг зүйлс энгийн хүнд байдаг зүйлс биш, энгийн хүнд тусдаг ямар ч өвчин эмгэг чиний биед байхыг зөвшөөрөхгүй. Хэрвээ чиний сэтгэл зөв байвал, бясалгалын эдгээх чадварт итгэж байвал эмээ үргэлжлүүлж уухгүй, энэ талаар бодохгүй, эмчлүүлэх гэж явахгүй бол хэн нэгэн чамайг эдгээж өгнө. Энд байгаа та бүхэн өдрөөс өдөрт сайжирч байгаа, өдрөөс өдөрт таатай болж байгаа. Энэ нь ямар учиртай вэ? Миний Номын биес та нарын олонхийн биед орж гарч завгүй байдаг, тэд эдгээр зүйлийг чамд хийж өгч байгаа юм. Хэрэв чиний сэтгэл бясалгалдаа баттай биш, наанаа бясалгалаа хийсэн ч цаанаа эргэлзсэн, туршаад үзэх гэсэн сэтгэлтэй бол чи юу ч олж авч чадахгүй. Буддад итгэх үгүй нь чиний ухамсар, сууриас шалтгаална. Хэрэв Будда

хүний нүдэнд ил гарч энд тодхон харагдвал хүн болгон бясалгана, чиний бодлыг өөрчлөх асуудал байхгүй болно. Чи эхлээд итгэ, дараа нь харж чадна.

Сурагч: Зарим хүн Багшийг болон шавийг нь урьж эмчилгээ хийлгэхийг хүсдэг. Тэгж болох уу?

Багш: Би нийтэд эмчилгээ хийх гэж ирээгүй. Зарим хүн өвдөх ёстой, миний хэлснийг зарим хүн ойлгодоггүй, би цааш нь нарийн тайлбарлахгүй. Буддын бясалгалд өргөн хэмжээнд амь аврахыг зорьдог, хүн эдгээхийг зөвшөөрдөг. Гэхдээ бид хүн эмчилбэл зохион байгуулалттай, сурталчлах хэлбэрээр хийдэг. Би нийтэд гарч ирээд удаагүй, ихэнх хүн намайг мэдэхгүй, намайг хүлээн зөвшөөрөхгүй, ном тараахад магадгүй ирж сонсох хүн цөөхөн. Бид хүмүүст эрүүл мэндийн зөвлөлгөө өгч хүмүүсийг эмчилснээр Фалунь Гон-ыг таниулж байгаа, үр дүн ч их сайн байна. Тиймээс бид зөвхөн хүн эмчлэхийн тулд хийгээгүй. Хүчирхэг гон хэрэглэж өвчнийг эмчлэхийг зөвшөөрөхгүй. Гурамсан Ертөнцөөс гарсан Номын зарчмаар Гурамсан Ертөнцийн Номын зарчмыг орлуулахыг зөвшөөрөхгүй, ингэж болохгүй, өвчнийг эдгээх нөлөө ч сайнгүй болно. Бясалгал, сурагчиддаа хариуцлагатай хандах үүднээс бид чиний биеийг өвчингүй болгож засах хэрэгтэй, зөвхөн тэгсэн үед л чи дээд түвшин лүү бясалгаж чадна. Чи үргэлж өвчнөө боддог, үндсэндээ бясалгах сонирхолгүй байвал чи хэлээгүй байсан ч миний Номын бие чиний юу бодож байгааг тодорхой мэднэ, эцэст нь чи юу ч олж авч чадахгүй. Энэ ангид бид та бүгдийн биеийг аль хэдийн засч өгсөн, мэдээж чи эхлээд бясалгадаг хүн байх ёстой. Би лекцийн дундаас та нарын өвчнийг эмчилж мөнгө хураах гэх мэтийн зүйл хийхгүй. Хэрэв чиний өвчин сайжраагүй гэвэл тэр бол ухамсрын асуудал. Мэдээж зарим хүн хүнд өвчтөй, магадгүй биен дээр нь илт өөрчлөлт харагдахгүй, гэхдээ үнэн хэрэгтээ их том өөрчлөлт гарсан. Нэг удаагийн засал хангалтгүй байж магад, гэхдээ бид боломжоороо хийсэн. Энэ нь бид чамд хариуцлагатай хандахгүй байгаа

хэрэг биш, харин өвчин хэтэрхий хүндэрснийх. Чи хариад бясалгахад бид үргэлжлүүлэн чамайг эмчилнэ, бүрэн эдгэртэл хийнэ. Гэхдээ ийм тохиолдол цөөхөн.

Сурагч: Дасгал хийхдээ яаж амгаланд орох вэ? Дасгал хийж байхдаа ажлынхаа хэцүү асуудлын талаар бодвол энэ нь зууралдсан сэтгэл үү?

Багш: Ашиг хувийн сонирхлыг хөнгөн авч үз, цэвэр ариун сэтгэлтэй бай. Хэрэв чи хүнд сорилт ирэхийг, хэзээ болохыг эртнээс мэдчихээд бэлтгэлтэй байвал тэр нь сорилт болж чадахгүй. Хэцүү сорилт ихэнхдээ гэнэт ирдэг. Чи итгэлтэй бат зогсож чадвал давж чадах нь гарцаагүй, тэгж байвал чиний зан чанар хэр өндөр байгаа нь харагдана. Чиний зууралдсан сэтгэл арилахад зан чанар дээшилнэ, чи бусадтай өрсөлдөж тэмцэлдэхээ болино, чиний атаа жөтөө, үзэн ядалт мартагдана, сэтгэл чинь цэвэршинэ, тэр үед амгаланд орох чадварыг ярьж болно. Хэрэв амгаланд орж чадахгүй бол өөрийгээ хоёр дахь хүн гэж сэтгэ, тэр бодлоо өөр хүнийх гэж бод. Тийм бодол нь ар араасаа оволзож байж мэднэ, чи битгий анхаар, тоохгүй орхичих. Зарим хүн Буддын нэрийг давтан унших эсвэл тоо тоолохыг зөвлөдөг, энэ бүгд бясалгалын янз бүрийн арга. Бид дасгал хийхдээ бодлоо төвлөрүүлэхийг шаардахгүй, гэхдээ чи дасгал хийж байгаагаа мэдэж байх ёстой. Чиний ажил дээрх хэцүү асуудал чиний хувийн ашиг, зууралдсан сэтгэлтэй холбоогүй, энэ бол сайн зүйл. Миний мэдэх нэг лам хуврага үүнийг бясалгал талаас нь ойлгодог. Тэр хийдийн хамба, маш олон хийх ажилтай, гэхдээ бясалган суухдаа тэдгээр зүйлийг өөрөөсөө тусгаарладаг, тэр талаар бодохгүй, энэ бол чадвар. Чи дасгалаа жинхнээсээ сайн хийвэл чамд юу ч бодогдохгүй, амиа хичээсэн сэтгэл гэх мэт байхгүй. Чи ажилдаа хувийн зүйл холихгүй бол ажлаа сайн хийж чадна.

Сурагч: Дасгал хийж байхад муу бодол орж ирээд байвал яах вэ?

Багш: Дасгалаа хийж байхад үе үе муу зүйлс гарч ирж болно. Та бүгд дөнгөж бясалгаж эхэлсэн, шууд их өндөр түвшинд хүрчих боломжгүй, бид одоо чамд тийм өндөр шаардлага тавихгүй, чамайг бодолдоо нэг ч муу зүйл битгий оруул гэвэл энэ нь бодит биш, аажмаар хий. Эхэндээ бол яахав (муу бодол орж ирж байвал), гэхдээ өөрийгээ битгий сул тавь, яваандаа бодол чинь дээшилнэ, чи Дафа-гаар бясалгаж байгаа болохоор өөртөө дээд шаардлагатай хандах ёстой. Энэ лекцийг төгссөний дараа чи энгийн хүн биш болно, чиний биед байгаа зүйлс их онцгой, чи өөрийнхээ зан чанарт хатуу шаардлага тавих хэрэгтэй.

Сурагч: Дасгал хийж байхад миний толгой, хэвлий гэдэс эргээд байх шиг санагдах юм, мөн цээж хавьд эвгүйрхээд байна.

Багш: Энэ бол эхний үед Фалунь эргэхэд гардаг зүйл, тэр мэдрэмж дараа нь алга болно.

Сурагч: Дасгал хийхэд жижиг амьтад татагдаад байвал яах вэ?

Багш: Янз бүрийн чигон дасгал жижиг амьдтыг татаж болно, зүгээр битгий тоо, тэгээд л болоо. Эерэг энергийн орон оршиж байгаатай холбоотой, ялангуяа Буддын ситемийн чигон, энэ гон амь бодийг өргөнөөр аврахад туслах шинж чанар агуулдаг. Бидний Фалунь цагийн зүүний дагуу эргэхдээ өөрийгээ авардаг, цагийн зүүний эсрэг эргэхдээ бусдыг авардаг. Дараа нь буцаад нөгөө тийш эргэн давтагддаг, бидний эргэн тойронд байгаа бүх зүйлст ашиг тустай.

Сурагч: Хоёр туйлыг нэвтрэх дасгалын үед гар дээш доош нэг удаа явахад нэг гэж тоолох уу? Буддын мянган гарын суниалт дасгал хийж байхад гараа сунгахын өмнө өөрийгээ их том, өндөр гэж төсөөлөх үү?

Багш: Гар болгон дээш доош нэг удаа явахад нэг гэж тоолно, Буддын мянган гарын суниалт хийхдээ өөрийгээ

тэгж бодохгүй байсан ч аясаараа том өндөр гэж мэдэрнэ. Өөрийгээ тэнгэр газрын хооронд аварга том гэж бодон зогсож байхад болно. Дандаа тийм мэдрэмжтэй байх гэвэл зууралдсан сэтгэл болно.

Сурагч: Би бясалгах дасгал хийхдээ лянхуа завилалтаар сууж чадахгүй бол яахав?

Багш: Чи хөлөө завилж сууж бясалгах дасгал хийж чадахгүй бол сандлын ирмэг дээр сууж хийж болно, үр дүн нь яг адилхан. Гэхдээ чи бясалгагч болохоор хөлөө дасгалжуул, тэгээд завилж чаддаг бол. Чи сандлын ирмэг дээр суугаад хөлөө завилах сургуулилт хий, яваандаа завилж чаддаг болох хэрэгтэй.

Сурагч: Гэр бүлийн гишүүд муу зүйл хийгээд Үнэн, Нинжин, Гэвчээртэй байж чадахгүй бол яах вэ?

Багш: Гэр бүлийнхэн чинь Фалунь Гон-оор хичээлэлдэггүй бол яахав, чи гол нь өөрөө сайн бясалга, асуудлыг хүндрүүлэх хэрэггүй, хөнгөн авч үз, өөр дээрээ гол нь сайн ажилла.

Сурагч: Өдөр тутмын амьдралд заримдаа би буруу зүйл хийгээд харамсдаг, гэсэн ч дахиад давтдаг. Энэ нь миний зан чанар тааруугийнх уу?

Багш: Чи энэ талаар бичиж байгаа болохоор чиний зан чанар дээрдэж байна, өөрийнхээ дутагдлыг ойлгож байна гэсэн үг. Энгийн хүн буруу зүйл хийгээд дараа нь ухамсарладаггүй, тэгэхээр чи энгийн хүнээс давуу болсон. Чи эхний удаа буруу зүйл хийсэн, зан чанараа бариагүй, ийм нэг явц байдаг, гэхдээ дараагийн удаа асуудал гарахад сайн хийхийг хичээ.

Сурагч: Дөч, тавин насны хүмүүс "Гурван цэцэг толгой дээр цуглах" түвшинд хүрч чадах уу?

Багш: Бид амь бие, сэтгэлээ хос бясалгадаг болохоор нас хамаагүй. Чи бясалгалдаа төвлөрөн миний тавьсан зан

чанарын чиг шугамыг баримтлан бясалгаад байвал нас чинь уртсаад л байна. Энэ нь чамд бясалгах хангалттай хугацаа өгч байгаа биш үү? Гэхдээ амь бие, сэтгэлийн бясалгал дасгалд нэг зүйл бий, насыг чинь уртасгаж байхад зан чанарт чинь асуудал гарвал чиний амь насанд тэр даруй аюул учирна, чамайг бясалгуулахын тулд нас чинь уртассан. Тиймээс зан чанар чинь доголдвол амь насны аюул гарна.

Сурагч: "хатуу гэхдээ зөөлөн" гэдэг нь хэр хүчийг хэлж байгаа вэ?

Багш: Чи үүнийг өөрөө олж мэд, жишээ нь бид их гарын мутар хөдөлгөөн хийхэд зөөлөн харагддаг, гэхдээ хийхэд хүч ордог. Хоёр гарын шуу, бугуй, болон хуруунуудын хоорондох хүч нилээд их, гэхдээ зөөлөн харагддаг. Энэ бол "хатуу гэхдээ зөөлөн" гэдэг нь. Би мутрын барил хөдөлгөөн хийхдээ үүнийг чамд өгсөн, чи дасгал хийхдээ аажмаар мэдэрнэ.

Сурагч: Эр эмийн хооронд бэлгийн харьцаа байх хэрэггүй гэж үнэн үү? Залуучууд гэр бүлээсээ салах болох уу?

Багш: Бид бэлгийн харьцааны талаар урьд ярьсан, чиний одоогийн түвшинд чамайг лам, хандмаа бол гэж хэлээгүй, чи өөрөө хүссэн. Хамгийн гол нь чи энэ зууралдсан сэтгэлээсээ салах, чи салж чадахгүй байгаа бүх зууралдсан сэтгэлээ хаях хэрэгтэй. Энгийн хүнд энэ нь дур хүсэл, бясалгагчийн хувьд бид үүнийг орхиж чадах хэрэгтэй, хөнгөн харах хэрэгтэй. Зарим хүн үүний хойноос хөөцөлддөг, тийм зүйл толгойд нь дүүрэн, энгийн хүн байсан ч ийм байвал хэтэрсэнд үзнэ. Одоо тэр бясалгагч болсон учраас тийм байж болохгүй илүү учир шалтгаантай, гэхдээ чи бясалгадаг харин хань чинь бясалгадаггүй байж болно, тэгвэл энэ шатанд хэвийн амьдралаараа бай, дээд түвшинд хүрэхээрээ чи өөрөө ямар байхаа мэднэ.

Сурагч: Бясалгал хийж байхдаа унтчихвал яахав? Би яаж

барих вэ? Заримдаа гурван минут хэртэй ухаанаа алддаг, юу ч мэдэхгүй болчихдог. Энэ ямар учиртай вэ?

Багш: Унтаж болохгүй, бясалгаж байхдаа унтаж болох юм уу? Бясалгаж байхдаа унтах нь муу амь бодь үймүүлж байгаа хэлбэр. Чиний ярьж байгаа ухаанаа алдах ийм байдал гарахгүй, магадгүй чи асуултаа буруу бичсэн үү? Хэрэв гурван минут гүн ховсдолын байдалд ордог бол юу ч биш, гүн амгаланд орох чадвар хүчтэй хүнд үргэлж ийм байдал гардаг, гэхдээ урт хугацаагаар байвал болохгүй.

Сурагч: Гэгээрлийн хутагт хүрэх зорилготой хүн бясалгалаар хүрч чадах уу? Хэрэв суурь сайнгүй бол яахав?

Багш: Чамд ийм зориг байгаа үгүйг харна, хамгийн гол нь хэр хүчтэй байгааг нь харна. Суурь сайнгүй хүний зориг бас ухамсрыг харна.

Сурагч: Би ханиадтай эсвэл халуурч байхдаа дасгалаа хийж болох уу?

Багш: Энэ лекцний дараа чамд өвчин байхгүй болно гэж би хэлнэ, магадгүй чи үүнд итгэхгүй. Манай сурагчид заримдаа яагаад ханиадтай, эсвэл халуурч байгаа мэт болдог вэ? Энэ бол саад бэрхшээл, хүнд хэцүүг туулж байгаа хэрэг, түвшнөө ахиулах цаг болсон гэсэн үг. Тэд бүгд үүнийг ойлгодог, үүнд санаа зовдоггүй тэгээд л давчихдаг.

Сурагч: Жирэмсэн хүн Фалунь Гон-оор хичээллэж болох уу?

Багш: Фалунь өөр орон зайд суулгагдсан болохоор үүнд ямар ч асуудал байхгүй, манай бясалгалд огцом хөдөлгөөн байхгүй, жирэмсэн хүнд муугаар нөлөөлөхгүй харин тус нэмэртэй.

Сурагч: Багш биднээс хол явахад зайнаас хамаарах уу?

Багш: Олон хүн ингэж боддог, "Багш Бээжинд байхгүй бид яах вэ?" Чи өөр төрлийн дасгалаар хичээллэхэд бас адилхан багш өдөр болгон чамайг харж байж чадахгүй. Чамд Ном

заасан, зарчмыг хэлж өгсөн, дасгалыг зааж өгсөн, бүрэн цогц зүйлсийг өгсөн, одоо чамд бясалгах л үлдлээ. Чи миний хажууд байвал батлан даалттай, хажууд биш бол баталгаа байхгүй гэж хэлж болохгүй. Бид үүнийг Буддын шавь нарын жишээгээр ярья, Шагжамуни өөд болсноос хойш хоёр мянга гаруй жил өнгөрлөө, гэсэн ч түүний шавь нар уламжлан нэг сэтгэлээр тууштай бясалгаж байгаа биш үү? Тиймээс бясалгах, бясалгахгүй нь чиний хэрэг.

Сурагч: Фалунь Гон-оор бясалгахад бигү мацаг барих уу?

Багш: Үгүй, тэгэхгүй. Яагаад гэвэл бигү мацаг анхдагч аугаа Дао бясалгалын арга, энэ нь Буддын шашин болоод Дао-гийн шашинаас өмнө, шашин үүсэхээс өмнө байсан. Энэ бол ер нь ганцаарчилсан бясалгадаг арга. Анхдагч аугаа Дао-гийн үед байсан шалтгаан нь бол тэр үед сүм хийд байгаагүй, хүмүүс уулын тагтанд хэн ч хоол унд хүргэж өгөх боломжгүй газарт бясалгадаг байсан. Тэр үед хүний хөлөөс зайдуу газар бясалгадаг байхад зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хөдөлгөөнгүй суух шаардлагатай байсан учраас бигү мацагийг хэрэглэдэг байсан. Өнөөдөр манай бясалгалд хэрэггүй, энэ аргыг онцгой нөхцөлд хэрэглэдэг байсан, ямар нэгэн ер бусын чадвар биш. Зарим хүн үүнийг заадаг, харин би хэлбэл ингэж дэлхий даяар хүн болгон идэхгүй болчихвол энгийн хүний нийгмийг эвдэнэ, асуудал гарна. Хэрэв хэн ч юу ч идэхгүй бол хүний нийгэм мөн үү? Тийм байхыг зөвшөөрөхгүй, тийм байж болохгүй.

Сурагч: Энэ таван дасгалаар ямар түвшинд хүрч болох вэ?

Багш: Энэ таван дасгал та бүхнийг бясалгаад асар өндөр түвшинд хүрэх боломжтой болгоно, мэдээж цаг нь болоход ямар түвшинд хүртэл бясалгаж чадахаа мэдэх болно. Манай бясалгалд хязгаар гэж байхгүй, тэр хэмжээнд чи бясалгаад хүрэхэд чамд бас өөр хувь ерөөлийн зохицуулалт байна, чи улам дээд түвшний Аугаа номонд хүрнэ.

Сурагч: "Ном хүнийг бясалгана" Энэ нь Фалунь үргэлж эргэж байдаг болохоор дасгал хийх хэрэггүй гэсэн үг үү?

Багш: Дасгал хийх нь сүм хийдийн аргаас өөр, сүм хийдэд бясалгахад сэтгэлээ бясалгана мөн самади-д суух хэрэгтэй. Тэр чадвар нь бясалгалаар гардаг, юу ч хийхгүйгээр чи гон гаргаж толгой дээрээ өсгөнө гэж ярьж болохгүй, тэгвэл минийхээр бол тэр бясалгагч биш. Бясалгал болгонд өөрийн уламжлагдсан зүйл байдаг, тэр нь бясалгалаар гардаг.

Сурагч: Бусад бясалгалын хүмүүс бодлоор удирдахгүй хийхийг бясалгалын арга биш гэдэг. Энэ нь зөв үү?

Багш: Хүмүүс янз бүрээр ярьдаг, гэхдээ хэн ч Аугаа номыг чамд над шиг заагаагүй. Буддын системд бодлоор бясалгах аргаар өндөр түвшинд хүрэхгүй гэж үздэг, миний хэлдэг бодол хэрэглэдэг бясалгалын арга гэдэг нь бясалгалд байдаг хөдөлгөөнийг хэлээгүй. Бясалгаж суух, мөн Жэинь бол бас хөдөлгөөн, хөдөлгөөний их багаас шалтгаалахгүй. Санаатай эсвэл санаандгүйгээр гэдэг нь чиний бодлыг хэлж байна. Бодлын хувьд, чи ямар нэгэн зүйлийг хүсэх хөөцөлдөх нь зорилготой гэсэн үг, тэгвэл зууралдсан сэтгэл болно. Ингэж хэлсэн л үг.

Сурагч: Зан чанар буянтай адил биш. Та буян хүний түвшинг тодорхойлдог гэсэн, та бас зан чанар хэр өндөр байна гон тийм өндөртэй гэсэн. Энэ хоёр хоорондоо зөрчилдөж байгаа биш үү?

Багш: Магадгүй чи тодорхой сонсоогүй байх, зан чанар өргөн хүрээний зүйлийг хамаардаг, буян түүний нэг хэсэг. Үүнд бас тэвчээр, хүнд бэрхшээлийг даах чадвар, ухамсар, зөрчилдөөнд яаж хандах гээд цааш олон зүйл орно. Энэ бүгд зан чанарт харьяалагддаг зүйлс, үүнд гоны хувиралт мөн буянгийн хувиралт хамаарагдана, их өргөн хүрээний зүйлс багтдаг. Чиний буян хэр их байна гон чинь тийм өндөр гэсэн үг биш, харин хэр их хэмжээний гон гаргаж болохыг заадаг. Зөвхөн сорилтонд зан чанар чинь дээшилбэл буян гон болж хувирч болно.

Сурагч: Манай гэр бүлийнхэн өөр өөр төрлийн чигон-оор хичээллэдэг. Бид нэг нэгэндээ саад болох уу?

Багш: Тэгэхгүй, гэхдээ би тэдгээр нь хоорондоо нөлөөлж чадахгүй гэж хэлэхгүй, харин бидний Фалунь Гон-д хэн ч саад болж чадахгүй. Чиний бясалгал тэдэнд ашиг тустай. Бид ариун Номын бясалгал хийдэг учраас чи буруу хазайхгүй.

Сурагч: Нийгэмд янз бүрийн дамжсан захиа байдаг, жишээ нь алтан цоожтой гинж зүүх сайн гэх мэт. Бид эдгээрт яаж хандвал зохих вэ?

Багш: Би та нарт хэлэхэд ийм зүйл жинхэнэ хуурамч, тийм захианд битгий хариул, энэ үнэхээр утгагүй зүйл, битгий анхаар. Чи нэг хараад л зүйтэй, үгүйг нь хэлж чадна. Манай Ном зан чанарыг бясалгах хатуу шаардлагатай. Би зарим чигон багшийг чигон наймаачин гэнэ, тэд чигон-ыг нэг төрлийн бараа, мөнгө олох хэрэгслээ болгосон. Тэдгээр хүмүүс бясалгал заавал юу ч гаргаж чадахгүй, багахан зүйл гаргасан ч дээд түвшнийх биш, зарим зүйл нь бүр ад чөтгөрийнх.

Сурагч: Фалунь Гон-ы сурагч Буддын сүм хийдэд шавилах зан үйл хийсэн бол яах вэ? Үүнээс гарсан нь дээр үү?

Багш: Бидэнд энэ нь ямар ч хамаа байхгүй, чиний хийсэн шашны зан үйл бол зөвхөн ёс төдий зүйл.

Сурагч: Фалунь Гон хичээллэсний дараа бидний заримын толгой хөөсөн мэт болох юм бас толгой эргэдэг.

Багш: Магадгүй та нар шинэ сурагчид, тэгээд бие чинь бүрэн засагдаагүй байгаа. Миний гаргасан хүчирхэг энерги чиний өвчний чий-г туун гаргахад толгой чинь хөөсөн мэт болно. Бид чиний толгойн өвчнийг эдгээхэд ийм байдал гарна, энэ нь сайн зүйл. Өвчин хурдан арилах тусам мэдрэмж улам хүчтэй байна. Бид долоон өдрийн лекцээр хичээллэхэд зарим хүн даахгүй байсан, хэрэв бид улам

богиносговол бүр хүндэрнэ, гаргаж байгаа энерги их хүчтэй учраас тэр мэдрэмж бас их хүчтэй. Арван өдрийн лекц илүү тохиромжтой. Хоцорч эхэлсэн хүмүүст арай хүчтэй мэдрэмж гардаг.

Сурагч: Гон бясалгаж байхад тамхи татаж, архи ууж болох уу? Ажил дээр уух шаардлагатай бол яах вэ?

Багш: Энэ асуултанд би ингэж хариулъя: Бид Буддын системээр бясалгаж байгаа, архи уухаа болих хэрэгтэй. Уухгүй удаан байж байгаад дахиад уух хүсэл төрж болно, тэгвэл аажмаар гар, гэхдээ их сунжруулж болохгүй тэгвэл шийтгэл авна. Тамхи татах нь санааны хэрэг, чи тамхинаас гаръя гэвэл гарч чадна. Энгийн хүн ихэвчлэн "Өнөөдрөөс эхлээд тамхинаас гарлаа" гэдэг, гэвч хэдэн өдрийн дараа тэвчиж чаддаггүй. Хэдэн өдрийн дараа тамхинаас гарах бодол дахин орж ирдэг, гарах гэж дахиад үзнэ, ийм байдлаар тамхинаас гарч чадахгүй. Энгийн хүн энэ дэлхийд амьдрахдаа бусадтай нийгмийн харилцаанд орохгүй зайлсхийж байх аргагүй, гэхдээ чи бясалгаж эхэлсэн болохоор өөрийгээ энгийн хүн шиг үзэхээ болих хэрэгтэй. Чамд сэтгэлийн хүч байвал хэлсэндээ хүрнэ. Мэдээж миний зарим сурагч татсан хэвээрээ, тэд тамхинаас гарч чадах байсан ч бусдыг тамхиар дайлахад татгалзах нь эвгүй санагддаг. Хоёр хоног татахгүй бол хэцүү санагдана, татсан ч бас хэцүү. Өөрийгээ барьж сур! Зарим хүний ажил хүмүүстэй бизнесийн холбоо тогтоох, тэгээд үе үе хамт уух дайлах болдог, энэ бол шийдэхэд хэцүү асуудал. Чи аль болохоор бага уухыг бод, эсвэл өөр арга бодож ол.

Сурагч: Бид Фалунь эргэхийг харж чадахгүй байхдаа үүнийг цагийн зүүний дагуу эргэж байна гэж бодоход хэрэв эсрэгээр эргэж байсан бол түүнд саад болох уу?

Багш: Фалунь автоматаар эргэдэг, үүнд чиний бодлын нөлөө хэрэггүй. Би дахиад хэлье, битгий бодлоо оролцуул, бодлоор ч удирдаж чадахгүй. Чи бодлоороо үүнийг албадан эсрэг зүг эргүүлнэ гэж битгий бод, хэвлийн доод хэсэгт

байрлах Фалунь бодлоор удирдагдахгүй. Чиний биеийг засахад хэрэглэж байгаа гаднах Фалунуудыг тодорхой зүг рүү эргэхийг хүсвэл хүлээн авч магадгүй, чи үүнийг мэдэрч болно. Гэхдээ би чамд хэлэхэд, битгий бодлоо оролцуулж бясалга. Хэрэв бодлоо оролцуулж бясалгавал чи өөрөө бясалгасан гэсэн үг. Бодлоороо удирдаж бясалгах юм бол хүн гон-ыг бясалгадаг болох уу? Харин биднийхээр бол Фалунь хүнийг бясалгана, Ном хүнийг бясалгана. Яагаад энэ бодлоо орхиж чадахгүй байна вэ? Аль ч бясалгалд, Даогийн бясалгалд хүртэл дээд түвшинд хүрэхэд бодлын оролцоо байдаггүй.

Сурагч: Фалунь Гон-оор хичээллэхэд ямар цагт, хаана, аль зүг рүү харж хийвэл хамгийн сайн бэ? Өдөрт хэдэн удаа хийвэл дээр вэ? Дасгалыг хоол идэхийн өмнө эсвэл дараа хийхээс хамаарах уу?

Багш: Фалунь бол дугуй, орчлон ертөнцийн хураангуйлал, тиймээс орчлон ертөнцийн зарчмын дагуу бясалгадаг, орчлон ертөнц хөдөлгөөнд байдаг учраас Ном хүнийг бясалгадаг, бясалгал хийгээгүй байхад ч чамайг бясалгадаг, үүгээрээ нийтэд дэлгэрсэн ямар ч бясалгалын арга, онолоос өөр. Миний энэ бясалгал бол Ном хүнийг бясалгадаг цорын ганц арга. Бусад бүх бясалгалын арга үрлийн замаар явдаг, биднийхээс өөр, тэдгээр нь зохиомлоор бясалгаж үрлийг хураадаг. Манай бясалгалд хэдийд ч дасгалаа хийсэн болно, чамайг дасгал хийгээгүй байхад гон чамайг бясалгана, цаг сонгох хэрэггүй, цаг завтай бол дасгалаа удаан хугацаагаар хийж болно, цаг бага бол бага хийж болно. Манай дасгал энэ байдлаараа их чөлөөтэй, харин зан чанарт тавигдах шаардлага хатуу. Мөн дасгал хийхэд зүг чигээс хамаарахгүй, аль ч зүг рүү харж хийсэн болно, яагаад гэвэл орчлон ертөнц эргэх хөдөлгөөнд байдаг. Чи баруун зүг рүү харж хийж байна гэсэн ч үнэндээ баруун зүг биш, зүүн зүг рүү харж хийж байна гэсэн ч магадгүй зүүн зүг биш. Би сурагчиддаа зүгээр хүндэтгэл болгож баруун зүг харж дасгалаа хий гэдэг, гэхдээ үүнд ямар ч нөлөө байхгүй. Чи

дасгалаа хаана ч хийж болно, гэртээ эсвэл гадаа, гэхдээ би харьцангуй цэвэр орчин, агаартай газар сонгох хэрэгтэй гэж үздэг, хогийн сав, жорлон мэтийн бохир зүйлээс хол байх хэрэгтэй, бусад зүйлс их хамаатай биш. Дафа бясалгал хийхэд цаг, байрлал, зүг чиг чухал биш. Мөн хоолны өмнө эсвэл дараа дасгалаа хийж болно гэхдээ их хоол идээд шууд хийх тохиромжгүй эхлээд жоохон амарсан нь дээр. Мөн их өлсөж гэдэс чинь хоржигнож байвал амгаланд ороход бас хэцүү. Чи өөрийнхөө нөхцөл байдалд зохицуулан хийх хэрэгтэй.

Сурагч: Дасгал хийж дууссаны дараа хийх ямар нэгэн зүйл бий юу, жишээ нь нүүрээ илэх гэх мэт?

Багш: Дасгал хийж дууссаны дараа хүйтэн уснаас болгоомжлох гэх мэтийн зүйл байхгүй, нүүр гараа илэх ч хэрэг байхгүй. Тийм зүйлс бол биений судлууд, зүүний цэгүүдийг нээх утгатай, эдгээр нь дасгалын эхэнд л хийгдчихсэн. Бид Аугаа номоор бясалгадаг, үүнд тийм зүйлс байхгүй. Одоо чиний бие эхний заслын үеэ өнгөрчихсөн. Энгийн хүнд бясалгагч болоход маш хэцүү санагддаг, зарим бясалгалын арга хүний биеийг шууд өөрчлөх чадваргүй, мөн зарим шаардлага нь их төвөгтэй. Бидэнд тийм зүйл байхгүй, тийм ойлголт ч байхгүй. Миний яриагүй зүйлд битгий санаа зов, зүгээр бясалгалдаа л төвлөр. Бид хэдхэн өдрийн дотор чиний бие янз бүрийн зүйлээс эмээх, эсвэл олон талын шаардлага бүхий эхний шатаа давчихна. Яагаад гэвэл бид Аугаа номоор бясалгаж байгаа. Би үүнийг бусад бясалгалын аргаар бол хэдэн жил бясалгасантай адил гэж хэлэхэд хилсдэхгүй. Би доод түвшний тийм ийм зүг чиг, суваг, гэх мэт зүсэн зүйлийн юм ярихгүй, бид дээд түвшний зүйл л заадаг. Дафа бясалгалд, жинхэнэ бясалгалд бясалгалаар дээшилдэг, харин дасгалаар биш.

Сурагч: Дасгал хийж дуусангуут бие засч болох уу? Миний шээс их хөөстэй байдаг, чий гадагш алдагдаж байгаа юу?

Багш: Энэ бол зүгээр, бид дээд түвшинд бясалгаж байгаа болохоор бидний шээс, өтгөнөөр энерги гарч байдаг, гэхдээ бага зэрэг, юунд ч нөлөөлөхгүй. Аугаа номоор бясалгахад бүх амийг аварна, тэр бага зэрэг алдагдал юу ч биш, бидний буцааж олж байгаа нь асар их. Энэ лекцийг уншиж байхдаа миний гаргаж байгаа энерги аугаа хүчирхэг, дараа нь бүх хананд их зүйл үлддэг.

Сурагч: Бид Фалунь Гон-ыг тарааж дэлгэрүүлж болох уу? Лекц сонсоогүй хүнд бид зааж өгч болох уу? Тэд дадлагажуулах төвд суралцаж болох уу? Хотоос зайдуу амьдардаг гэр бүлийнхэн, найз нөхөддөө дууны бичлэг, ном шуудангаар илгээж болох уу?

Багш: Чи бидний бясалгалыг тарааж олон хүн үүнээс ашиг тус хүртэхэд буруутах зүйлгүй. Би та бүхэнд олон ном ярьсан, ном заасан, дээд түвшний зүйлийг ойлгуулсан. Би зарим зүйлийг урьдчилан хэлж өгсөн, тэгэхгүй бол та нар хожим тэр зүйлийг хараад, түүнтэй учрахдаа ойлгохгүй гэж болгоомжилсон. Чи хүмүүст дасгал зааж өгч болно, гэхдээ Фалунь суулгаж өгч чадахгүй. Тэгвэл яах вэ? Би хэлсэн, чамайг жинхэнэ бясалгахгүй алдаг оног яваад байвал миний Номын биес чамайг орхиод явна, жинхэнэ бясалгавал миний Номын биес чамайг харж хандана. Тэгэхээр чи хүнд дасгал заахад чамд миний өгсөн мэдээлэл байгаа, үүнд Фалунь гаргах механизм бий. Тэр заалгасан хүн сэтгэлээсээ бясалгавал Фалунь бүрэлдэн гарна, хэрэв хувь заяанд нь төлөвлөгдсөн, сайн суурьтай хүн бол Фалунийг тэр даруйдаа авна. Манай номонд их тодорхой бичсэн. Биечлэн заалгаагүй хүн байсан ч бясалгаж болно.

Сурагч: Фалунь Гон-д амьсгал авахдаа анхаарах уу? Яаж амьсгалаа зохицуулах вэ?

Багш: Фалунь Гон-оор хичээллэхэд амьсгал авах гаргааа зохицуулах хэрэг байхгүй, амьсгалд бид анхаарахгүй. Энэ бол эхлэн сурагчийн мэдэх зүйл, бидэнд энд хэрэггүй, амьсгалаа зохицуулах удирдах нь үрлийг бясалгахад байдаг,

үлээж гал өрдөх гэх мэт. Дагуу урсгалаар амьсгалах (Гэдсээ төмбийлгэж амьсгаа авах), эсрэг урсгалаар амьсгалах (Гэдсээ татаж амьсгаа авах), шүлсээ залгих, гэх мэт бол бүгд үрлийн бясалгалын арга, бид үүнийг хийдэггүй. Чамд хэрэгтэй бүхнийг Фалунь хийж өгдөг, зарим төвөгтэй, нарийн зүйлсийг Багшийн Номын бие хийж өгдөг. Аль ч бясалгалд ялангуяа Дао системд их дэлгэрэнгүй ярьдаг, гэхдээ тэр хүн өөрөө гаргадаггүй, харин тэр сургуулийн их багш үүнийг бүтээдэг, хувирган гаргаж өгдөг, тэр хүн үүнийг мэдэхгүй. Тэр өөрөө хийж чадахгүй зөвхөн гэгээрсэн, гон нээгдсэн хүн хийж өгч болно.

Сурагч: Бид дасгал хийхдээ анхаарлаа төвлөрүүлэх үү? Хаана төвлөрүүлэх вэ?

Багш: Бидэнд анхаарлаа төвлөрүүлэх зүйл байхгүй. Би та нарт анхаарал төвлөрүүл гэж хэзээ ч хэлдэггүй, энэ зууралдсан сэтгэлээсээ сал, ямар ч бодол оролцуулж хэрэггүй. Гуравдугаар дасгалд хоёр алганы чий хоёр туйлд хүрдэг, энд хоромхон зуур бодоход л болоо өөр юу ч битгий бод.

Сурагч: Энерги цуглуулах чий хураахтай адил уу?

Багш: Бид чий хурааж яах юм? Бид Дафа-гаар бясалгадаг, яваандаа чий гаргаж ч чадахгүй болно. Бидний бясалгадаг нь доод түвшний чий биш, харин гаргадаг нь туяа. Фалунь энерги цуглуулдаг, бид хийх хэрэггүй. Жишээ нь сансрын хоёр туйлыг нэвтрэх дасгалаар чий хураадаггүй, харин бие дундуур өнгөрөөдөг, мөн энерги цуглуулах нөлөөтэй, гэхдээ гол зорилго нь биш. Хүн чий яаж хураадаг вэ? Чи Дафа-гаар бясалгахад гараа нэг даллахад гэнэт их хэмжээний чий ирж толгой хүндэрч мэдрэгдэнэ. Гэхдээ тэр чий ямар хэрэгтэй юм? Мөн цуглуулсан энергээ санаатайгаар хураах гэсний ч хэрэггүй.

Сурагч: Фалунь Гон-д "зуун өдөр суурь тавих" мөн "үр хөврөлийн амьсгал" байдаг уу?

Багш: Энэ бүгд доод түвшнийх, бид хийдэггүй. Бид аль хэдийн тэр тогтворгүй эхний шатыг өнгөрсөн.

Сурагч: Фалунь Гон арга билгийн тэнцвэрийг ярьдаг уу?

Багш: Энэ бол бас л чий-тэй холбоотой доод түвшнийх, чи энэ түвшнөөс гарангуут арга билгийн тэнцвэр гэж ярихаа болино. Чи ямар системд бясалгаж байсан ч багшаас жинхэнэ уламжилж авсан бол, доод түвшнийг ардаа орхингуут урьд бясалгасан бүх зүйлс арчигдана юу ч үлдэхгүй! Тэгээд шинэ түвшинд шинэ цогц зүйл бясалгана, дараа нь тэр түвшнөөс гарахад дахиад шинэ зүйл бясалгана, ингэж цааш үргэлжилдэг.

Сурагч: Тэнгэр дугарч байхад дасгалаа хийж болох уу? Фалунь Гон хичээллэдэг хүн чимээнээс айх ёсгүй юу?

Багш: Чамд нэг жишээн дээр тайлбарлаж өгье. Би анх Бээжинд нэг том байшингийн хашаан дотор сурагчдад дасгал зааж байхад бороо орох гэж байсан, тэнгэрийн дуу их чанга байсан. Тэгэхэд тэд дасгалаа хийж байсан, Фалунь баганы хөдөлгөөнт дасгал, би үүнийг зөвхөн уламжилсан шавь нартаа заадаг. Би бороо ирж байгааг харсан, гэхдээ тэд дасгалаа хийж дуусаагүй байсан. Ширүүн бороо гэхдээ асгараагүй, үүл их доошилж байшингийн дээр хуран тэнгэр харанхуйлсан байсан, аянга цахилж их нүргээнтэй байсан. Тэгэхэд аянга Фалуний захад буусан гэхдээ бид жоохон ч гэмтээгүй. Бидэнд аянга хаана буусан нь илт харагдаж байсан, гэхдээ бид шалбараа ч үгүй гарсан. Энэ нь манай дасгал хамгаалалтайг харуулж байна, би ер нь дасгал хийхдээ цаг агаарын байдлыг хардаггүй, цаг л байвал хэзээ дасгал хиймээр байна хийдэг, чимээнээс айдаггүй. Бусад аргаар хичээллэдэг хүн чимээнээс айдаг, гүн амгалан байдалд байхад гэнэт чанга дуу гарахад бүх биений чий дэлбэрэх шиг гялалзаж биенээс гардаг. Манай дасгалд ийм санаа зовох зүйлгүй. Мэдээж гэхдээ нам гүм газар олж хийхийг бод.

Сурагч: Бид Багшийн дүрийг төсөөлөх хэрэгтэй юу?

Багш: Тэгэх хэрэг байхгүй, чиний тэнгэрийн нүд нээгдэхэд миний Номын бие хажууд чинь байгааг харна.

Сурагч: Таван дасгал хийхэд ямар нэгэн шаардлага бий юу? Бүгдийг хамт хийх ёстой юу? Есөн удаа давтаж хийхийг амандаа тоолж болох уу? Хэрэв есөөс илүү удаа хийвэл эсвэл зарим хөдөлгөөнийг буруу хийвэл сөрөг нөлөөлөх үү?

Багш: Чи энэ таван дасгалаас аль дуртайгаа хийж болно, гэхдээ нэгдүгээр дасгалыг бусдаас өмнө хийх нь сайн яагаад гэвэл энэ нь бүх биеийг бэлдэж өгдөг. Эхлээд үүнийг хийх хэрэгтэй, тэгээд бүх бие чинь бэлэн болсны дараа бусад дасгалуудыг хийвэл илүү үр дүнтэй. Дасгалаа бүгдийг нь хиймээр байна уу боломжоороо л бол, хэр их цаг байна түүгээрээ л хий, ганц дасгалыг сонгож хийсэн ч болно. Гурав дахь, дөрөв дөх дасгалын хөдөлгөөн тус бүр есөн удаа давтагдах ёстой, номонд бичигдсэн дагуу есөн удаа дотроо тоолж болно. Гэртээ хариад хүүхдээ хажуудаа зогсоон тоолуулж болно. Есөн удаа давтсаны дараа энергийн механизмыг мэдрэх гэж оролдсон ч чадахгүй, миний зүйл ингэж ажилладаг. Эхэндээ чи бодож болно хэвшээд ирэхээрээ автоматаар болдог. Зарим хөдөлгөөнийг сайн санахгүй бол, илүү олон давтдаг бол эсвэл дутуу хийдэг бол засчих тэгээд л зүгээр.

Сурагч: Хөдөлгөөн дуусахад яагаад дасгал дуусдаггүй вэ?

Багш: Фалунь автоматаар эргэдэг, чамайг дасгалаа хийж дуусахыг дор нь мэднэ. Энэ нь асар их энергитэй, цацаргаснаа буцаагаад авчирдаг, санаатайгаар хийснээс хавьгүй дээр. Дасгалыг дуусгаж байгаа биш зөвхөн энергийг л буцааж авч байгаа юм. Бусад дасгалын аргад дуусгаад минут болоход л дасгал дуусдаг. Манай бясалгалд үргэлж дасгал хийгдэж байдаг, хөдөлгөөн зогссоны дараа ч дасгал дуусахгүй. Чи Фалуний эргэлтийг зогсооё гэсэн ч чадахгүй, би үүнийг гүнзгий тайлбарлавал чи ойлгохгүй.

Чи үүний эргэлтийг зогсоож чадвал би зогсох болно, намайг зогсоож чадах уу?

Сурагч: Жэинь, Хөши гарын барилтыг багана зогсолт шиг хийж болох уу?

Багш: Эхний дасгал, "Буддын мянган гарын сунгалт" ыг багана зогсолт шиг хийж болохгүй, сунгалтанд хэтэрхий их хүч гаргавал болохгүй, асуудал гарна.

Сурагч: Дасгал хийж байхдаа сугаа хөндий байлгах хэрэгтэй юу? Эхний дасгал хийж байхад миний суга хатуурсан мэдрэгддэг, яагаад тэр вэ?

Багш: Чамд өвчин байгаа юу? Эхний шатанд бие чинь засал хийгдэж байхад янз бүрийн байдал гарч болно. Чамд зарим шинж тэмдэг илэрнэ, гэхдээ энэ нь дасгал хийснээс биш.

Сурагч: Ли багшийн лекцэнд суугаагүй хүн бусад сурагчдын хамт паркад дасгал хийж болох уу?

Багш: Болно. Аль ч сурагч бусаддаа дасгал яаж хийхийг зааж өгч болно. Сурагчид бусдад дасгал зааж өгөх нь миний энд дасгал заахтай адилгүй, би чиний биеийг шууд засч өгдөг. Гэхдээ зарим хүн дасгал хийж эхлээд л Фалунь авсан. Сурагч болгоны ард миний Номын биес байдаг, тэд үүнийг шууд хийж чадна. Бүгд тэр хүний хувь заяны тохироотой холбоотой, энэ тохироо нь бүрдсэн бол тэр хүн Фалунийг тэр даруй олж авна, хувь заяны тохироо бага бол дасгалаа тогтмол хийгээд байхад яваандаа эргэлтийн механизмтай болдог. Цааш хичээллэхэд эргэлтийн механизмын нөлөөгөөр Фалунь гардаг.

Сурагч: Ер бусын чадвар эрчимжүүлэх дасгалын гарын барил ямар учиртай вэ?

Багш: Бидний хэлээр илэрхийлэх боломжгүй, гарын барилт болгон баялаг агуулгатай. Ерөнхий утга нь: "Би дасгалаа хийх гэж байна, Буддын номоор хичээллэхэд бэлэн. Биеэ сайн зохицуулж дасгалын байдалд орлоо."

Сурагч: Сүүн цагаан биений түвшинд бясалгаад хүрэхэд бүх хөлсний сүвүүд онгойж биений амьсгал явагддаг гэж үнэн үү?

Багш: Чи мэдрэх гэж үз, чи аль хэдийн энэ түвшинг өнгөрчихсөн. Чамайг сүүн цагаан биений байдалд хүргэж биенийг чинь засахад би арваас доошгүй цаг Ном заах хэрэгтэй, үүнээс богино байж болохгүй. Чи өөр бясалгалын замаар явбал хэдэн арван жил, түүнээс ч удаанаар бясалгах хэрэгтэй болно бид чамайг ийм байдалд дор нь хүргэсэн. Энэ шатанд зан чанарын шаардлага байхгүй учраас багшийн чадварт үндэслэн хийгдэнэ, чамайг мэдрэхээс өмнө тэр түвшин өнгөрчихнө, магадгүй хэдэн цаг л болно. Чи нэг л өдөр их мэдрэмтгий байж магад, тэгээд дороо мэдрэхээ болино, үнэндээ нэг том түвшинг давсан юм. Бусад бясалгалын аргаар бол чи энэ байдалд жил түүнээс ч удаанаар байна. Үнэндээ энэ бол доод түвшний зүйл.

Сурагч: Би автобусаар явж байхдаа, эсвэл оочерт зогсож байхдаа Фалунь Гон дасгалын хөдөлгөөнийг бодож байж болох уу?

Багш: Манай дасгал бодлоор удирдахыг шаардахгүй, өдөр бүр дасгалыг хэр удаан хийх тодорхой шаардлага байхгүй. Мэдээж урт хийх тусам сайн, гэхдээ чи дасгалаа хийгээгүй байхад ч энэ нь чамайг бясалгаж байна. Эхний шатанд дасгалаа сайн хийж энергийн механизмаа бэхжүүлэх нь дээр гэдэг. Зарим сурагчид ажлаар сар, хоёр сараар дасгал хийх завгүй явж байгаад харихад ямар ч саар нөлөө гардаггүй гэдэг, Фалунь эргэсэн хэвээр хэзээ ч зогсдоггүй. Чи өөрийгээ бясалгагч гэж үзсэн хэвээр зан чанараа сайн барьж байвал энэ нь үргэлжлэн ажиллана. Гэхдээ нэг зүйл бий: Хэрэв чи бясалгахгүй бол, өөрийгээ энгийн хүнтэй андуурвал энэ нь алга болно.

Сурагч: Фалунь Гон-ыг Тантрын шашинтай хамт бясалгаж болох уу?

Багш: Тантрын шашинд бас Фалунь байдаг, гэхдээ манай бясалгалтай хамт хичээллэж болохгүй. Хэрэв чи Тантрын шашны Фалунийг бясалгаж үүсгэсний дараа Тантрын шашнаараа үргэлжлүүлэн бясалгаж болно. Яагаад гэвэл энэ ч бас ариун Ном юм. Гэхдээ хамт бясалгаж болохгүй. Тантрын шашны Фалунь гол тэнхлэгийн сувгийг бясалгадаг, энэ нь хэвтээгээр эргэдэг. Энэ Фалунь манай Фалунаас ялгаатай, хүрдэн дээр нь тарни байдаг. Манай Фалунь хэвлийн доод хэсэгт босоогоор хавтгай талаар гадагш харан байрладаг. Хэвлийн доод хэсэгт зай бага миний Фалунь дангаар бүх зайг эзэлдэг, хоёр дахийг байрлуулбал шахцалдана.

Сурагч: Бид Фалунь Гон-оор хичээлэхийн хажуугаар Буддын өөр бясалгалын аргаар хичээллэж болох уу? Бодьсатва Гуаниний нэрийг уншсан дууны бичлэгийг сонсож болох уу? Буддын сүсэгтэн Фалунь Гон-оор бясалгасны дараа судар уншиж болох уу? Бусад дасгалыг давхцуулан хийж болох уу?

Багш: Би болохгүй гэж бодож байна. Бясалгал болгон өөрийн аргатай, хэрэв чи зөвхөн эдгэрэх, эрүүл мэндээ сайжруулахын тулд биш харин жинхэнэ бясалгахыг хүсвэл нэг бясалгалд тууштай байх ёстой. Энэ бол ноцтой асуудал. Дээд түвшинд бясалгахад бясалгалын нэг замаар явахыг шаарддаг. Энэ бол туйлын үнэн. Буддын системийн бясалгалуудыг хооронд нь хольж болохгүй. Бидний энд хийж байгаа бясалгал бол дээд түвшнийх, өнө эртний үеэс уламжлагдан ирсэн, санааныхаа зоргоор хийж болохгүй. Өөр орон зайнаас түүний хувирах явцыг харахад бүгд маш гүн гүнзгий нарийн төвөгтэй байдаг, яг нарийн тоног төхөөрөмжний адил аль нэг сэлбэгийг нь аваад оронд нь хамаагүй нэг сэлбэг тавьчихвал тэр дороо эвдэрчихнэ. Бясалгалд бас адил, юуг ч хольж болохгүй, хооронд нь хольбол буруутна. Бүх бясалгалын аргууд адилхан, хэрвээ бясалгахыг хүсвэл нэг бясалгалдаа тууштай байх ёстой, эс бөгөөс чи үндсэндээ бясалгаж чадахгүй. "Бясалгал

болгоноос сайныг нь ав" гэдэг үг байдаг, энэ бол зөвхөн өвчин эдгээх, бие эрүүлжүүлэх түвшинд л яригддаг, дээд түвшин лүү чамайг дагуулж чадахгүй.

Сурагч: Бид өөр бясалгалын хүмүүстэй дасгал хамт хийвэл нэг нэгэндээ саад болох уу?

Багш: Тэр ямар бясалгалынх байна хамаагүй, Дао-гийн бясалгагч, ер бусын бясалгалынх ч байна уу, Буддынх ч байна уу зөвхөн ариун номынх л бол бидэнд ямар ч саад болохгүй. Чи түүнд ч саад болохгүй, харин тэр чиний хажууд дасгалаа хийхэд түүнд ашигтай. Фалунь бол оюун ухаант амь бодь, үрлийг бясалгадаггүй, бусдад автоматаар тусална.

Сурагч: Би өөр чигон багшаар биеэ засуулж болох уу? Өөр чигон багшийн лекцэнд суувал харшлах уу?

Багш: Энэ лекцний дараа та нар өөрсдийнхээ биеийг ямар болсныг мэдэрнэ. Хэсэг хугацааны дараа өвчин чамд байхыг зөвшөөрөхгүй, дахин асуудал гарахад магадгүй ханиад эсвэл гэдэс өвдөх хэлбэрээр илэрнэ, үнэндээ энэ бол өвчин биш, харин сорилт даваа юм. Чи өөр чигон багш олж засуулна гэвэл миний хэлснийг ухамсарлаагүй эсвэл миний хэлсэнд итгэхгүй байгаа хэрэг. Чи ямар нэгэн зүйлийг олох гэж хөөцөлдвөл муу мэдээллийг өөртөө татаж бясалгалд чинь саад болно. Хэрэв тэр чигон багшид шүглэсэн сүнсний гон байвал чи бас тэр зүйлийг өөртөө татна. Лекцийг нь сонсох бас адилхан, сонсохыг хүснэ гэдэг чинь ямар нэгэн зүйлийг хүссэн хэрэг биш үү? Чи өөрөө үүнийг ухамсарла, энэ бол зан чанарын асуудал, би үүнд оролцохгүй. Хэрэв тэр дээд түвшний зарчим, зан чанарын асуудал ярьж байгаа бол өөр хэрэг, гэхдээ чи миний лекцэнд суусан чиний бие засагдсан. Урд чиний бясалгасан мэдээлэл их төвөгтэй, биеийг чинь замбараагүй болгосон, одоо бүгд засагдаж цэгцлэгдсэн, мууг нь гаргаж сайныг нь үлдээсэн. Мэдээж би чамайг өөр бясалгал сурахыг чинь хорихгүй, чи Фалунь Гон-ыг дээр гэж бодохгүй бол өөр бясалгал сурч болно.

Гэхдээ чи их олон янзын зүйл сурвал чамд сайн биш гэж би бодож байна. Чи Аугаа номоор бясалгасан, Номын биес чиний хажууд байна, чи дээд зүйлсийг олсон, одоо буцаад доошлохыг хүсч байна уу?

Сурагч: Бид Фалунь Гон бясалгалаар хичээллэж байвал массаж, бие хамгаалах урлаг, Нэг хурууны Даяан, Тайжи гэх мэт аргад суралцаж болох уу? Эсвэл хичээллэхгүй зүгээр номыг нь уншвал болох уу?

Багш: Чи массаж, бие хамгаалалт сурах бол яахав, гэхдээ тэр ширүүн байдлыг мэдэрч эхлэхэд чамд амаргүй болно. Нэг хуруу Даяан, Тайжи бол чигон-д харъяалагдана. Чи түүгээр хичээллэвэл тэдгээрийг биендээ нэмж чиний биед байгаа миний зүйлүүдийг цэвэр биш болгоно. Зан чанарын талаар өгүүлсэн ном уншихад бол яахав, гэхдээ зарим зохиолч юмны учрыг өөрөө сайн мэдэхгүй хамаагүй дүгнэлт хийдэг, тэр нь чиний бодлыг төөрөлдүүлнэ.

Сурагч: Толгойн өмнө хүрд барих дасгал хийж байхад миний хоёр гар шүргэлцээд байдаг, ингэж болох уу?

Багш: Гараа битгий хүргэ, бага завсартай байлга, гар шүргэлцвэл гарт байгаа энерги буцаад биенд орно.

Сурагч: Хоёрдугаар дасгал хийж байхад гараа өргөж байж чадахгүй болбол түр буулгаж амраагаад буцаагаад үргэлжлүүлж болох уу?

Багш: Бясалгал бол амаргүй зүйл, чиний гар чилэхэд буулгаж амраавал үр дүнгүй болно. Зааварчилбал, удаан барих тусмаа сайн. Гэхдээ чи өөрийнхөө боломжоор хий.

Сурагч: Бүтэн лянхуа завилалтанд яагаад зүүн хөл доор, эмэгтэй хүний бол баруун хөл дор нь байдаг вэ?

Багш: Яагаад гэвэл манай бясалгалд нэг чухал хүчин зүйлийг анхаардаг, эмэгтэй хүний бие эрэгтэй хүнийхээс ялгаатай. Эмэгтэй хүн өөрөө дотоод биеэ хувиргах гэвэл бясалгал нь эмэгтэй хүний биед зохицсон байх ёстой. Эмэгтэй хүний зүүн хөл баруун хөлөө өргөдөг, энэ нь биенд

тохиромжтой. Эрэгтэй хүний хувьд эсрэг, үндсэн байдал нь өөр.

Сурагч: Дасгал хийхдээ кассетний бичлэг сонсож эсвэл хөгжим ая сонсож, эсвэл уншлагыг давтан хэлж байж болох уу?

Багш: Буддын системийн сайн ая бол болно, гэхдээ жинхэнэ бясалгалд чи ямар ч ая битгий сонс, яагаад гэвэл амгаланд орохыг шаарддаг. Харин бидний сонсдог ая бол тоо томшгүй олон бодлыг нэг болгох зорилготой юм.

Сурагч: Хоёр туйлыг нэвтрэх дасгалын үед биеэ сул байлгах уу эсвэл чангалж байх уу?

Багш: Хоёр туйлыг нэвтрэх дасгалд чөлөөтэй сул зогсоно, нэгдүгээр дасгалын шаардлагатай адилгүй, манай бусад дасгалууд нэгдүгээр дасгал шиг биш биеэ сул байлгахыг шаарддаг.

3. Зан чанараа бясалгах

Сурагч: Би Үнэн, Нинжин, Тэвчээр зарчим баримтлахыг хүсч байна, гэхдээ урд шөнө нэг хүнтэй ширүүн хэрэлдэж байна гэж зүүдэллээ, би тэвчих гэсэн боловч чадаагүй. Энэ нь миний зан чанарыг дээшлүүлэх гэж байсан уу?

Багш: Яг тийм. Би та нарт зүүд гэж юу болохыг хэлсэн, энэ талаар өөрийнхээрээ ойлго. Чиний зан чанарыг дээшлүүлэх зүйлс гэнэт гардаг, чамайг сэтгэл санааны бэлтгэлтэй болохыг чинь хүлээхгүй. Хүнийг сайн уу, муу юу гэдгийг шалгахдаа тэр хүний сэтгэл санааны бэлтгэлгүй байхад туршиж үзэж мэднэ.

Сурагч: Фалунь Гон-ы Үнэн, Нинжин, Тэвчээрийн Тэвчээр нь бүх зүйлийг зөв буруу байсан ч тэвч гэсэн үг үү?

Багш: Миний ярьсан Тэвчээр бол чиний хувийн эрх ашигтай хамаатай зүйл, чи зууралдаад салж чаддаггүй эдгээр зүйл дээр зан чанараа дээшлүүлэхийг хэлсэн.

Үнэндээ Тэвчээр бол муугүй зүйл, энгийн хүний хувьд бас адил. Би нэг түүх ярья, цэргийн өрлөг жанжин Хан Шин залуудаа ушу-гаар хичээллэдэг байсан. Тэр үед ушу-гаар хичээллэдэг хүмүүс сэлэм зүүж явдаг байсан. Нэг удаа Хан Шин гудамжаар явж байхад нэг танхай эр зам дээр нь хааж зогсоод "Чи сэлэм зүүж явж яах гэсэн юм? Чи хүн алж зүрхлэх юмуу? чаддаг юм бол миний толгойг авчих" гээд хүзүүгээ сунгаж өгөөд зүрхлэхгүй бол миний салтаан доогуур мөлхөж гар гэсэн. Хан Шин тэгээд салтаан доогуур нь мөлхөж гарсан. Тэр үнэхээр тэвчээрээ барьж чаддаг байсан. Зарим хүн тэвчээртэй байх нь сул тал, тийм байвал энд тэнд амархан дээрэлхүүлнэ гэдэг. Тэвчээрээ барьж чаддаг хүн бол үнэндээ сэтгэлийн их тэнхээтэй хүн. Зөв буруу зүйлийг цэгнэхдээ орчлон ертөнцийн мөн чанарт нийцэж байгаа эсэхийг хар. Зарим хэрэгт чи өөрийгээ буруугүй гэж бодож болно, бусад хүмүүс чамайг уурлуулсан гэнэ, үнэндээ чи учрыг нь мэдэхгүй. Чи нэг жоохон зүйлээс л болсон гэнэ. Харин миний хэлж байгаа бол өөр зарчим, тэр бидний энэ материаллаг орон зайд харагдахгүй. Зүгээр хошигнож хэлэхэд чи магадгүй урд насандаа бусдад өртэй байсан, тийм бол чи үүний зөв бурууг хэлж чадах уу? Тэгэхээр бид тэвчээртэй байх ёстой. Чи эхлээд бусдыг уурлуулаад дараа нь тэвчиж болох уу? Чамайг уурлуулсан хүнд чи тэвчээртэй байгаад зогсохгүй бас талархах хэрэгтэй. Жишээ нь хэн нэгэн чамайг загнасан бас багшид ховлосон. Тэгсэн ч чи түүнд сэтгэлээсээ баярлах хэрэгтэй. Чи өөрийгээ А-Кю тай адил болж байна уу гэж бодож магад. Энэ бол чиний бодол. Чи түүнд буцаагаад адилхан хандаагүй бол чиний зан чанар дээшилсэн гэсэн үг. Тэр энэ материаллаг орон зайд чамайг чадсан, гэхдээ өөр орон зайд чамд юм өгсөн биш үү? Чиний зан чанар дээшилж хар бие бодь хувирсан. Чи гурав дахин илүү олсон. Яагаад түүнд талархахгүй гэж? Үүнийг энгийн хүний үзлээр ойлгоход хэцүү, гэхдээ би энгийн хүнд биш бясалгагч хүнд ярьж байна.

Сурагч: Шүглэсэн сүнсгүй хүн зан чанараа дээшлүүлж үүнээс зайлж чадна, харин сүнс шүглэсэн хүн яаж үүнээс салах вэ?

Багш: Нэг зөв бодол зуун ёрыг дарна. Чи өнөөдөр аугаа номыг гардаж авлаа, одооноос эхлээд шингэсэн сүнс чамд ашиг тус үзүүлсэн ч битгий хүлээж ав. Тэр чамд мөнгө, алдар нэр, олз омог авчрахад чи сэтгэлдээ баяртай, би ямар байна хардаа гэнэ, бусдын өмнө гайхуулна. Чиний бие тааруухан болоход тэдгээр зүйлтэй амьдрахыг хүсэхгүй эмчлүүлэхээр багшийг хайна. Чи түүний өгсөн ашиг тусыг яагаад авсан юм? Тэгвэл бид чиний асуудлыг хариуцаж чадахгүй, яагаад гэвэл чи түүний өгсөн болгоныг нь хүлээж авсан. Чи зөвхөн олохыг хүсээд байвал энэ бүтэхгүй. Чи түүнээс юу ч хүсэхгүй байх хэрэгтэй, сайн зүйл байсан ч битгий ав, зөвхөн багшийнхаа заасан бясалгалын аргаар яв. Чи өөрийгээ зөв удирдвал, бодол чинь тууштай бол тэр дагжин чичрэнэ, тэр чамд сайн зүйл өгөх гэсэн ч авахгүй бол тэр яваад өгнө. Хэрэв тэр чамаас явахгүй бол муу зүйл хийж байна, би оролцож шийднэ. Гараар нэг даллахад тэр ор сураггүй алга болно. Харин чи өгсөн зүйлийг нь аваад байвал болохгүй болно.

Сурагч: Гадаа паркад хичээллэвэл сүнс шүгэлж болох уу?

Багш: Би олон удаа хэлсэн, бид ариун замаар бясалгадаг, нэг зөв бодол зуун ёрыг дарна! Ариун бясалгалд сэтгэл ариун, юу ч чам дээр гарч чадахгүй. Фалунь гайхалтай, чамд ямар ч муу ёрын зүйлс халдаж чадахгүйгээс гадна чиний ойр байхаасаа айна. Чи үүнд итгэхгүй бол өөр газар хичээллэж болно, тэд бүгд чамаас эмээнэ. Хэрэв би хичнээн их шүглэсэн сүнс байгааг хэлбэл та бүхэн айна, маш олон хүнд шүглэсэн сүнс байгаа. Тэдгээр хүмүүс өвчнөө эдгээх биеэ сайжруулах зорилгондоо хүрээд цааш үргэлжлүүлэн бясалгана, өөр юу авахыг хүсч байна? Бодол ариун биш бол тэдгээр зүйлс гай авчирна. Тэд зарчмыг мэдэхгүй учраас бид буруутгах хэрэггүй. Миний нийтэд гарсан нэг зорилго бол эдгээр буруу зүйлсийг засахад туслах явдал юм.

Сурагч: Ямар ер бусын чадвар ирээдүйд гарах вэ?

Багш: Би энэ талаар ярихыг хүсэхгүй байна. Хүн болгонд өөрийн нөхцөл байдаг болохоор хэлэхэд хэцүү. Өөр өөр чадвар өөр өөр түвшинд гарна. Хамгийн чухал нь түвшин бүрд чиний зан чанар ямар байхаас шалтгаална. Нэг хэлбэрийн зууралдсан сэтгэлээ орхивол түүнд таарсан ер бусын чадвар гарна. Гэхдээ тэр чадвар эхэн шатных юм, тийм хүчтэй биш. Чиний зан чанар их өндөр түвшинд хүрээгүй байхад тийм их чадвартай болгохгүй. Манай ангид зарим хүний суурь их сайн, заримд нь бороонд норохгүй алхах Бурхан хөл чадвар гарсан, зарим нь юмыг зайнаас хөдөлгөх чадвар гарсан.

Сурагч: Зан чанараа бясалгах, бүх зууралдсан сэтгэлээ орхих гэдэг нь Буддынхаар хоосон чанарт, Дао-гийнхаар үл оршихуйд хүрэх гэсэн үг үү?

Багш: Бидний ярьдаг зан чанар, эсвэл буян бүгд Буддын хоосон чанарт, Дао-гийн үл оршихуйд багтдаггүй. Харин Буддын хоосон чанар, Дао-гийн үл оршихуй манай зан чанарт багтдаг.

Сурагч: Будда үргэлж Будда-гаараа байх уу?

Багш: Чи Дао-д хүрсний дараа, гэгээрлийн хутагт хүрсний дараа чи аугаа гэгээрэгч, дээд түвшний амь бодь. Гэхдээ чамд үүрд буруу хазайхгүй гэсэн баталгаа байхгүй. Мэдээж чи тэр түвшинд ер нь буруу зүйл хийхгүй, яагаад гэвэл чи үнэнийг харж байгаа. Хэрэв буруу зүйл хийвэл бас адилхан доош унана, үргэлж сайн зүйл хийвэл тэндээ үүрд үлдэнэ.

Сурагч: Аугаа суурьтай хүн гэж ямар хүнийг хэлэх вэ?

Багш: Тодорхойлох зүйл нь нэгдүгээрт: төрөлхийн сайн суурь, хоёрт: ухамсар сайн, гуравдугаарт: тэвчээр сайн, дөрөвдүгээрт: их зууралдсан сэтгэлгүй, энгийн хүний зүйлийг хөнгөн хардаг. Үүнийг аугаа суурьтай гэдэг. Ийм хүнийг олоход хэцүү.

Сурагч: Сайн суурьтай биш хүн Фалунь Гон-оор хичээллээд гон гаргаж чадах уу?

Багш: Сайн суурьгүй хүн гон гаргаж чадна, хүн болгонд тодорхой хэмжээний буян байдаг. Огт буянгүй байх аргагүй, ийм хүн гэж байхгүй. Чамд цагаан бие бодь байхгүй ч гэсэн хар бие бодь байна, бясалгалаар энэ нь цагаан бие бодид хувирч болно, нэг илүү шат гэсэн үг. Бясалгах явцдаа хүнд бэрхшээлийг тэвчвэл, зан чанар чинь сайжирвал, өөрийгээ зориулбал чамд гон өснө. Бясалгал бол урьдчилсан нөхцөл, энэ нь багшийн Номын биес үүнийг гон-д хувиргаж өгдөг.

Сурагч: Хүн төрөхөд түүний бүхэл амьдрал төлөвлөгдсөн байдаг. Зүтгэж ажиллах нь өөрчлөлт өгөх үү?

Багш: Мэдээж тэгнэ, чиний зүтгэж ажиллах бас төлөвлөгдсөн байдаг, зүтгэж ажиллахаас өөр аргагүй, чи энгийн хүн, том зүйлийг өөрчилж чадахгүй.

Сурагч: Тэнгэрийн мэлмий нээгдээгүй байхад хүлээж авсан мэдээллийн сайн мууг яаж мэдэх вэ?

Багш: Өөрөө ялгахад хэцүү, чиний бясалгалын замд зан чанарын сорилт болгож олон төвөгтэй зүйл тавигддаг. Номын биений хамгаалалт бол чамд амь насны аюул гаргуулахгүйн тулд юм. Гэхдээ чиний өөрөө давах ёстой, шийдвэрлэх ёстой, ухамсарлах ёстой зарим асуудалд оролцохгүй байж болно. Зарим үед муу мэдээллүүд ирнэ, хонжворт сугалааны тохирлын дугаарыг хэлэх гэх мэт, магадгүй тэр дугаар нь таарна эсвэл таарахгүй байж мэднэ, эсвэл зарим өөр зүйлийг хэлнэ, чамайг энэ бүгдэд яаж хандахыг чинь харна. Чиний сэтгэл зөв байхад буг чөтгөр халдаж чадахгүй, зан чанараа сайн барьж байхад ямар ч асуудал гарахгүй.

Сурагч: Сэтгэл санаагаар унасан үедээ дасгалаа хийж болох уу?

Багш: Чиний санаа сэтгэл таагүй байхад суугаад амгаланд орох хэцүү, бодолд чинь муу зүйлс замбараагүй гүйлдэнэ. Бид дасгал хийхэд мэдээлэл орж ирдэг, муу бодол толгойд чинь байхад дасгал хийхэд тэдгээр нь орж ирнэ чи тэгээд буруу номоор бясалгачихна. Чиний хийдэг дасгалыг нэртэй багш, их багш эсвэл Тантрын амьд Будда заасан байсан ч чи тэдний зан чанарын хатуу шаардлагыг дагахгүй бол чамд тэд хэдий заасан ч гэсэн хийсэн дасгал чинь тэднийх биш болно. Та бүгд боддоо, жишээ нь багана зогсолт дасгал хийж ядарсан ч толгой чинь завгүй бодно, "Манай ажлын тэр, тэр их зэвүүн, яагаад намайг муулсан бэ?", "Цалингаа яаж нэмэгдүүлэх вэ?" эсвэл "Юмны үнэ өсч байна, одоо ахиухан олж авсан нь дээр" ингэж хийвэл чи өөрөө зохиомлоор санаандгүйгээр буруу номоор хичээллэж байгаа биш үү? Тэгэхээр сэтгэл санаа чинь тааруухан үед дасгалаа хийхгүй байсан нь дээр.

Сурагч: Туйлын өндөр зан чанар гэдгийн шалгуур юу вэ?

Багш: Зан чанарыг бясалгадаг, тийм тогтсон шалгуур гэж байхгүй, чи өөрөө ухамсарлах хэрэгтэй. Хэрэв чи зан чанарт тавих шалгуур хүсвэл ингэж хий: Ямар нэгэн зүйл чамд тохиолдоход гэгээрсэн хүн ийм хэрэгт яаж хандах байсан бол гэж бодоод үз. Гарамгай хүмүүс мэдээж гайхамшигтай, гэхдээ тэд зөвхөн энгийн хүмүүст л үлгэр жишээ.

Сурагч: Бид чигон багш болгоны ярьсан бүрийг сэжигтэй харж хэрэггүй, гэхдээ мөнгөний төлөө луйварчин байвал яахав?

Багш: Магадгүй чи үүнтэй учрахгүй. Чи эхлээд тэдний юу ярьж байгааг нь хар тэгээд луйварчин уу үгүй юу гэдгийг өөрөө ялга. Чигон багшийн сайн мууг нь түүний зан чанараас хар. Зан чанар хэр өндөр байна гон тийм өндөр.

Сурагч: Яаж нүглийг арилгах вэ? Буддын шашинд ярьдагаар үйлийн үрээ төлөх гэдэг.

Багш: Бясалгал бол нүглийг арилгах хэлбэр, өөрийн зан чанараа дээшлүүлэх хамгийн сайн арга, үүний дүнд хар бие бодь цагаан бие бодь, буян болж хувирч болно, тэгээд буян гон болж хувирна.

Сурагч: Фалунь Гон-оор хичээллэхэд ямар хориг цээр байдаг вэ?

Багш: Буддын шашинд хорьдог зүйлүүдийг бид бас ихэнхийг нь адилхан хорино, гэхдээ бидний ойлголт бол өөр. Бид лам хувраг, хандмаа биш энгийн хүмүүсийн дунд амьдардаг, тиймээс өөр. Зарим зүйлийг хөнгөн авч үзэхэд л хангалттай. Чиний гон хүч өсөхийн сацуу чи маш өндөр түвшинд хүрнэ, тэр түвшинд шаардагдах зан чанар адилхан маш өндөр.

4. Тэнгэрийн мэлмий

Сурагч: Би багшийг Ном ярьж байхад толгой дээр нь нэг метр алтан шаргал хүрээ, ард нь толгойн хэмжээтэй олон алтан шаргал хүрээнүүд байхыг харсан.

Багш: Энэ хүний тэнгэрийн мэлмий өндөр түвшинд хүрсэн байна.

Сурагч: Багшийн шавь, хүний өвчнийг эдгээж өгөхдөө амаараа вино тургиж байсан, тэгэхэд алтан туяа цацарч байсан, тэр юу вэ?

Багш: Би энэ хүнийг нилээд сайн бясалгасан байна гэж хэлнэ, тэр гаргаж байгаа чадварыг харсан байна.

Сурагч: Хүүхдийн тэнгэрийн мэлмий нээгдвэл түүнд ямар нэгэн байдлаар нөлөөлөх үү? Нээгдсэн тэнгэрийн мэлмийгээр нь энерги урсан гарах уу?

Багш: Зургаа хүртэлх насны хүүхдийн Тэнгэрийн мэлмий нээгдэх нь амархан. Хүүхдийн тэнгэрийн мэлмий нээгдээд дасгал хийхгүй бол энерги алдагдана, гэхдээ гэр бүлийн хэн нэг нь бясалгадаг байх хэрэгтэй. Түүнийг өдөрт нэг л удаа

харуулж байх хэрэгтэй, энэ нь Тэнгэрийн мэлмий хаагдахаас сэргийлнэ бас хэтэрхий их энерги алдуулахгүй. Хүүхдийг өөрийг нь бясалгуулах нь хамгийн дээр. Тэд тэнгэрийн мэлмийгээ их хэрэглэх тусам улам их энерги алдана, энэ нь бодит биед нөлөөгүй ч хамгийн үндсэн зүйлд нь нөлөөлнө, харин түүнийг сайн хадгалж байвал нөлөө байхгүй. Миний сая ярьсан бол бага хүүхдэд хамаатай, том хүнд биш. Зарим хүний Тэнгэрийн мэлмий нээлттэй, тэд энерги алдагдахаас айдаггүй гэхдээ их дээд түвшний зүйлийг харж чаддаггүй. Зарим нь их дээд түвшнийг харж чаддаг, тэднийг юм харахад Номын бие эсвэл их багш энерги өгдөг, тиймээс ямар ч асуудалгүй.

Сурагч: Би багшийн бие болон сүүдэр дээр нь алтан цацраг туяа харсан, гэхдээ нүд ирмэх зуур бүгд алга болсон. Яагаад вэ?

Багш: Тэр бол миний Номын бие байсан. Би энд ярьж байхад миний толгойн оройд гон багана байдаг, тэр бол миний байгаа түвшин. Энэ нь нүд ирмэхэд алга болсон, яагаад гэвэл чи Тэнгэрийн мэлмийгээ яаж хэрэглэхээ мэддэггүй, чи махан нүдээрээ харчихсан.

Сурагч: Бид ер бусын чадвараа яаж хэрэглэх вэ?

Багш: Хэрэв чи энэ чадвараа цэргийн шинжилгээ туршилтанд, өндөр технологт, эсвэл тагнуулд хэрэглэх гэвэл ийм асуудал байдаг: Бидний орчлон ертөнц мөн чанартай, үүнд зохицсон бол тэр чадвар үйлчилнэ, үгүй бол үйлчлэхгүй. Тийм чадвартай хүнийг сайн зүйл хийлгэх гэсэн ч дээд түвшний зүйлд нөлөөлж чадахгүй. Түүний хийж чадах нь зөвхөн мэдрэмж төдий л зүйл юм. Тэр хүн бага чадвар хэрэглэвэл нийгмийн хэвийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж чадахгүй. Харин тодорхой зүйлийг өөрчлөхийг хүсвэл, үнэхээр том зүйл хийнэ гэвэл түүний ярьснаар болохгүй, яагаад гэвэл нийгмийн хөгжил хүний хүслээр өөрчлөгдөхгүй. Тэр ямар нэг зүйлд хүрэх хүсэлтэй байсан ч эцсийн шийдвэр түүнийхээр болохгүй.

Сурагч: Хүний бодол биений хаагуур орж гарч байдаг вэ?

Багш: Бидний ярьж байгаа бодол гол төлөв толгойн оройгоор гардаг, гэхдээ мэдээж үүгээр хязгаарлагдахгүй аль ч сүвээр гарч болно. Зарим бясалгалд хэлдэг шиг зөвхөн толгойн оройгоор гардаг биш, биеийн аль ч хэсгээр гарч болно. Биенд орохдоо бас мөн адил.

Сурагч: Тэнгэрийн мэлмий байгаа газарт улаан туяа, голд нь хар нүх харагдах юм. Дараа нь үе үеэрээ хурдан дэлбээлэх юм. Энэ нь миний Тэнгэрийн мэлмий нээгдэж байна уу? Заримдаа оддын гэрэл, цахилгаан үзэгдэх юм.

Багш: Чамд одны гэрэл үзэгдвэл Тэнгэрийн мэлмий нээгдэх ойлгосных, цахилгаан үзэгдвэл бараг бүрэн нээгдсэнийх.

Сурагч: Би багшийн толгой, биен дээр нь улаан, ногоон өнгөөр туяарсан хүрээ байхыг харсан, нүдээ анихад юу ч харагдахгүй болсон. Би гадны нүдээр харсан уу?

Багш: Чи гадны нүдээр хараагүй, чи нүдээ аниад харж сураагүй учраас зөвхөн нүдээ нээлттэй байхад хардаг. Ер нь хүмүүс аль хэдийн нээгдчихсэн Тэнгэрийн мэлмийгээ яаж хэрэглэхээ мэддэггүй, заримдаа нүдээ нээлттэй байхад санаандгүй юм хардаг, тэгээд улам сайн харах гэхдээ энгийн нүдээрээ харж тэр нь алга болдог. Чамайг санаандгүй байхад дахиад харагддаг.

Сурагч: Манай охин ямар нэг дугуй тэнгэрт байхыг хардаг, гэхдээ тодорхой хэлж чаддаггүй. Бид түүнд Фалуний эмблемийг харуулахад яг харсан нь мөн байна гэсэн. Түүний Тэнгэрийн мэлмий үнэхээр нээгдсэн үү?

Багш: Зургаагаас бага насны хүүхэд Фалуний эмблемийг нэг хараад л Тэнгэрийн мэлмий нь нээгдэж болно, гэхдээ чи үүнийг зориудаар битгий хий, хүүхэд харж чаддаг.

Сурагч: Би нээгдсэн Тэнгэрийн мэлмийгээ яаж хэрэглэхээ мэдэхгүй байна. Багшаа та тайлбарлаж өгөөч?

Багш: Тэнгэрийн мэлмий бүрэн нээгдэхэд чи яаж хэрэглэхээ мэддэггүй байсан ч мэддэг болно, Тэнгэрийн мэлмийгээр харах нь санаатайгаар болдоггүй, чи улам нарийн харахыг хүсэхэд мэдэлгүйгээр энгийн нүдлүүгээ шилжиж харааны судлаа хэрэглэдэг, тэгээд юм харагдахаа больдог.

Сурагч: Тэнгэрийн мэлмий нээгдэхэд бид орчлон ертөнцийг бүхэлд нь харж чаддаг болох уу?

Багш: Тэнгэрийн мэлмий нээгдэх түвшингүүд байдаг. Өөрөөр хэлбэл хэр сайн үнэн байдлыг харах нь чиний түвшингээс шалтгаална. Тэнгэрийн мэлмий нээгдэхэд чи орчлон ертөнц дэх бүх зүйлсийг хардаг болно гэсэн үг биш. Гэхдээ бясалгалаар яваандаа чиний түвшин ахина, гэгээрлийн хутагт хүртэл ахина. Тэр үед илүү олон түвшинг хардаг болно, тэглээ ч гэсэн чамд бүхэл орчлон ертөнцийн үнэнг хардаг болно гэсэн баталгаа байхгүй. Урьд Шагжамүни амьдарч байхдаа түвшингээ байнга дээшлүүлж байсан, шинэ түвшинд хүрэх болгондоо урьд заасныгаа харахад тодорхой бус байсан. Дараагийн түвшинд ахих тутамд өөрчлөгдөж байсан, тиймээс эцэст нь хэлсэн: "Тодорхой хэлэх Ном гэж байхгүй". Түвшин болгонд өөр Ном байдаг. Түүнд хүртэл бүхэл орчлон ертөнцийн үнэнийг мэдэх боломж байгаагүй. Ердийн хүнд Рулай түвшин хүртэл энэ дэлхийд бясалгана гэдэг төсөөлөхийн аргагүй, тэд зөвхөн Рулай түвшинг л мэднэ, үүнээс дээш түвшингүүд байдгийг мэдэхгүй, үүнээс дээдэх зүйлсийг мэдэхгүй учраас хүлээн зөвшөөрдөггүй. Рулай түвшин бол Буддын номонд бага түвшин. Тиймээс Аугаа Ном хязгааргүй гэж хэлдэг.

Сурагч: Таны бие дээр харагддаг зүйлс үнэхээр оршдог уу?

Багш: Мэдээж үнэхээр оршдог, бүх орон зай матери бие бодиос тогтдог. Зөвхөн тэдгээрийн бүтэц нь биднийхээс өөр.

Сурагч: Миний ирээдүйн тухай зөн совин ихэнхдээ үнэн болдог.

Багш: Энэ бол урьдчилан мэдэх чадвар, бидний ярьсан зүйл. Энэ бол үнэндээ хувь тавиланг мэдэх чадлын доод түвшин. Бидний гон бясалгадаг орон зайд цаг, хэмжээний ухагдахуун гэж байхгүй, энэ нь хэр хол зай байх эсвэл хэр удаан хугацаа байх нь хамаагүй, адилхан.

Сурагч: Дасгал хийж байхад яагаад өнгийн хүмүүс, өнгийн тэнгэр, янз бүрийн дүрснүүд харагддаг вэ?

Багш: Чиний Тэнгэрийн мэлмий нээгдсэн. Чиний харсан нь өөр орон зайн зүйлс, тэр орон зай олон давхаргатай, чи түүний аль нэг давхаргыг харсан байна. Тийм үзэсгэлэнтэй сайхан.

Сурагч: Би дасгал хийж байхдаа чанга дуу гарахыг сонссон, миний бие хагарч онгойх шиг болсон. Би гэнэт олон зүйлсийг ойлгосон, яагаад тэр вэ?

Багш: Зарим хүнд ийм байдал гардаг, биений зарим хэсэг дэлбэрч онгойдог. Чи зарим талаар гэгээрэлд хүрсэн, энэ нь аажим гэгээрэлд харъяалагддаг. Чиний бясалгалын нэг түвшин дуусахад нэг хэсэг нь дэлбэрч онгойдог. Энэ бол зүгээр хэвийн.

Сурагч: Заримдаа би хөдөлж чадахгүй болох юм. Яагаад вэ?

Багш: Бясалгалын эхэн үед заримдаа чи гараа юмуу эсвэл биенийхээ зарим хэсгийг хөдөлгөж чадахгүй болж мэднэ. Яагаад вэ? Яагаад гэвэл чамд хөшөөх гон чадвар гарсан. Энэ бол чиний нэг төрөлхийн чадвар, их хүчирхэг. Хэн нэгэн муу зүйл хийгээд зугтах гэвэл чи "хөш" гээд хэл, тэгвэл тэр дороо хөшингө болно.

Сурагч: Хэзээ хүн эмчилж эхэлж болох вэ? Би урьд нь хүн эмчилдэг байсан, үр дүн гардаг байсан. Фалунь Гон-оор бясалгаж эхэлсний дараа хүн ирж үзүүлбэл эмчилж өгч болох уу?

Багш: Энэ ангид суугаа та нарын хувьд ямар янзын дасгалаар хичээллэж байсан, түүгээр хэр удаан хичээллэсэн, хүн эмчлэх түвшин-доод түвшинд хүрсэн байсан ч би та нарыг өвчин эдгээхийг хүсэхгүй байна, чи өөрийгээ ямар байдалд хүрснээ ч мэдэхгүй байгаа. Урьд нь чи зарим хүнийг эмчилж чаддаг байсан бол магадгүй чиний ариун бодол нөлөөлсөн байх, эсвэл хажуугаар чинь өнгөрсөн багш чамайг сайн санааны үйл хийж байгаа болохоор тусалсан байж болно. Гэхдээ бясалгалаар гарсан энерги чинь зарим зүйл хийхэд тусална, гэхдээ чамайг хамгаалж чадахгүй. Чи хэн нэгнийг эмчлэхэд түүнтэй нэг оронгоор холбогддог. Аажмаар өвчтөний хар чий чамайг түүнээс илүү өвчтэй болгоно. Эдгэрсэн үү? гэж өвчтөнөөс асуувал тэр, арай дээр болсон гэнэ. Энэ ямар янзын эмчилгээ вэ? Зарим чигон багш "Маргааш бас нөгөөдөр дахиад хүрээд ир. Бид хэдэн курс эмчилгээ хийнэ" гэдэг, давтан хийдэг. Энэ нь хуурч байгаа биш үү? Чи дээд түвшинд хүртлээ эмчилгээ хийхгүй хүлээвэл сайн биш үү? Чиний эмчилсэн болгон эдгэрнэ, ямар сайхан хэрэг вэ? Чамд тийм доод түвшинд биш гон гарвал, чамд эмчилгээ хийх зайлшгүй шаардлага байвал би чиний гарын түгжээг онгойлгож чиний эдгээх чадварыг гаргана. Гэхдээ дээд түвшинд бясалгаж байгаа бол тийм зүйлээс хол байх нь дээр гэж би хэлнэ. Миний зарим шавь нар эмчилгээ хийдэг, энэ нь Дафа-г сурталчлахын тулд зарим нийгэмлэгийн арга хэмжээнд оролцдог. Тэд миний хажууд хийдэг, би тэднийг дадлагажуулсан, тиймээс тэд хамгаалагдсан, асуудал гарахгүй.

Сурагч: Ер бусын чадвартай болбол бусдад хэлж болох уу?

Багш: Фалунь Гон-оор бясалгадаг хүнд даруухан хэлэхэд асуудалгүй, та бүхнийг хамтдаа хичээллэ, дасгалаа цуг хий гэдгийн учир нь хоорондоо туршлагаа хуваалц санал бодлоо солилц гэж байгаа юм. Гадны ер бусын чадвартай хүнтэй уулзвал мэдээж хэлж болно, өөрийгээ гайхуулаагүй л бол хэлэхэд асуудалгүй. Харин өөрийнхээ чадвараар гайхуулахыг хүсвэл асуудал гарна, удаан гайхуулбал чадвар

чинь алга болно. Чигон үзэгдлийн талаар зүгээр ярилцах, хэлэлцэхийг хүсвэл, буруу санаа бодолгүй бол асуудалгүй гэж би бодож байна.

Сурагч: Буддын системд хоосон чанарын талаар ярьдаг, Дао системд үл оршихуйн талаар ярьдаг, бид юу ярих вэ?

Багш: Буддын системд ярьдаг хоосон чанар, Дао системд ярьдаг үл оршихуй бол бясалгалын онцлог арга. Мэдээж бид бас тэр түвшинд хүрэх ёстой. Бид бясалгах хүслийг ярьдаг, гон-ыг хүсэхгүйгээр өсгөнө, зан чанараа бясалгана, зууралдсан сэтгэлээ орхино, эцсийн дүн нь хоосон, юу ч үгүйтэй адилхан. Гэхдээ бид тэдгээрийг онцлон авч үздэггүй, яагаад гэвэл чи материаллаг орчлонд амьдардаг, та нарт амьдрах орлогоо олох, мэргэжилтэй байх, ямар нэгэн зүйл хийх хэрэгтэй. Чи юу ч хийсэн, хийж байгаа зүйл чинь сайн уу, муу юу гэсэн асуулт аяндаа гарч ирдэг. Тэгвэл яах вэ? Бид бясалгадаг нь зан чанар, энэ бол манай аргын хамгийн давуу онцлог. Чиний бодол ариун, хийж байгаа зүйл чинь манай шаардлаганд нийцэж байвал зан чанарын асуудал гарахгүй.

Сурагч: Ер бусын чадвараа нэмэгдэж байгааг яаж мэдрэх вэ?

Багш: Бясалгалын эхний шатанд чадвар гарвал чи мэдрэх болно. Хэрэв чамд тийм чадвар хараахан гараагүй ч чиний бие их мэдрэмтгий бол мэдэрч бас болно. Аль ч тохиолдол нь биш бол хэлэх ямар ч арга байхгүй. Зөвхөн мэдрэхгүйгээр бясалгалаа үргэлжлүүлэн хийхээс өөр арга байхгүй. Манай сурагчдын 60-70% нь Тэнгэрийн мэлмий нээгдсэн, тэдний харж чаддагийг би мэднэ. Гэхдээ тэд юу ч хэлдэггүй, нүдээ том болгон юмсыг ажигладаг. Би яагаад та нарыг хамтдаа дасгалаа хий гэдэг вэ? Би та нарыг хоорондоо туршлагаа хуваалцах, ярилцаж байхыг хүсч байна. Харин бясалгалдаа хариуцлагатай хандах үүднээс өөрсдийн хүрээнээс гадуур хамаагүй ярьж болохгүй. Өөрсдөө хоорондоо хуваалцах хамт ахихын тулд бол болно.

Сурагч: Номын бие ямар харагддаг вэ? Надад Номын биес бий юу?

Багш: Хүний Номын бие тэр хүнтэйгээ яг адилхан. Чамд одоо Номын биес байхгүй. Чиний бясалгал тодорхой түвшинд хүрч Гурамсан ертөнцийн номын бясалгалыг дүүргэхэд маш өндөр түвшинд хүрнэ. Тэр цагт л Номын биес гарна.

Сурагч: Энэ ангийг төгссөний дараа Багшийн Номын биес хэр удаан бидэнтэй хамт байх вэ?

Багш: Сурагч гэнэт дээд түвшний зүйлсийг бясалгаж эхлэхэд түүнд том эргэлт гардаг. Би түүний бодолд гарах өөрчлөлтийг хэлээгүй, тэр хүнд бүхэлд нь гарах өөрчлөлтийг хэлж байна. Энгийн хүний олсон зүйл энгийн хүнд байх ёсгүй зүйл байвал түүнд аюултай, амь насанд нь аюул гарна. Миний Номын бие түүнийг хамгаалах ёстой, би тэгж чадахгүй байж Ном тараавал хүн хорлосонтой адил болно. Олон чигон багш бясалгал заахаас, үүнийг хийхээс айдаг, учир нь энэ хариуцлагыг хүлээж чадахгүй. Миний Номын биес чамайг эхнээс нь авхуулаад төгс гэгээрэлд хүртэл чинь хамгаална. Хэрэв чи замын дундаас бясалгахаа больчихвол Номын биес өөрсдөө яваад өгнө.

Сурагч: Багш хэлэхдээ, ердийн суурьтай хүмүүсийн бясалгал, дасгалаас биш харин зан чанараа бясалгахаас шалтгаалдаг гэсэн. Хүний зан чанар өндөр бол хүрэх дээд түвшиндээ дасгал хийхгүйгээр хүрч чадна гэсэн үг үү?

Багш: Онолын хувьд тэр зөв. Чи зан чанараа бясалгаж л байвал буян гон болж хувирна. Чи өөртөө бясалгагч хүн гэж хандах хэрэгтэй, тэгэхгүй бол үргэлжлэн зөвхөн буян хураана. Чи магадгүй их буян хураана. Зөвхөн сайн хүн байж буян хураавал, чи өөрийгээ бясалгагч гэж тооцсон ч дээд түвшний Ном олж аваагүй учраас цааш ахихгүй. Чи миний олон зүйлсийн нууцыг задалсныг мэднэ, Багшийн хамгаалалтгүйгээр дээд түвшинд бясалгах хэцүү. Чи дээд

түвшинд нэг ч өдөр бясалгаж чадахгүй, тиймээс гэгээрлийн хутагт хүрэх амаргүй. Чиний зан чанар дээшлэхэд орчлон ертөнцийн мөн чанартай ижилсэж чадна.

Сурагч: Алсаас эдгээхийн зарчим юу вэ?

Багш: Энэ бол амархан. Орчлон ертөнц агшиж, тэлж чаддаг, мөн ер бусын чадвар бас адилхан. Би эхний газраа байгаад хөдлөхгүй, гэхдээ гаргасан чадвар жишээ нь Америкт, хол байгаа өвчтөнд хүрч чадна. Хүнийг эдгээхдээ би чадвараа түүний байгаа газар луу явуулна, эсвэл түүний сүнснийг шууд энд авчирна. Алсаас эдгээх ингэж явагддаг.

Сурагч: Хичнээн төрлийн ер бусын чадвартай болсноо яаж мэдэх вэ?

Багш: Арван мянга гаруй төрлийн чадвар байдаг, яг хичнээн төрөл байдгийг мэдэх нь чухал биш. Тийм зарчим, Ном байдгийг мэдэхэд л хангалттай. Бусдыг нь чамайг бясалгахад үлдээж байна. Хэтэрхий ихийг мэдэх нь шаардлагагүй бөгөөд чамд сайн болохгүй. Багш шавийг хайдаг, хүлээж авдаг, шавь үүнийг юу ч мэдэхгүй, түүнд юу ч хэлэхгүй. Бүгд түүний ухамсарлаж ойлгохоос болно.

5. Хүнд бэрхшээл

Сурагч: Багшийн бидэнд бэлдсэн хүнд бэрхшээл, сорилт уу?

Багш: Тэгж хэлж болно, тэдгээр нь чиний зан чанарыг дээшлүүлэхийн тулд төлөвлөгдсөн. Жишээ нь чиний зан чанар тэр түвшний шаардлаганд хүрэхгүй бол чамайг дээшлүүлж болох уу? Бага ангийн сурагчийг дээд сургуульд элсүүлж болох уу? Миний бодоход, тэгж болохгүй! Хэрэв чиний зан чанар үнэхээр дээшлээгүй, юуг ч хөнгөн авч үзэж чадахгүй, юунаас ч татгалзаж чадахгүй байхад чамайг дээд түвшинд аваачвал гэгээрэгчидтэй үл ялих зүйлээс болж

маргалдана. Үүнийг зөвшөөрөхгүй! Тиймээс бид зан чанарт их анхаарал тавьдаг.

Сурагч: Бясалгагчид тохиолдох хүнд бэрхшээл, энгийн хүний туулдаг зовлон бэрхшээлээс ямар ялгаатай вэ?

Багш: Тийм их ялгаа байхгүй. Бэрхшээл зовлон бясалгагч хүний хувьд бол бясалгалын замд төлөвлөгдсөн, энгийн хүний хувьд бол нүглээ төлөхөд юм, бүгд бэрхшээл зовлонтой. Чи бясалгагч байвал хүнд бэрхшээл зовлонгоос чөлөөлөгдөнө, энгийн хүн бол тэгэхгүй гэсэн үг биш, хоёр тохиолдолд адилхан. Чиний зовлон бэрхшээл бол зан чанарыг чинь дээшлүүлэхэд зориулагдсан, түүнийх бол үйлийн өрөө төлөхөд зохицуулагдсан. Үнэн хэрэгтээ бэрхшээл зовлон бол өөрийн нүгэл, би түүнийг шавийнхаа зан чанарыг дээшлүүлэхэд ашигладаг.

Сурагч: Бэрхшээл зовлон нь Буддын судар олохоор Баруун зүгт аялсан дээр гардаг наян нэгэн бэрхшээл зовлонтой адилхан уу?

Багш: Зарим талаараа адилхан. Бясалгагч хүний амьдрал урьдчилан төлөвлөгддөг, чамд хэтэрхий их юмуу эсвэл хэтэрхий бага бэрхшээл зовлон гэж байхгүй, наян нэг байх албагүй. Энэ нь чи суурь чанараараа хэр өндөр бясалгаж чадахаас хамаарна, чиний хүрч болох түвшин дагуу төлөвлөгдсөн байдаг. Бясалгагч хүн энгийн хүнд байдаг бүх зүйлийг, харин бясалгагчид байх ёсгүй бүхнийг орхих явцыг туулна. Энэ нь үнэхээр хэцүү. Бид чамайг орхиж чаддаггүй зүйлээсээ салж чаддаг болгох арга замыг олно, тэгээд чи хэцүү бэрхийг туулж зан чанараа дээшлүүлнэ.

Сурагч: Дасгалаа хийж байхад хүн муу зүйл хийх гэвэл яах вэ?

Багш: Фалунь Гон-оор хичээллэхэд бусад хүмүүс муу зүйл хийхээс айх хэрэггүй. Эхний шатанд чамайг миний Номын биес хамгаална, гэхдээ чамд юу ч тохиолдохгүй гэсэн үг биш. Чи өдөр бүр буйдан дээрээ суугаад цайгаа ууж байгаад

гон гаргана гэсэн үг биш. Заримдаа чи бэрх зовлонтой учраад миний нэрийг дуудахад чиний өмнө намайг байгааг хардаг, би туслахгүй байж магад, тэр хэцүү бэрхшээлийг чи давах ёстой. Гэхдээ чамд үнэхээр аюул тулгарвал би тусална. Жинхэнэ аюул ер нь тохиолдохгүй, яагаад гэвэл чиний зам өөрчлөгдсөн, гэнэтийн зүйл тохиолдохыг зөвшөөрөхгүй.

6. Орон зай ба Хүн төрөлхтөн

Сурагч: Орчлон ертөнцөд хичнээн түвшин байдаг вэ?

Багш: Миний мэдэхээр орчлон ертөнцийн давхарга тоологдошгүй. Өөр орон зайнуудын хувьд тэдгээрт юу оршдог, юу тэнд амьдардаг болохыг орчин үеийн шинжлэх ухааныг ашиглан мэдэхэд тун хэцүү, шинжлэх ухаан тэдгээрийг оршдогийг бодитоор нотолж чадахгүй. Харин зарим чигон багш, ер бусын чадвартай хүмүүс өөр орон зайг харж чаддаг. Яагаад гэвэл өөр орон зай зөвхөн Тэнгэрийн мэлмийд харагддаг, хүний махан нүдээр харж чадахгүй.

Сурагч: Орон зай болгонд Үнэн, Нинжин, Тэвчээр оршдог уу?

Багш: Гийм, орон зай болгонд Үнэн, Нинжин, Тэвчээр мөн чанар агуулагддаг. Энэ мөн чанарыг дагадаг хүн сайн хүн, үүнийг зөрчдөг хүн үнэхээр муу хүн. Үүнд ижилсэж чадсан хүн Дао-д хүрсэн хүн.

Сурагч: Анхны хүн төрөлхтөн хаанаас үүссэн бэ?

Багш: Анхдагч орчлон ертөнцөд ийм олон босоо, хэвтээ түвшингүүд байгаагүй, нэг хэлбэрийн цомхон байсан. Гэхдээ түүний хөгжил, хөдөлгөөний явцад амьдрал үүссэн. Бид үүнийг хамгийн анхны үндсэн амь гэдэг. Энэ нь орчлон ертөнцтэй нийцсэн ямар ч муу зүйл оршдоггүй байсан. Орчлон ертөнцтэй нийцсэн гэдэг нь үүнтэй адилхан

байсан, орчлон ертөнцөд байдаг чадварууд байсан. Орчлон ертөнцийн хөгжил, хувьслын дүнд зарим тэнгэрийн диваажингууд үүссэн. Сүүлд нь улам бүр олон амь бодь үүссэн. Манай доод түвшний хэллэгээр яривал нийгмийн давхарга үүссэн, хоорондын харьцаа үүссэн. Энэ хувьслын явцад зарим хүмүүс өөрчлөгдсөн, орчлон ертөнцийн мөн чанараас хазайж ирсэн. Тэд тийм сайн биш болж ер бусын чадвар нь буурсан. Тиймээс бясалгагчид үнэнд буцах гэж ярьдаг, энэ нь анхны байдалдаа буцах гэсэн үг. Түвшин өндөр байх тусам орчлон ертөнцтэй улам ижилссэн байдаг, увьдас чадвар нь хүчтэй гарна. Орчлон ертөнцийн хувьслын явцад зарим амь бодь муу болсон, гэхдээ тэднийг устгаж болохгүй. Тэгэхээр тэднийг өөрсдөөр нь дээшлүүлж орчлон ертөнцтэй буцаад ижилсүүлэх арга зам хэрэгтэй болсон. Тэднийг зарим бэрхшээл зовлон туулж өөрсдийгээ дээшлүүлэг гэж доод түвшин лүү явуулсан. Сүүлд хүмүүс тэр түвшин лүү ирсээр байх болсон, тэгээд тэр түвшин хуваагдсан. Зан чанар нь улам доройтсон хүмүүс тэр түвшинд үлдэж чадахгүй болсон, тиймээс тэр түвшин дахин хуваагдаж дараачийн доод түвшин бүтээгдсэн. Ингэж улам доод түвшин хуваагдаж гарсаар өнөөгийн хүн төрөлхтөн амьдарч байгаа энэ түвшин бүтээгдсэн. Энэ бол одоогийн хүн төрөлхтөний үүсэл.

* * *